

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ТӨСӨЛ (P118109) БОЛОН УУЛ УУРХАЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ (P145439)-ИЙГ
ХЯНАЛТЫН ХОРООГООР ХЯНУУЛАХ ХҮСЭЛТЭД УДИРДЛАГААС ӨГӨХ
ХАРИУ**

2015 оны 2-р сарын 10-нд Хяналтын хороо хүлээн авч, 2015 оны 3-р сарын 13-нд бүртгэсэн Монгол улсын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэмэлт санхүүжилт (P145439)-д хяналт шалгалт явуулах хүсэлт (RQ15/03)-ийг Удирдлага хянаж үзсэн болно. Удирдлагаас дараах хариуг бэлтгэсэн болно.

Агуулга

Товчилсон үгс.....	2
Гүйцэтгэх хураангуй.....	3
I. УДИРТГАЛ.....	7
II. ХҮСЭЛТ.....	7
III. ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	8
IV. УДИРДЛАГЫН ХАРИУ.....	15

Зураг

Зураг 1. IBRD/ОУСБХБNo.41575

Хавсралт

- Хавсралт1. Гомдол ба хариу
Хавсралт2. УУДБХОД дэд төслийн судалгаа (төлөвлөсөн ба гүйцэтгэсэн)
Хавсралт3. УУДБХОД олон нийтийн зөвлөгөөн

ТАЙЛБАР: Энэхүү орчуулга нь Англи эхээс нь орчуулсан. Ямарваа нэг зөрүүтэй илэрхийлэл байх аваас Англи эхийг баримтлана. Энэ баримт бичгийн Англи хувилбар нь цорын ганц албан ёсны хувилбар болно.

Товчилсон үгс

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ХНҮ	Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ
ГХХЯ	Гадаад хэрэг, худалдааны яам (Австрали улс)
БОННҮ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНУХ	Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УЦС	Усан цахилгаан станц
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
ОТХОББ	Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллага
УУДБХОД	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл
ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
МВ	Мегаватт
ТББ	Төрийн бус байгууллага
ОТ	Оюу толгой уурхай
ТҮББ	Төслийн үнэлгээний баримт бичиг
ТУБ	Төслийн удирдах баг
ТУХ	Төслийн удирдах хороо
ХХГМ	Хил хязгааргүй гол мөрөн
ГӨБДБС	Говийн өмнөд бүсийн дэд бүтцийн судалгаа
НБХ	Нүүрс хийжүүлэх
АД	Ажлын даалгавар
АХА	Ажлын хэсгийн ахлагч
ЮНЭСКО	Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
ДБ	Дэлхийн Банк
ДБГ	Дэлхийн Банк Групп

Хураангуй

i. *Хүсэлт гаргагчид нь Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (УУДБХОД)-ийн хүрээнд Банкнаас санхүүжүүлж буй үнэлгээний судалгаануудаас бус, харин санал болгож буй дэд төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаа мөн/эсвэл бүтэлгүйтлээс үүдэж болзошгүй хор хөнөөлд чиглэгдсэн асуудлууд дэвшүүлсэн тул Удирдлагын зүгээс УУДБХОД төсөлд хяналт шалгалт хийх хүсэлт нь шалгалт явуулах шаардлага хангаагүй гэж үзэж буй юм.* Удирдлага нь УУДБХОД төслийн хүрээнд судлагдаж буй санал болгосон дэд төслүүдийн барилгын ажлыг санхүүжүүлэхэд Банкны оролцоогүй, дэд төслүүдийн барилгын ажил огт эхлээгүй мөн Удирдлагын зүгээс тэдгээрийг санхүүжүүлэх талаар аливаа шийдвэр эсхүл амлалт өгөөгүйг тэмдэглэж буй юм.

ii. *Банк өөрийн Бодлого болон журмыг хэрэгжүүлж чадаагүйн улмаас Хүсэлт гаргагчдын эрх эсхүл сонирхолд шууд сөрөг нөлөө учраагүй, ирээдүйд учрахгүй гэж Удирдлага итгэж байна.* Банкнаас өөрийн Бодлого болон журмыг хэрэгжүүлэх, Төслийн хүрээнд өөрийн эрхэм зорилгыг баримтлахын тулд бүхий л чармайлтыг гаргасан гэдэгт Удирдлага итгэлтэй байна. Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуудалд хамаарагдах бүхий л Бодлого, журмыг Банк дагаж мөрдсөн гэж Удирдлага үзэж буй юм.

Төсөл

iii. УУДБХОД төсөл нь 2011 оны 11-р сарын 24-нд Гүйцэтгэх Захирлуудын Зөвлөлөөр батлагдаж, 2011 оны 11-р сарын 20-нд хүчин төгөлдөр болсон. УУДБХОД төсөл нь санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран уул уурхай, эцсийн шатны боловсруулалтын салбарт дэмжлэг үзүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, дэд бүтцийн төслийг Монгол улс (“Хүлээн авагч”) -д бэлтгэх, хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг бий болгох зорилготой юм.

iv. Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангах тогтвортой эх үүсвэр болох бололцоотой хэдий ч эрчим хүч, тээвэр, ус болон аж үйлдвэрийн боловсруулах салбар дахь өнөөгийн дутагдлууд уул уурхайн хөгжлийг хязгаарлаж байна. Уул уурхай хөгжлийг дэмжихэд шаардлагатай дэд бүтцийг байгаль орчин болон нийгэмд тогтвортой байдлаар төлөвлөх, бүтээн байгуулах болон үйл ажиллагааг явуулдаг болох нь Монгол Улсын Засгийн газар (МУЗГ)-т тулгарч буй гол сорил юм.

v. Уг Төсөл нь дээр дурьдсан бэрхшээлүүдийг авч үзэн, Монголын уул уурхайн салбарт санал болгож буй зургаан дэд төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах үүднээс Үнэлгээний судалгаанууд (урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд)-г санхүүжүүлж буй юм. Шүрэнгийн судалгаа болон Орхон Говийн судалгаа гэх хоёр үнэлгээний судалгаанууд нь эдгээр санал болгож буй дэд төслүүдийн хэрэгжих боломж, байгаль орчин болон нийгмийн болзошгүй нөлөөллийг судлах юм.

vi. УУДБХОД төслийн хүрээнд аливаа дэд бүтцийн хөрөнгө оруулалтын санхүүжилт зөвшөөрөгдөхгүй ба Банкны зүгээс УУДБХОД төслийн хүрээнд судлагдсан санал болгож буй дэд төслүүдийг барихад хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох амлалт МУЗГ-т өгөөгүй болно.

Хүсэлт

vii. Хяналтын хороо нь Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (Банк)-аас санхүүжүүлж буй Монгол улсын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэмэлт санхүүжилт (P145439) (УУДБХОД төсөл)-ийн талаарх Хяналт шалгалт явуулах хүсэлт (IPN Request RQ15/03, цаашид “Хүсэлт” гэх)-ийг 2015 оны 3-р сарын 13-нд бүртгэсэн болно.

viii. Уг Хяналт шалгалт явуулах хүсэлтийг Төслөөс үүдэн гарах сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй гэж итгэж буй Монгол улс болон ОХУ-ын орон нутгийн төлөөлөгчид болон орон нутгийн байгууллагууд (цаашид “Хүсэлт гаргагчид гэх”) гаргасан болно.

Удирдлагын хариу

ix. *Хүсэлт гаргагчид нь Банкнаас санхүүжүүлж буй Үнэлгээний судалгаануудаас бус, харин санал болгож буй дэд төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаа мөн/эсвэл бүтэлгүйтлээс үүдэх болзошгүй хор хөнөөлд чиглэгдсэн асуудлууд дэвшүүлсэн тул Удирдлагын зүгээс Хяналт шалгалт хийх хүсэлт нь шалгалт явуулах шаардлага хангаагүй гэж үзэж байна.* Банк нь санал болгож буй дэд төслүүдийг барих санхүүжилтэд оролцоогүйн дээр одоо аливаа барилгын ажил явагдахгүй байгааг Удирдлага онцолж байна. Удирдлага нь Хяналт шалгалт явуулах хүсэлтэд тавигдах шаардлагуудтай холбоотой эдгээр асуудлуудыг үл харгалзан Хүсэлтэд дэвшүүлсэн асуулт, асуудлуудад хариу өгөх боломжийг хүлээн авч буй юм.

x. *Монгол улсын эрчим хүчний салбарт үзүүлэх дэмжлэг нь сайн үнэлгээ, судалгаанд суурилдаг байх ёстой гэж үзсэн хэвээр байна.* Үүнд Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцааны төслөөс санхүүжүүлсэн “Монгол улс: Эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх нь” (Эрчим хүчний салбарын төлөвлөгөө) орж буй юм. Эрчим хүчний салбарын төлөвлөгөө нь Монгол улсын эрчим хүчний салбарын талаар шаардлага хангасан хэмжээнд хийгдсэн, цогц судалгаа ба уг салбарын ирээдүйн хөгжлийн талаар стратегийн зөвлөмжүүдийг агуулсан болно. Ажлын давхардал үүсгэхгүйн тулд УУДБХОД төслийн хамрах хүрээнд уг салбарын давтан судалгааг оруулаагүй болно.

xi. *Эдгээр Үнэлгээний судалгаанууд нь Дэлхийн Банкны Гүйцэтгэх захирлуудын зөвлөлөөс 2011 оны 5-р сарын 24-нд баталсан УУДБХОД төслийн баримт бичигт тусгагдсан Бүрэлдэхүүн хэсэг 1-т хамрагдаж буй болохыг Удирдлагаас тодруулахыг хүсэж байна.* МУЗГ нь судлагдаж буй зургаан санал болгосон дэд төслүүдийг тодорхойлсны дараа Үнэлгээний судалгаануудын талаарх мэдээллийг Дэлхийн Банкны ГЗЗ-өөр 2014 оны 3-р сарын 18-нд батлуулсан төслийн бүтцийн өөрчлөлт, нэмэлт санхүүжилтэд хамруулсан болно.

xii. *УУДБХОД төсөл нь Банкны бодлого, журам болон томоохон дэд бүтцийг хөгжүүлэхэд тавигдах олон улсын салбарын практик туршлагыг баримталж буй гэж үзэж байгаа ба энэ нь төлөвлөлтийн түвшнөөс эхлэн илүү гүнзгий дүн шинжилгээнд дэвшин шилжих цуврал үнэлгээ, судалгаанууд шаарддаг юм.* Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)-ний ажлын даалгаварт уг үнэлгээний хүрээнд нэмэлт хувилбаруудыг үнэлэх шаардлага тавигдах юм. Одоогоор санал болгож буй дэд төслүүдийн аливаа БОННУ хийгдэж эхлээгүй болно.

xiii. *Голын дээд болон доод урсгал дагуух амьдрах орчны нөлөөллийн талаар Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд нь Үнэлгээний судалгаануудаас биш, харин санал*

болгож буй Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн барилгын ажил болон үйл ажиллагаанаас үүдэх болзошгүй хор хохирлоос үүдэх боломжтой гэж илтгэж буйг Удирдлага тэмдэглэж байна. Хүсэлт гаргагчдын дэвшүүлж буй асуудлууд нь санал болгож буй Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллүүдэд багтаж байгаа ба эдгээр нөлөөллүүд нь Үнэлгээний судалгаануудын сэдэв юм.

xiv. **Хил дамнасан нөлөөллийг Олон улсын усан замын талаар баримтлах Банкны бодлого (ОР 7.50)-ын дагуу нягтлан судална гэж Удирдлага тэмдэглэж буй юм.** Хэрэв хэрэгжвэл Сэлэнгэ гол болон түүнд цутгах гол, мөрөнд байрлах Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдэд хийх Үнэлгээний судалгаануудад энэхүү бодлого нь мөрдөгдөх юм. Сэлэнгэ гол нь Монгол улс болон ОХУ-ын хилийг гаталж, ОХУ-ын Байгаль нуурт цутгадаг юм. Банкны бодлогын дагуу олон улсын усан замын талаарх эсвэл түүнтэй холбоотой ТЭЗҮ нь мэдээллэх шаардлагаас чөлөөлөгдсөн байдаг. Удирдлагаас Бодлогын дагуу УУДБХОД төслийг уг шаардлагаас чөлөөлөх зөвшөөрлийг 2013 оны 8-р сарын 28-нд олгосон. Гэсэн хэдий ч Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн БОННУ-нд эрэг орчмын асуудлуудад дүн шинжилгээ хийх юм.

xv. Байгаль нуур болон Сэлэнгэ голын ус, намхархаг газар нь ЮНЭСКО-гийн Дэлхийн өвийг хамгаалах конвенц болон Рамсарын конвенцийн хамгаалалтанд тус тус багтсан. Банк нь эдгээр газруудын соёлын болон байгаль орчны ач холбогдлыг ухамсарлаж буй ба УУДБХОД төсөлд хамааралтай (ЮНЭСКО-гийн Дэлхийн өв болон Рамсарын конвенциуд гэх мэт) олон улсын байгаль орчны гэрээ, хэлэлцээрүүдийн хүрээнд МУЗГ-ын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд хяналт тавьдаг болно.

xvi. **Сэлэнгэ голын ай сав газарт хийгдэх усан эрчим хүчний бүтээн байгуулалтаас үүдэх болзошгүй хуримтлагдах нөлөөллийн талаар Хүсэлт гаргагчидтай адил санаа зовинож буйг тэмдэглээд, УУДБХОД төсөл нь эдгээр асуудлуудыг Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн БОННУ-нд хуримтлагдах нөлөөлүүдийг дэлгэрэнгүй, системтэйгээр дүн шинжилгээ хийх замаар нягтлан шалгах аар зорьж буйг Удирдлага онцолж буй юм.** Энэхүү хуримтлагдах нөлөөллийн дүн шинжилгээнд ирэх 20 жилд Сэлэнгэ голд авч үзэх ус болон усны эрчим хүчний бүхий л дэд бүтцүүд мөн Сэлэнгийн садраа болон Байгаль нуурын газар нутгийг хамруулах юм.

xvii. **Банк нь дэд төслүүдийн үнэлгээний судалгаануудыг бэлтгэх бүхий л үе шатанд холбогдох олон нийттэй зөвлөлдөх, мэдээллэх талаар баримтлах Банкны бодлого болон журмыг даган мөрдсөн гэж Удирдлага үзэж буй юм.** Банк нь тэргүүн практик туршлагыг баримтлах үүднээс Банкны бодлогод хамаарахгүй үйлчлүүлэгчийн эзэмшлийн мэдээллийг ил болгохыг МУЗГ-т уриалан ажилласан.

xviii. Удирдлага нь Хүлээн авагчид цогц Үнэлгээний судалгаанууд хийхэд дэмжлэг үзүүлэх замаар хүсэлт гаргагчдын болон бусад оролцогч талуудын холбогдох зовнилуудыг авч үзэхээр тууштай зорьж ажиллаж байна.

I. УДИРТГАЛ

1. Хяналтын хороо нь Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (Банк эсвэл Дэлхийн Банк)-аас санхүүжүүлж буй Монгол улсын уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (P118109) болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэмэлт санхүүжилт (P145439) (хамтад нь УУДБХОД төсөл гэх)-ийн талаарх Хяналт шалгалт явуулах хүсэлт болох IPN RequestRQ15/03 (цаашид “Хүсэлт” гэх)-ийг 2015 оны 2-р сарын 10-нд хүлээн авч, 2015 оны 3-р сарын 13-нд бүртгэсэн болно.

2. *Энэхүү Удирдлагын хариуны бүтэц.* Уг баримт бичиг нь дараах хэсгүүдээс бүрдсэн болно. Үүнд: Хэсэг II-т Хүсэлтэд дэвшүүлсэн асуудлуудын тойм, Хэсэг III-т УУДБХОД төслийн хураангуй ба загвар, Хэсэг IV-т Хүсэлтийн шаардлагад нийцсэн эсэх болон дэвшүүлсэн гол асуудлуудын талаарх Удирдлагаас хүсэлтэд өгөх хариу тус тус тусгагдсан болно. Хавсралт 1-т Хүсэлт гаргагчдын өгсөн мэдэгдлүүд болон тэдгээрт өгөх Удирдлагын дэлгэрэнгүй хариуг хүснэгт хэлбэрээр тусгасан болно. Хавсралт 2-т УУДБХОД төслийн хүрээнд төлөвлөсөн болон гүйцэтгэсэн бүхий л судалгаанууд (Үнэлгээний судалгаанууд)-ын жагсаалтыг оруулсан болно. Хавсралт 3-т УУДБХОД төслөөс өдийг хүртэл явуулсан олон нийтийн зөвлөгөөний дэлгэрэнгүйг харуулсан болно.

II. Хүсэлт

3. Хянан шалгалт явуулах хүсэлтийг аюулгүй байдлын үүднээс хувийн мэдээллээ нууцлахыг хүссэн Монгол улс болон ОХУ-ын орон нутгийн төлөөлөгчид болон орон нутгийн байгууллагууд гаргасан болно. Тэд Монгол улс болон ОХУ дахь төлөөлж харилцах хоёр төлөөлөгчийг сонгосон болно (цаашид “Хүсэлт гаргагчид” гэх).

4. Хүсэлтэд дараах хавсралтуудыг хавсаргасан. Үүнд :

- (i) “Дэлхийн Банкны бодлогуудын зөрчлийн хүснэгт”
- (ii) “Болзошгүй нөлөөллүүдийн хүснэгт”
- (iii) “Дэлхийн Банкны ажилтнуудтай харилцаж байсан баримт”
- (iv) “Оролцогч талуудтай харилцах, төслийн хяналттай холбоотой асуудлуудын дэлгэрэнгүй”

Удирдлагад Хүсэлтийг дагалдуулж өөр материал ирүүлээгүй болно.

5. Хүсэлтэд дараахыг мэдэгдсэн:(i)УУДБХОД төсөл нь Монгол улсын эрчим хүчний салбарт үр ашиггүй хөгжлийг дэмжиж байна;(ii)УУДБХОД төслийн хүрээнд явагдсан үйл ажиллагаа төслийн хамрах хүрээг зөрчиж байна;(iii)Төсөл нь зохих үйл явцыг дагахгүй байна;(iv)бусад хувилбаруудыг хангалттай шинжилж үзээгүй;(v) хэрэв санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүд ирээдүйд баригдвал хүн ам, байгаль орчинд ноцтой хор хохирол учруулж;(vi) Дэлхийн өвд бичигдсэн Байгаль нуур болон Рамсарын конвенцоор I хамгаалагдсан Сэлэнгийн ус, намхархаг газар гэх мэт газруудад үзүүлэх болзошгүй хил дамнасан нөлөөллийг УУДБХОД төслөөс хангалттай авч үзээгүй; мөн(vii)Болзошгүй нөлөөлөлд өртөх Монгол улс болон ОХУ-ын холбогдох талуудад хангалттай мэдээлэл өгч, зөвлөлдөөгүй.

¹ Ус, намхархаг газрын олон улсын конвенци (Рамсарын конвенци)

6. Хүсэлтэд Банкныг дараах Бодлого болон журмыг дагаж мөрдөөгүй гэж үзсэн болно. Үүнд:

- ОР²/ВР³4.01 Байгаль орчны үнэлгээ
- ОР/ВР4.04 Байгалийн амьдрах орчин
- ОР/ВР4.07 Усны нөөцийн менежмент
- ОР/ВР4.12 Албадан нүүлгэлт
- ОР/ВР7.50 Олон улсын усан замын төслүүд
- ОР/ВР10.0 Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт
- Мэдээлэл авах

III. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

7. Нийт 3 сая орчим хүн амын тал нь нийслэл хот Улаанбаатарт амьдардаг, нийт 1.5 сая квадрат км газар нутаг бүхий Монгол улс нь дэлхийн хамгийн хүн амын нягтаршил багатай орнуудын нэг юм. Хэдийгээр нийт хүн амын 27 хувь нь ядуурлын шугамаас⁴ доогуур амьдарч буй боловч Монгол улсад эдийн засгийн өсөлтийг дэмжиж, дунд орлоготой улсын статуст хүргэсэн эрдэс баялгийн салбарын хурдацтай өсөлт өнгөрсөн арван жилд тохиосон. Уул уурхайн салбар одоогоор улсын ДНБ-ний 26 хувийг бүрдүүлж буй юм. Түүнчлэн, эрдэс баялгийн арвин их нөөц нь тус улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг хангах хамгийн том боломжийг олгож буй юм. Гэсэн хэдий ч урт хугацаанд уул уурхайн салбарыг Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийн эх үүсвэр болгоход олон тооны томоохон сорил тулгарч буй юм. Монгол улсын Засгийн газар (МУЗГ) уул уурхайн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, түүнийг бууруулахад тусгайлан анхаарч, сайн эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай юм. Түүнчлэн, уул уурхайн хөгжил нь эрчим хүч, тээвэр, ус болон аж үйлдвэрийн боловсруулалт гэх гол дөрвөн дэд бүтцийн салбар дахь одоогийн дутагдлаас үүдэн хязгаарлагдаж буй юм. Уул уурхайн хөгжлийг дэмжих дэд бүтцийг цаг хугацаанд нь тогтвортой байдлаар төлөвлөх, бүтээн байгуулах, үйл ажиллагаанд оруулах нь МУЗГ-т тулгарч буй гол сорил юм.

8. Монгол улс нь дэлхийд томоохонд тооцогдох зэс, уран, нүүрс, төмөр, хүдэр болон алтны орд газруудтай юм. Сүүлийн жилүүдэд Өмнөговь аймагт байрлах Оюу толгойн алт, зэсний уурхай, Таван толгойн нүүрсний уурхай гэх мэт хэд хэдэн томоохон төслүүд гадаад, дотоодын ихээхэн хөрөнгө оруулалтаар олборлолтын үйл ажиллагаагаа эхэлсэн. Эдгээр уул уурхайн үйл ажиллагааг тогтвортой замаар дэмжихийн тулд шаардлагатай эрх зүйн зохицуулалт, дэд бүтцийг бий болгох нь Монгол улсын хувьд тулгамдсан хэрэгцээ болж буй юм.

9. Эрдэс баялгаас хамааралтай эрсдэлүүдийг Монгол улс сайн мэдэж байгаа ба эдгээр эрсдэлүүдийг удирдах чадавхийг бэхжүүлэх нь сүүлийн хэдэн жилүүдэд Дэлхийн Банк Групп (ДБГ)-ийн дэмжлэгийн гол цөм байсаар ирсэн болно. ДБГ-ийн уул уурхайг гол сэдэв болгосон цогц стратегийг 2009-2010 оны Завсрын Стратегид тусгасан байсан ба энэхүү баримт бичиг нь УУДБХОД төслийг бэлтгэж, батлуулахад хүчин төгөлдөр байсан юм. Энэхүү стратегийг одоогийн 2013-2017 онд Монгол улстай Түншлэх Стратегид илүү гүнзгийрүүлэн тусгасан болно. Одоогийн Монгол Улстай Түншлэх Стратегийн гурван чиглэлийн эхнийх нь “Уул уурхайн эдийн засгийг тогтвортой, ил тодоор удирдах талаар Монгол улсын чадавхийг бэхжүүлэх” гэж гарчиглагдсан ба үүний хүрээнд ДБГ-ийн дараах

² ОР- Үйл ажиллагааны бодлого

³ ВР-Банкны бодлого

⁴ Монгол улсын үндэсний ядуурлын шугамыг нэг хүнд нэг сарын 118 669 төгрөгөөр тогтоосон (эсвэл 2012 оны нэрлэсэн ханшаар 89 ам.доллар)

цогц үйл ажиллагааг зохион байгуулсан байна: уул уурхайн салбарын эрх зүйн орчинг сайжруулж, байгаль орчин, нийгмийн удирдлагыг бэхжүүлэх техникийн туслалцаа⁵; нэн чухал дэд бүтцийг илүү сайн төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх⁶; ОУСК болон ОТХОБА-ын “тэргүүн туршлага” бүхий уул уурхайн хөрөнгө оруулалт; Монголын институцийг илүү ил тод, хариуцлагатай болгох болон сайжруулсан дата, цахим засгийн газраар дамжуулан иргэдэд чиглэгдсэн төрийн менежментийг сайжруулах техникийн туслалцаа⁷; болон төсөв, эдийн засаг болон мөнгөний удирдлагын бодлогуудыг бэхжүүлэх туслалцаа⁸.

Тодорхойлолт

Төсөл. Уг Төсөл нь Дэлхийн Банкаас баталж, ОУХА-с санхүүжүүлж буй Монгол улсын УУДБХОД төсөл юм.

Үнэлгээний судалгаанууд. УУДБХОД төслөөс санал болгосон Монголын зургаан дэд төслийг нягтлан шалгах Үнэлгээний судалгаанууд (урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ, БОННҮ) болон бусад ажлуудыг санхүүжүүлж буй юм. Эдгээр Үнэлгээний судалгаануудад Шүрэнгийн судалгаа, Орхон Говийн судалгаанууд орж буй ба санал болгосон төслүүдийн техник, эдийн засгийн боломж болон байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг нягтлан судлах юм.

Дэд төслүүд. Санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүд гэх мэт эдгээр зургаан санал болгосон дэд төслүүд нь ирээдүйд хэрэгжиж болох дэд бүтцийн төслүүд юм. Эдгээр зургаан санал болгож буй төслүүдийг УУДБХОД төсөл эсвэл Банкаас санхүүжүүлээгүй байгаа болно.

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (УУДБХОД төсөл)

10. ***Зорилт.*** УУДБХОД төслийн зорилго нь санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран уул уурхай, эцсийн шатны боловсруулалтын салбарт үзүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, дэд бүтцийн төслийг бэлтгэх явуулах орон нутгийн чадавхийг Монгол улсад бий болгох юм. Төслийн хамрах хүрээ орон даяар бөгөөд зөвхөн техникийн туслалцааг, өөрөөр хэлбэл ТЭЗҮ, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд гэх мэт судалгааны бэлтгэл болон чадавхийг бэхжүүлэх ажлуудыг санхүүжүүлж буй юм. УУДБХОД төслөөс аливаа дэд төслүүдийг санхүүжүүлэх хориотой болно. Түүнчлэн, Банк нь санал болгосон дэд төслүүдийн барилгын ажлыг УУДБХОД төслийн хүрээнд санхүүжүүлэх амлалт Монгол улсад өгөөгүй гэдгийг Удирдлага онцолж буй юм.

11. ***Төслийн загвар.*** УУДБХОД төсөл нь Гүйцэтгэх захирлуудын зөвлөлөөр 2011 оны 5-р сарын 24-нд батлагдсан. Уг төсөл нь Монгол Улсын Их Хурлаар соёрхогдон батлагдаж, 2011 оны 11-р сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон. УУДБХОД төсөл нь дөрвөн техникийн туслалцааны бүрэлдэхүүн хэсгүүдэс бүрдсэн юм. Үүнд: (i) ТЭЗҮ болон бусад техникийн судалгаанаас бүрдэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дэмжлэг (18.11 сая ам.доллар); (ii) чадавхийг бэхжүүлж, мэдлэг шилжүүлэх (2.47 сая ам.доллар); (iii) гүний усны менежментийг бэхжүүлэх (3.23 сая ам.доллар); мөн (iv) төслийн менежмент (1.19 сая ам.доллар) тус тус орно. Энэ нь Байгаль орчны үнэлгээ ОР4.01-ийн дагуу Ангилал А-д хамрах төсөл юм. УУДБХОД төслийн бүрэлдэхүүн хэсэг 1 нь дэд бүтцийн хөрөнгө

⁵ Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны хөтөлбөр (MSISTAP)

⁶ Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)

⁷ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС)-ын Монгол дахь хөтөлбөр, Ухаалаг Засгийн газар төсөл (SMART), мөн бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд засаглал, иргэний оролцоог сайжруулахаар хийгдэх нэмэлт үйл ажиллагаанууд

⁸ Олон салбарын техникийн туслалцааны төсөл (MSTAR) болон бусад техникийн туслалцаа болон ААА оролцоо

оруулалтыг хөнгөвчлөх техникийн судалгаанууд болон Хүсэлтийн гол сэдэв болох санал болгосон Шүрэнгийн усан цахилгаан станц (Шүрэн) болон Орхон Говийн дэд төслүүдийн ТЭЗҮ ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) болон бусад ажлаас бүрдэх юм.

12. Томоохон дэд бүтцийн судалгаа хийхэд олон улсын практик туршлагыг дагах тал дээр Монгол улсад туслах нь УУДБХОД төслийн үндсэн цөм болохыг Удирдлага онцолж буй юм. Дэлгэрэнгүй ТЭЗҮ гэх мэт судалгаануудыг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, шаардлагатай тохиолдолд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээтэй зэрэгцүүлэн эсхүл уялдуулан явуулах юм. Банкны бодлого, журмыг даган мөрдүүлэх үүднээс олон улсын туршлагатай зөвлөхүүд Үнэлгээний судалгаа хийхэд гол үүрэг гүйцэтгэх юм. Ингэснээр УУДБХОД төсөл нь ирээдүйд мэдээлэлд тулгуурласан, тогтвортой шийдвэрт хүргэхийн тулд цогц, системтэй, шинжлэх ухаанд суурилсан, үнэн зөв, объектив Үнэлгээний судалгааг санал болгосон дэд төсөл бүрт МУЗГ-аас хийх нөхцөлийг хангах зорилготой юм.

13. *Банкны оруулж буй үнэ цэнэ.* УУДБХОД төслийн хүрээнд Банкаас үзүүлж буй дэмжлэгийн үнэ цэнэ нь сайжирсан чадавх, илүү системтэй, бүтэц зохион байгуулалт бүхий арга барил, мөн эдгээр санал болгосон дэд төслүүдийн үнэлгээ, судалгаанд Банкны оролцооноос үүдэх илүү ил тод байдал тус тус болно. Банкны бодлого болон журмыг хийгдэж буй Үнэлгээний судалгаануудад мөрдөх замаар эдийн засаг, санхүү, байгаль орчин болон нийгмийн эрсдэлүүдийг олж тогтооход, мөн төслийн (үүнд “төсөлгүйгээр” гэх хувилбар мөн орж буй) болоод салбарын түвшин дэх хувилбаруудад нягт нямбай дүн шинжилгээ хийхэд илүү их ач холбогдол өгч байна. УУДБХОД төслийн хүрээнд хийгдэх Үнэлгээний судалгаанууд нь Банкны оролцоогүйгээр хийгдвэл гарах судалгаануудаас илүү өндрийн хүрээнд хийгдэх Үнэлгээний судалгаа, жишээлбэл, УУДБХОД төслийн хүрээнд хийгдэх байгаль орчны үнэлгээнүүдийн хүрээнд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг БОННУ-ний нэг хэсэг болгон оруулах юм. Ингэх нь Банкны бодлого, журмын дагуу шаарддаг боловч Монголын хуулийн дагуу шаарддаггүй юм. Түүнчлэн, Банкны зөвлөлдөх болон мэдээллэх шаардлагуудыг мөрдөх нь илүү ил тод байдлыг дэмжиж буй юм.

14. УУДБХОД төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-нд хэрэв үнэлгээ, судалгаа нь хийгдэж буй санал болгосон дэд төслүүдийг МУЗГ-аас ирээдүйд хэрэгжүүлбэл, БОНУХ-нд тусгагдсан үйл явцыг баримтална гэж заасан болохыг Удирдлага тэмдэглэж буй юм. Аливаа боломжит санхүүжүүлэх этгээд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах, хамгийн бага түвшинд байлгах арга хэмжээг авч үзэн, олж тогтоолгохыг БОНУХ зорьж буй юм. Тодруулбал, хэрэв зайлсхийх боломж байхгүй тохиолдолд Монгол улсын байгаль орчин, нийгмийн хууль тогтоомж болон Дэлхийн Банкны Хамгааллын бодлогуудын дагуу нөлөөллийг хангалттай олж тогтоон, үнэлж, улмаар бууруулах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх юм.

15. Дээрхээс гадна, Банкны оролцоо нь олон эх үүсвэрээс санхүүгийн дэмжлэг авах, зохицуулах боломжийг УУДБХОД төсөлд олгосон юм. Үүнд УУДБХОД төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд хийх усны нөөцийн үнэлгээнүүд, чадавхийг бэхжүүлэх ажлуудын цар хүрээг нэмэгдүүлэхэд ашигласан Австрали улсын Засгийн газрын буцалтгүй тусламж орж буй юм. Монголд оруулах хөгжлийн туслалцааг ийм маягаар зохицуулах нь донор болон хөгжлийн байгууллагуудын дэмжлэгтэй үйл ажиллагаануудыг нийцтэй, зохион байгуулалттай болгож, улмаар ерөнхий үр дүнг сайжруулж, улсын нэн тэргүүний хэрэгцээг шийдвэрлэх юм.

16. *Дэд төслийн шалгаруулалт ба хэрэгжүүлэлт.* Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд үнэлж, судлах санал болгосон төслүүдийг олж тогтоох, шалгаруулах болох үнэлэхэд хэрэглэдэг үйл явц нь УУДБХОД төслийн гол онцлог юм. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын удирддаг яамд хоорондын Төсөл удирдах хороо (ТУХ)-г Төслийг ерөнхийлөн удирдуулахаар

байгуулсан болно. Сангийн яаманд байрлах Төсөл удирдах нэгж (ТУН) нь ТУХ-нд дэмжлэг үзүүлдэг. ТУХ нь санал болгосон дэд төслүүдийн алийг УУДБХОД төслийн дэмжлэгтэй үнэлж, судлахыг тогтоож, шийдвэр гаргах гол үүрэгтэй юм.

17. ТУХ нь 2012 онд дэд бүтцийн олон төрлийн үндэсний мастер төлөвлөгөөнүүдэд тусгагдсан тэргүүлэх чиглэлүүдэд үндэслэн санал дэвшүүлэх боломжит дэд төслүүдийг сонгон шалгаруулах үйл явцыг хэрэгжүүлэхээр хоёр удаа хуралдсан. ТУХ нь Шүрэн болон Орхон Говь гэх зэрэг зургаан санал болгосон төслүүдийг Засгийн газрын яамд, агентлагуудаас санал болгосон нийт 43 төслөөс сонгон жагсаасан. Дэлхийн Банкнаас уг санал болгосон дэд төслүүд нь УУДБХОД төслийн зорилт болоод хамрах хүрээтэй нийцэж буйг 2014 оны 11-р сарын 20-нд баталгаажуулсны дараа зургаан санал болгосон төслүүдийг удирдан хариуцах яам болгон УУДБХОД төслөөс санхүүжүүлэх техникийн судалгаа, үнэлгээнүүдийг хянах үүрэг бүхий, олон улсын зөвлөхүүдийн дэмжлэгтэй ажиллах ажлын хэсгийг байгуулсан.

18. ТУХ нь санал болгосон зургаан дэд төсөл бүрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудыг олон үе шаттай хэрэгжүүлэх журмыг гаргасан болно. Энэхүү арга барил нь дэд бүтцийн төслүүдийг бэлтгэх, дүн шинжилгээ хийхэд зориулсан олон улсын тэргүүн туршлагыг тусгасан ба санал болгосон төслүүдийн хувь хувийн нарийн төвөгтэй байдал, УУДБХОД төслийн эхлэх үед байсан суурь мэдээллээс шалтгаалан нарийвчлагдсан болно. Ерөнхийдөө санал болгосон дэд төслүүдийн үнэлгээ, судалгаанууд нь хоёр үе шат бүхий арга барилыг баримталсан. Үүнд: үе шат1–техник, санхүү, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ ба сонгогдсон техникийн судалгаануудын гүйцэтгэл; мөн үе шат2–ТЭЗҮ ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд тус тус орсон. Санал болгосон Орхон Говийн дэд төсөл (Орхон Говийн судалгаанууд)-ын хувьд дэд төслийн өөрийн нарийн түвэгтэй байдал, гүний усны үнэлгээний дутагдалтай байдлаас үүдэн үнэлгээний үе шатанд шаардагдах хэмжээнээс илүү нарийн түвшний дүн шинжилгээг гаргах бэлтгэл судалгааг оруулж өгсөн юм. Санал болгосон Шүрэнгийн төсөл (Шүрэнгийн судалгаанууд)-ын хувьд дэд төслийн өөрийн нарийн төвөгтэй байдлаас үүдэн дараах гурван үе шат бүхий арга барилыг баримталсан. Үүнд: үе шат 1 –техник, санхүү, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ; үе шат2– урьдчилсан ТЭЗҮ; мөн үе шат 3–ТЭЗҮ ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд. ТУХ болон Банкны шийдвэр гаргасан үндэслэлүүдийг энэхүү үйл явцад оруулсан ба үүний талаар доор өөр хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

19. Үнэлгээний судалгаануудыг хийх явцад Банкны Бодлого, журмын дагуу оролцогч талуудтай олон нийтийн зөвлөгөөн хийнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүдийг гүйцэтгэхээр авч ажиллуулах зөвлөхүүдийн ажлын даалгавар (АД)-т оролцогч талуудын зураглал, оролцогч талуудтай зөвлөлдөх төлөвлөгөө гаргах шаардлагыг орсон болно.

20. Санал болгосон зургаан дэд төслүүдийн Үнэлгээний судалгаануудын аль нь ч эцсийн ТЭЗҮ болон БОННУ-ний үе шатанд хүрээгүй байгаа боловч Үнэлгээний судалгаануудын үнэлж, хянах үйл явцыг боловсруулсан болно. Дэлхийн Банкны мэргэжилтнүүд хянаж үзэн, чанарын баталгааны хяналт тавихаас гадна Шүрэн болон Орхон Говийн санал болгосон дэд төслүүдийг үнэлж дүгнэх олон улсын мэргэжилтнүүдийн төлөөлөл бүхий Шинжээчдийн хороо байгуулагдана.

21. *Бусад хувилбаруудын дүн шинжилгээ.* УУДБХОД төслийн хүрээнд хийгдэх үнэлгээний судалгаануудын гол бүрэлдэхүүн хэсэг нь бусад хувилбаруудад дүн шинжилгээ хийх юм. Үүнд “төсөлгүйгээр” гэх хувилбар орж буй юм. Үнэлгээний судалгаануудын үе шат бүхэнд зохих түвшний дүн шинжилгээг хийх, дүн шинжилгээ хооронд бусад хувилбаруудыг тууштай авч үзэхийг баталгаажуулах юм. Энэ нь эхний богино жагсаалтыг гаргах үе шатанд

явагдсан салбарын түвшний бусад хувилбаруудын дүн шинжилгээнээс эхэлж, Үнэлгээний судалгаа цааш явагдахад илүү нарийссан.

22. *Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд үнэлж, судалж буй дэд төслүүд.* Үнэлгээ, судалгаа хийхээр дээр дурьдсан үйл явцын дагуу сонгогдсон санал болгосон зургаан дэд төслүүд нь:(i) Орхон Говийн урсацын тохируулга, усны нийлүүлэлт;(ii)Сэлэнгэ гол дахь Шүрэнгийн усны цахилгаан станц (УЦС);(iii) Дархан-Сэлэнгийн төвийн бүсийн хар төмөрлөгийн цогцолбор; (iv) Багануурын нүүрсний уурхайн өргөтгөл; (v) Өмнөд говийн бүсийн нутгийн унд, ахуй, үйлдвэрийн усан хангамжийн систем; болон (vi) Хийжүүлсэн нүүрсний (НБХ)-н үйлдвэр юм.Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн эцсийн гарц нь эдгээр зургаан санал болгосон дэд төслүүдийн хэрэгжих боломжийг авч үзсэн багц ТЭЗҮ, холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд (Үнэлгээний судалгаанууд) байх юм.

23. *Хэрэгжүүлэлтийн түүх.*УУДБХОД төслийн хэрэгжүүлэлт МУЗГ-ын ийм төслүүдийг хэрэгжүүлж байсан туршлага, чадавх хязгаарлагдмал байсан улмаас удаан эхэлсэн. Эхэн үед ТУХ болон ТУН гэх мэт УУДБХОД төслийн институцийн болоод засаглалын бүтцийг байгуулахад чармайлтаа төвлөрүүлсэн. 2012 он гэхэд ТУХ бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хүрээнд үнэлж, судлах санал болгосон дэд төслүүдийг шалгаруулах ажлыг эхэлсэн байсан ба дэд төслүүдийн судалгаануудыг үнэлэх, баталгаажуулах болон хэрэгжүүлэх явц өдийг хүртэл үргэлжилсээр байна.

24. 2014 оны 3-р сард санал болгосон зургаан дэд төслүүдийг УУДБХОД төслийн хүрээнд үнэлж, судлахаар болж шалгаруулсны дараа Төсөл нь Түвшин 1 (ГЗЗ-өөр батлагдах) бүтцийн өөрчлөлт дараах зорилгоор хийсэн: (i) үнэлгээ, судалгаанд хамруулахаар болсон санал болгосон дэд төслүүдийг оруулахыг баталгаажуулах;(ii) санал болгосон зургаан дэд төслүүдийн Үнэлгээний судалгаануудад хамааралтай Банкны Хамгааллын бодлогуудыг авч үзэх;мөн (iii) худалдан авах ажиллагааны зохицуулалт, үр дүнгийн хүрээ гэх мэт жижиг нэмэлт өөрчлөлтүүдийг Төсөлд тус тус оруулах болно. Үүнтэй зэрэгцэн Австрали улсын Гадаад хэрэг, худалдааны яам (ГХХЯ, хуучнаар АОУХА)-ны Итгэлцлийн сангаас УУДБХОД төслийн бүрэлдэхүүн хэсэг 3 (Гүний усны менежмент)-ийг өргөжүүлэх зорилгоор Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөлд 4.2 сая ам.долларын нэмэлт буцалтгүй тусламж өгөхөөр баталсан.

Санал болгосон Шүрэнгийн усан цахилгаан станцын дэд төсөл (Шүрэнгийн дэд төсөл)

25. УУДБХОД төслийн хүрээнд 350-800 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зардал шаардагдах, 160-245МВ хүчин чадал бүхий усан цахилгаан станцыг Сэлэнгэ голд барих саналын боломжийг судалж, үнэлэх юм. Тодорхой байршлын хувьд Сэлэнгэ голын дээд урсгал хавьцаах Шүрэн голтой нийлэх хэсэгт байрлана гэж үзэж буй юм. Энэ газар нутаг нь ОХУ-ын нутаг дэвсгэрт хамаарагдах Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн амьдрах орчин болох Байгаль нуур болон Рамсарын хамгаалалтанд багтсан Сэлэнгийн садраагаас голын урсгал өөд 500 км-ийн зайд байрлах Монголын нутаг дэвсгэр юм.

26. Монголын Сэлэнгэ болон Орхон голууд нь Байгаль нуурт цутгадаг голуудын хоёр юм. Сэлэнгэ гол (ОХУ-д Сэлэнга) нь Рамсарын хамгаалалтанд орсон Сэлэнгэ садарт очихоосоо өмнө ОХУ-ын Джида, Хилок, Уда, Чикой гэх томоохон голуудтай нийлдэг. Санал болгосон Шүрэн болон Орхон Говийн далангаар урсцыг тохируулах газар нь Сэлэнгийн садарын урсац болон Байгаль нуурын динамикт нөлөө үзүүлэх хэсгүүдийн зөвхөн нэг хэсэг юм. Санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн БОННУ-ний нэг хэсэг болон хийгдэх хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь Монгол улс болон ОХУ-д хийж буй бусад интервенцүүдийн нийт нөлөөлөлд оруулах эдгээр дэд төслүүдийн болзошгүй нөлөөллүүдийг үнэлэх юм..

27. МУЗГ нь одоо ажиллаж буй дулааны цахилгаан станцаас гадна эрчим хүч үйлдвэрлэх, Монгол улсын уул уурхайн салбар болон бусад хэрэглэгчдийн хурдтай өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах үүднээс санал болгосон Шүрэнгийн дэд төслийг барих асуудлыг авч үзэж буй юм. Энэ нь хэрэв баригдвал хил дамнасан гол дээр байрлах томоохон, цогц төсөл байх юм. Энэ нь өмнөд бүс нутагт байрлах томоохон уурхайнууд зэрэг уул уурхайн салбарт тогтвортой эрчим хүчний эх үүсвэрээр хангах юм. Түүнчлэн энэ нь нүүрсээс ихээхэн хамааралтай байгаа Монгол улсад цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих юм. Үүний зэрэгцээ санал болгосон Шүрэнгийн дэд төсөл нь дараах эрсдэлүүдийг учруулж болзошгүй юм. Үүнд: далангийн газар орчим үзүүлэх орон нутгийн байгаль орчны нөлөөлөл болон Байгаль нуур болон Сэлэнгэ садар гэх мэт доод урсгал дагуух усны тогтолцоонд үзүүлэх бусад нөлөөллүүд; далангийн аюулгүй байдал; мөн бүс нутгийн улс төр болон засгийн газар хоорондын харилцаа тус тус орно.

28. Шүрэнгийн судалгаанууд нь дээр дурьдсан гурван үе шат бүхий арга барилыг баримталсан. Санал болгосон Шүрэнгийн дэд төсөл нь ТУХ-ноос УУДБХОД төслийн хүрээнд үнэлж, судлуулахаар анх 2012 онд сонгогдсон. 2014 оны сүүлчээр Шүрэнгийн судалгаануудын хувьд урьдчилсан ТЭЗҮ, анхан шатны байгаль орчин болон нийгмийн үнэлгээг дуусгаж, ТЭЗҮ болон БОННУ-ний АД-ын төслийг боловсруулах ажил явагдаж байсан тул хоёр дахь үе шатаа бараг дуусгасан байсан. ТУХ-ноос Шүрэнгийн судалгаануудын эцсийн үе шатыг эхлүүлэх болох, өөрөөр хэлбэл, ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийж болохыг Банкнаас баталгаажуулахыг хүсэмжилсэн.

Гүйцэтгэсэн ажлыг холбогдох Банкны бодлого, журмыг дагаж мөрдсөн эсэх, санал болгосон Шүрэнгийн дэд төслийн үнэлж, судалж буй болзошгүй хор хөнөөл болон ашиг тусыг нарийн нягталж үзэхийн сацуу сонирхож буй оролцогч талуудаас өмнө нь Банкинд ирүүлж байсан захидлуудад дэвшүүлсэн асуудлуудыг зохих ёсоор авч үзсэний үндсэн дээр Банк Шүрэнгийн судалгаануудыг цааш үргэлжлүүлэх боломжтой гэж баталгаажуулсан. Тиймээс, Удирдлага нь 2014 оны 11-р сарын 20-нд санал болгосон Шүрэнгийн дэд төслийн ТЭЗҮ болон БОННУ-г УУДБХОД төслийн хүрээнд үргэлжлүүлж болно гэж баталгаажуулсан.

Санал болгосон Орхон Говийн дэд төсөл

29. Санал болгосон Орхон Говийн дэд төсөл (Орхон Говийн судалгаанууд)-ын үнэлгээ, судалгаанууд нь Орхон голын урсацыг тохируулж, гадаргын ус хуримтлуулах далан, усан сан барих саналыг судалж, үнэлэх юм. Санал болгосон Орхон Говийн төсөлд уул уурхайн хөгжил, аж үйлдвэр болон аялал жуулчлалыг хөгжлийг дэмжих үүднээс Өмнө говийн бүс нутагт ус дамжуулах 900-1000 км орчим урт хоолой багтаж буй юм. Уг санал болгосон дэд төслийн төсөв нь 600 саяас 1 тэрбум ам.доллар орчим байх тооцоотой байна.

30. Санал болгосон Орхон Говийн дэд төсөл нь том, нарийн төвөгтэй дэд төсөл байх ба хэрэв баригдвал хил дамнасан голд байрлах юм. Үүний боломжит үр өгөөжид: орон нутгийн иргэд болон Өмнөд говийн томоохон уурхайнууд гэх мэтчилэн уул уурхайн салбарыг тогтвортой усны эх үүсвэрээр хангах замаар Монгол улсад чухал хөгжлийн үр өгөөж авчрах; мөн ялангуяа Өмнөд говийн бүс нутагт ховор гүний усны олборлолт буурах тус тус болно. Үүний сацуу санал болгосон Орхон Говийн дэд төслийг барих нь эрсдэлүүд дагуулж болох юм. Үүнд: : далангийн газар орчим үзүүлэх орон нутгийн байгаль орчны нөлөөлөл болон Байгаль нуур болон Сэлэнгэ садар гэх мэт доод урсгал дагуух усны системд үзүүлэх бусад нөлөөллүүд; далангийн аюулгүй байдал; мөн бүс нутгийн улс төр болон засгийн газар хоорондын харилцаа тус тус орно.

31. Санал болгосон Орхон Говийн дэд төсөл нь Шүрэнгийн дэд төсөлтэй төстэй үнэлгээ, судалгааны үйл явцыг дагасан ба түүнийг үнэлгээ, судалгаанд хамруулахаар сонгон шалгаруулах явцад сайжруулах алхам хийж, бэлтгэл судалгааг хийлгүүлсэн болно. Энэхүү

дэд төслийн үнэлгээ, судалгааны хувьд урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ-ний үе шатыг нэгтгэсэн тул хамт хийгдэх юм. Гэсэн хэдий ч энэхүү үе шат хэрэгжиж эхлээгүй байгаа болно.

32. Санал болгосон Орхон Говийн дэд төслийг Австрали улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд нарийвчилсан гүний усны мониторинг, үнэлгээ хийх замаар сайжруулсан. Эдгээр гүний усны үнэлгээний судалгаанууд 2014 онд эхэлсэн ба Орхон Говийн судалгаануудтай зэрэгцэн үргэлжлэх юм. Үүний зорилго нь Өмнөд говийн бүсийн усны эрэлтийг хэрхэн хангах талаар МУЗГ шийдвэр гаргахад туслалцаа үзүүлэх үүднээс гүний усны үнэлгээний судалгааны үр дүнг Орхон Говийн судалгаануудын үр дүнтэй зэрэг гаргасан байх юм. Гүний усны үнэлгээний судалгааны үр дүн гараагүй байгаа боловч санал болгосон Орхон Говийн дэд төслийн бэлтгэл судалгааны хүрээнд хийгдсэн ажлаас харвал Орхон Говиос Өмнөд Говь руу ус татах нь ирээдүйд шаардлагатай ба уул уурхайн ирээдүйн хөгжил нь олдох усны хэмжээ болон цаг хугацаанаас шалтгаалах юм.

IV. УДИРДЛАГЫН ХАРИУ

33. Хүсэлт гаргагчдын мэдэгдэл, түүнд өгсөн Удирдлагын дэлгэрэнгүй хариуг Хавсралт 1-т оруулсан болно. Тэдгээр хэд хэдэн асуудлуудад Удирдлага дараах хариуг өгч байна.

34. *Хүсэлт гаргагчид нь УУДБХОД төслийн хүрээнд Банкаас санхүүжүүлж буй ТЭЗҮ, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) болон судалгаанууд (Үнэлгээний судалгаанууд)-аас бус, харин санал болгож буй дэд төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаа мөн/эсвэл бүтэлгүйтлээс үүдэх болзошгүй хор хөнөөлд чиглэгдсэн асуудлууд дэвшүүлсэн тул Удирдлагын зүгээс хяналт шалгалт хийх хүсэлт нь шалгалт явуулах шаардлага хангаагүй гэж үзэж буй байна.* Удирдлага нь УУДБХОД төслийн хүрээнд судлагдаж буй санал болгосон дэд төслүүдийн барилгын ажлыг санхүүжүүлэхэд Банкны оролцоогүй, мөн тэдгээрийг санхүүжүүлэх талаар аливаа шийдвэр эсхүл амлалт өгөөгүйг тэмдэглэж буй юм. УУДБХОД төсөл нь зөвхөн Үнэлгээний судалгаануудыг хамарч буй юм.

35. *Хүсэлт гаргагчид нь санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн талаар үндэслэлтэй асуултууд агуулсан асуудлууд дэвшүүлсэнд Удирдлага талархаж байна.* Гэсэн хэдий ч эдгээр асуудлуудыг зөвхөн цогц, системтэй байгаль орчин, нийгмийн үнэлгээ ОР 4.01-д заасны дагуу хийн авч үзэж, хариуг олох боломжтой гэж үзэж байна. Банк нь УУДБХОД төслийн хүрээнд МУЗГ-т эрэлхийлж буй баталгаатай, объектив мэдлэг, хариултыг санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн Үнэлгээний судалгаагаар дамжуулан боловсруулахад дэмжлэг үзүүлж буй юм. Хүсэлт гаргагчдын үндэслэлтэй асуудлуудыг эдгээр Үнэлгээний судалгаанд оруулж, хянан үзэх юм.

36. *МУЗГ-аас санал болгосон төслүүдийг урагшлуулах эсэх талаарх шийдвэрийг эдгээр судалгаанууд нь урьдчилан тогтоохгүй мөн/эсвэл албадахгүй тул Хүсэлт гаргагчдын дурдсан хор хөнөөл нь Үнэлгээний судалгаануудаас үүдэх боломжгүй гэж Удирдлага үзэж байна.* Мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай объектив суурь мэдээллээр хангах зорилготой хараат бус зөвлөхийн хийсэн Үнэлгээний судалгаанууд болон эдгээр Үнэлгээний судалгаануудын зөвлөмжийг хүлээн авах эсвэл хэрэгжүүлэх талаар МУЗГ-ын гаргах шийдвэр хоёрын хоорондох логик ялгаатай, цаашид ч хэвээр харах шаардлагатай юм. Эдгээр Үнэлгээний судалгаануудыг санхүүжүүлэх нь Хяналт шалгалтын тогтоолд шаардсанчлан бодитой болон болзошгүй хор хөнөөлд хүргэж, Банкны бодлого, журмыг хэрхэн зөрчсөн болохыг Удирдлага олж харахгүй байна.

37. *Нэг оролцогч бүлгийн илэрхийлсэн хязгаарлагдмал зовиол, асуудлуудад төвлөрч, хяналт шалгалт энэ үе шатанд явуулах нь Хүлээн авагчийн хараат бус, цогц байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг ОР4.01-т заасанчлан хийж, эцэслэх чадварыг*

дордуулна гэж Удирдлага итгэж байна. Энэ нь Банкны бодлого, журамд заасан техникийн болон байгаль орчин, нийгмийн үнэлгээнд суурилсан техникийн дэмжлэг, хараат бус зөвлөмжийг өөрийн гишүүн орнуудад өгөх Банкны чадварыг мөн дордуулах юм.

38. *Уг хүсэлт нь тодорхой санал болгосон дэд төслүүдийн судалгааг хориглохыг зорьж буй ба ингэх хориглох эрсдэл болон нөлөөллүүдийг зөвөөр үнэлэх үйл явцыг хааж буй хэрэг гэж Удирдлага мөн тэмдэглэж байна.* Ийм арга барил нь өөрийн гишүүн орнуудад эдийн засгийн нөөцийг тогтвортой хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэх Банкны чиг үүрэгтэй зөрчилдөж байгаа дээр хувьцаа эзэмшигчдийн хүсэмжлэн, хүлээж байдагчлан олон улсад мэдлэг хуримтлууулж, түгээх Банкны үүргийг ихээхэн хүндрүүлэх боломжтой юм.

Хүсэлтэд дэвшүүлсэн тодорхой асуудлуудын талаар

39. Хяналт шалгалт явуулах энэхүү хүсэлт нь тавигдах шаардлага хангаж буй эсэхтэй холбоотой ноцтой асуудлыг үл харгалзан Удирдлагын зүгээс Хүсэлт гаргагчдын дэвшүүлсэн асуулт, асуудлуудад хариулах боломжийг таатай хүлээн авч байна. Удирдлагын зүгээс Хүсэлтэд дурдсан дараах мэдэгдлүүдэд тусгайлан хариулах хүсэлтэй байна:

- a) Монгол улсын эрчим хүчний салбарын үр ашиггүй хөгжил.
- b) УУДБХОД төслийн хамрах хүрээний зөрчил.
- c) УУДБХОД төслийн үйл явцын сул тал болон дутагдлууд.
- d) Бусад хувилбаруудад хангалттай дүн шинжилгээ хийгээгүй.
- e) Амьдрах орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл.
- f) Үзүүлж болзошгүй хил дамнасан нөлөөлөл.
- g) Зөвлөлдөх, мэдээллэхтэй холбоотой дутагдлууд.

Монголын эрчим хүчний үр ашиггүй хөгжүүлж байгаа гэсний талаар

40. Монгол улсын эрчим хүчний салбарт хурдтай өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлтийг найдвартай хангах, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, нүүрсний хэт хамаарлаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдийг бууруулах зэрэг хэд хэдэн, харилцан уялдаатай сорилууд тулгарч байна. Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн өсөлтөөс ихээхэн үүдэлтэйгээр 2020 он хүртэл цахилгааны эрэлт жилд 8-10 хувь нэмэгдэх тооцоололтой байна. Цахилгаан үйлдвэрлэл болон социализмын үед баригдаж хуучирсан үр ашиггүй бүс нутгийн түгээх системийн аль алинд дарамт үүсч, ачаалал тулж байна. Хэрэв Монгол улс одоогийн эрчим хүчний системүүдийн эмзэг байдлаа бууруулах, хурдтай өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд томоохон хөрөнгө оруулалт хийхгүй бол эрчим хүчний хямралд орох аюул нүүрэлж байна.

41. Нүүрс нь Монгол улсад зонхилох эрчим хүчний эх үүсвэр юм. Байгалийн хий байхгүйн дээр бүхий л боловсруулсан газрын тос ихэвчлэн ОХУ, бага зэргийг Хятад болон Өмнөд Солонгос улсаас импортлож байна. Монгол улс нь усан, нар болон салхин сэргээгдэх эрчим хүчний нөөцийг хөгжүүлэх өндөр боломж байгаа ба үүнээс усан эрчим хүч нь суурь ачааллыг хангахад эдийн засгийн хувьд хамгийн хямд, хамгийн үр ашигтай сонголт юм. Хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс нэлээдгүй хөнгөлөлттэй тариф тусгасан Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007 он)-иар сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхийг дэмжсэн байна.

42. Улс орны эрчим хүчний салбарын стратегийн хөгжлийг ихэвчлэн эрчим хүчний мастер төлөвлөгөө хэрэгжүүлэх замаар хангадаг. Усан эрчим хүчийг хөгжүүлэх нь Монгол улсын

эрчим хүчний төлөвлөгөөнүүдэд 1970 оноос хойш суугдсаар ирсэн. УУДБХОД төсөл нь Банкны дэмжлэгтэйгээр 2009 онд хэрэгжиж дууссан “Өмнө говийн дэд бүтцийн судалгаа” (ӨГДБС) гэх зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаанаас урган гарсан ба үүний хүрээнд Өмнөд говийн бүсийн дэд бүтэц, үүнд дунд эрчим хүчний дэд бүтцийн хөгжлийн хэрэгцээг шинжлэн судалсан юм. Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэйгээр 2010 онд эхэлж 2014 онд эцэслэгдсэн “Монгол улс: Эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх нь” гэх гарчиг бүхий эрчим хүчний салбарын хамгийн сүүлийн стратеги энэхүү судалгааг хавсарч буй юм. УУДБХОД төсөл нь эрчим хүчний салбарын үндэсний хэмжээний стратегийн судалгааг оруулаагүй тул хуумгай хандсан байна гэсэн Хүсэлт гаргагчдын мэдэгдлийн хариуд Удирдлага нь АХБ-наас санхүүжсэн Эрчим хүчний салбарын төлөвлөгөө нь чанартай бөгөөд цогц байсан тул ажлын давхардлаас зайлсхийх үүднээс уг салбарт давтан судалгаа хийхийг УУДБХОД төслийн хамрах хүрээнд оруулаагүй гэж цохож байна.

43. Эрчим хүчний салбарын төлөвлөгөө гаргахдаа Монголын эрчим хүчний ирээдүйн эрэлтийн талаар цогц таамаглал хийсэн ба 2030 он гэхэд эрчим хүчний эрэлт 4372МВ-д хүрэх тооцоо байна. Үүний 2821МВ нь Оюу толгой, Таван толгой хэмээх 2 том уурхайн төлөвлөж буй эрэлтээс үүдэлтэй.

44. Мөн Эрчим хүчний салбарын төлөвлөгөө нь Монгол Улсын эрчим хүчний системийн насжилтанд үнэлгээ хийсэн ба улс орны эрчим хүчний аюулгүй байдал болон найдвартай байдлыг хангахад нилээд хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэж үзсэн. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд одоогийн өмнөд болон төвийн эрчим хүчний сүлжээнүүд нь Улаанбаатар хот болон өмнөд говийн бүсийг хамарсан нэгдсэн нэг систем (Төвийн эрчим хүчний систем)-д холбогдохыг дурдсан байна. Уг сүлжээний энэхүү харилцан холболт нь МУ-ын уул уурхайн салбар болоод хүн амд нийлүүлэх эрчим хүчний нийлүүлэлтийг удирдахад нилээд уян хатан байдлыг бий болгоно. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд тодорхойлсноор хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл нь Төвийн эрчим хүчний Системээр дамжуулан өмнөд говийн бүс тухайлбал, Оюу толгой, Таван толгойн уурхайд их хэмжээний эрчим хүч нийлүүлэх юм.

45. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөгөөр МУ дахь эрчим хүчний үйлдвэрлэлийн болон эрчим хүчний сүлжээний өөр өөр эх үүсвэрүүдийн талаар нилээд гүнзгий авч үзсэн. Сэргээгдэхгүй болон сэргээгдэх (ус, нар, салхи) эх үүсвэрийг аль алийг нь авч үзсэн. Уг судалгаагаар эрчим хүчний бодлогод суурилсан тэргүүлэх чиглэлүүд тухайлбал, цахилгаан эрчим хүчний эрэлт, хамгийн бага зардал бүхий шийдэл, эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны бодлого, бүтээгдэхүүний төрөлжилт ба санхүүжилтийн талаар авч үзсэн. МУ-ын эрчим хүчний бүтцэд боломжийн бөгөөд үр ашиг бүхий хувилбар болох усан цахилгаан станц нь эрчим хүчний нийлүүлэлтийн бүтцийг тэнцвэржүүлж, эрчим хүчний их хэмжээний нийлүүлэлтийг хангах уян хатан нийлүүлэлт болоход тусална. Төвийн эрчим хүчний системд эрчим хүч нийлүүлэх Шүрэн голын усан цахилгаан станцыг хөгжүүлэх талаар зөвлөмж уг төлөвлөгөөнд тусгагдсан. Усан цахилгаан станц нь МУ-д давамгайлж буй эрчим хүчний үүсгүүр болох нүүрс түлдэг станцтай харьцуулахад чухал давуу талуудтай.

46. Нүүрсний хэрэглээг хязгаарлах, эрчим хүчний цэвэр эх үүсвэрт холбогдохын ач холбогдлын талаар дорвитой ярьж чадахгүй байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот дэлхий дээрхи нүүрсний гаралтай агаарын бохирдол хамгийн ихтэй хот. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөгөөр цэвэр эрчим хүчний өөр боломжит хувилбарын талаар нарийн судалгаа хийж байгаа бөгөөд нарны эсвэл салхиний эрчим хүч аль аль нь Монгол Улсын хурдацтай өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангаж чадахгүй гэж үзсэн. Учир нь нарны болон салхины эрчим хүч нь байгалийн жамаар тасалддаг шинж чанартай. Салхиний болон нарны эрчим хүч нь МУ дахь усан цахилгаан станцын болон хийн эсвэл нүүрсний эрчим хүчний цахилгаан станцыг бүрэн орлож чадна гэсэн баталгаа байхгүй.

47. Дээрх зөвлөмжүүдээс үл хамааран аливаа усан цахилгаан станцын хувилбаруудыг байгаль орчны нийгмийн нөлөөлөл, эдийн засгийн болон техникийн боломж, цогц нөлөөллийн хувьд сайтар судлах хэрэгтэй ба эдгээр судалгаануудыг хийгэл төлөвлөж буй төслүүдийн боломжит эрсдэл ба нөлөөллийг бүрэн мэдэж чадахгүй гэдгийг удирдлага тэмдэглэсэн байна. Шүрэн болон Орхон Говь дэд төслүүдийн эдгээр хүчин зүйлсүүдийн талаар системтэй, цогц үнэлгээ, судалгаа хийх нь УУДБХОД төслийн ажил болох нь тодорхой.

УУДБХОД төслийн хамрах хүрээний зөрчил

48. Бүрэлдэхүүн-1-ийн хүрээнд 6 дэд төслийг үнэлж, судлах нь уул уурхайн салбарын хөгжлийг дэмжих дэд бүтцийн хөрөнгө оруулалтын үнэлгээ ба судалгааны бэлтгэлийг санхүүжүүлэх УУДБХОД төслийн хамрах хүрээг зөрчсөн гэсэн хүсэлт гаргагчдын гомдолтой удирдлага санал нийлэхгүй байгаа. МУ-ын дэд бүтцийн хэрэгцээний талаарх олон төрлийн судалгаа, төлөвлөгөөнд дурдсанаар, иймэрхүү дэд бүтцүүд логикийн хувьд өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлтийг хангах хөрөнгө оруулалтанд багтдаг.

49. УУДБХОД төслийн ТҮББ төслийн цар хүрээг уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих бэлтгэлтэй холбоотой санхүүжилтийн судалгаа хэмээн тодорхойлсон байдаг: “Эрчим хүч, тээвэр, Мэдээллийн технологи ба харилцаа холбоо, ус, орон сууц ба нийгмийн салбар дахь төслүүд боломжтой, түүнчлэн логистик болон хилийн хэрэгслүүд боломжтой. Мөн дараагийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, зэс хайлуулах үйлдвэр, төмөр бөмбөлгийн үйлдвэр гэх мэт нэмүү өртөг шингээх үйл ажиллагаанд үнэлгээ ба бүтээн байгуулалт (хувийн хөрөнгө оруулалтад) хийхэд мөн санхүүжилт хийх боломжтой” (ТҮББ, 89-р догол мөр). Эдгээр тэргүүлэх чиглэлүүдийг 2009 онд хийгдсэн ӨГДБС-ны зөвлөмжүүдэд үндэслэн сонгосон ба Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөмжүүдтэй ч нийцэж байгаа юм.

50. УУДБХОД төслийн Бүрэлдэхүүн-1-ийн хүрээнд 6 дэд төслийг үнэлж, судлах хэрэгтэй гэж ТУХ үзсэн ба УУДБХОД төслийн бүтцийн өөрчлөлтийн баримт бичигт тусгагдаж, улмаар 2014 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Зөвлөлөөр нэмэлт санхүүжилт батлагдсан.

УУДБХОД төслийн үйл явцын талаарх сул талууд

51. УУДБХОД төслийн үйл явцыг сайн бус гэж шүүмжилж байгаатай удирдлага санал нийлэхгүй байна. УУДБХОД төсөл нь Банкны бодлого ба журмыг баримталдаг. Мөн төлөвлөх явцдаа цуврал судалгаа хийдэг, боломжит хувилбаруудад нь нарийвчилсан дүн шинжилгээ хийдэг, төслийн дүн шинжилгээний явцад нөлөөллийг хэмждэг зэрэг томоохон дэд бүтцийг хөгжүүлэх талаар олон улсын тэргүүн туршлагыг хэрэгжүүлдэг. 16-19-р догол мөрүүдэд илүү дэлгэрэнгүй дурьдсанчлан, хэд хэдэн яамдыг хамарсан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар удирдуулсан ТУХ нь төслийг ерөнхийд нь удирддаг. ТУХ сонгогдсон 6 дэд төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх олон шатат журмыг бий болгосон. Хүснэгт 1-ийг харна уу.

Хүснэгт 1. Судалгаа хийх үе шат

Орхон Говь	Хийгдсэн судалгаануудыг нягтлах, ба урьдчилсан судалгаа хийх	Урьдчилсан ТЭЗҮ/ТЭЗҮ болон БОННУ	
Шүрэн	Хийгдсэн судалгаануудыг нягтлах	Урьдчилсан ТЭЗҮ	ТЭЗҮ болон БОННУ
Бусад дэд төслүүд	Хийгдсэн судалгаануудыг нягтлах	ТЭЗҮ болон БОННУ	

52. Төлөвлөсөн дэд төслүүдийн Үнэлгээ судалгааны ихэнхэд нь⁹ 2 үе шаттай үнэлгээний аргыг бий болгосон. 1-р үе шат нь өмнө нь хийгдсэн судалгаануудыг нягтлах, 2-р үе шат нь ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх асуудал хамрагдана. 1-р үе шатанд дэд төслүүдийн талаар өмнө нь хийгдсэн судалгаануудыг нягтлах үйл ажиллагаа хийгдэх ба үүнд техник, санхүү ба байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, болон төслийн өөр боломжит хувилбаруудын талаар авч үзнэ. Энэ үе шатанд байгаа мэдээллүүдийн талаар баримт цуглуулах, өмнө нь хийгдсэн судалгаануудыг нягтлах ажиллагаа хийсэн талаар тайлан гаргах асуудал мөн хамрагдана. Дараагийн шатны үнэлгээ хийх ажлын даалгавар гаргахад байгаа мэдээлэл хангалтгүй бол, 1-р үе шатанд мөн тодорхой техникийн судалгаануудыг хийдэг. Өмнө нь хийгдсэн судалгаануудыг нягталсан талаар ажлын тайлангаас гадна 1-р үе шатнаас гарсан үр дүнгүүд нь 2-р үе шатанд хийгдэх ТЭЗҮ болон холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх ажлын даалгаварт багтана. 1-р үе шатанд мөн ТУБ-ийн зөвлөхүүдтэй хамтран өмнөх судалгаануудыг нягтлах явцад зохион байгуулсан дэд төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, мэдээлэл цуглуулах, байгаль орчин, нийгмийн үнэлгээний талаар хэлэлцүүлгийг эхлүүлэх сурталчлах арга хэмжээ гэх мэт оролцогч талуудтай хийх уулзалтууд болон ТЭЗҮ болон БОННУ боловсруулах ажлын даалгавар бэлтгэх үеийн байнгын уулзалтууд хийгддэг. 2-р үе шатанд дор дэлгэрэнгүй авч үзэх БОННУ бэлтгэх үеийн нэмэлт уулзалтууд ч хийгддэг.

53. Өмнө нь дурьдсанчлан Шүрэнгийн судалгаа нь нэмэлт *урьдчилсан ТЭЗҮ боловсруулах* үе шаттай. 1-р шатны үр дүнд боломж болоод санхүүгийн байдлыг нягтлах судалгаа хийгдэх, мөн 2-р үе шатанд хийгдэх урьдчилсан ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын даалгавар боловсруулах ажил багтана. Урьдчилсан ТЭЗҮ боловсруулах судалгаа 2014 онд хийгдсэн ба 3-р шатанд хийгдэх ТЭЗҮ боловсруулах судалгаа ба байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх нарийвчилсан ажлын даалгавар боловсруулагдаж байна. 2-р үе шат хараахан дуусаагүй байгаа ба ТЭЗҮ болон БОННУ боловсруулах зөвлөхийн тендер хараахан эхлээгүй байна. Дээр дурдсанчлан мөн доор дэлгэрэнгүй авч үзэхчлэн, Шүрэнгийн судалгаа нь явцын туршид оролцогч талуудтай уулзалтуудыг зохион байгуулна.

54. Орхон Говийн судалгаа нь 3 үе шаттай. Гэхдээ Орхон говийн дэд төслийн цогцолборын мөн чанар болон говийн бүс дэх гүний усны нөөцийн талаар мэдээлэл хангалтгүйгээс болоод өмнө нь хийгдсэн судалгаануудыг нягтлах 1-р үе шатыг өргөжүүлж урьдчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд авч үзэх олон хүчин зүйлсийн талаар судлах *урьдчилсан судалгаа* хийх болсон. Боломжит байршлуудын хувилбаруудын талаарх дүн шинжилгээ гэх мэт урьдчилсан ТЭЗҮ судалгааны зарим чухал зүйлсийг илүү мэдээлэл авсны дараа ТЭЗҮ боловсруулах судалгааны нэг хэсэг болгон хийх болно. Орхон Говийн судалгаанд иймэрхүү арга хэмжээ

⁹ Дархан-Сэлэнгийн төвийн бүсийн хар төмөрлөгийн цогцолбор; Багануур ХХК-ний нүүрсний уурхайн өргөтгөл; Өмнөд говийн бүс нутгийн унд, ахуй, үйлдвэрийн усан хангамжийн систем; Нийлэг байгалийн хийн үйлдвэр

авах болсон шалтгаан нь тогтвортой үр дүнд хүрэхийн тулд мэдээлэл хангалттай үед л дүн шинжилгээ хийх ба иймэрхүү дүн шинжилгээ нь УУДБХОД төслийн бүрэлдэхүүн 3-ийн хүрээнд хийгдэж буй гүний усны үнэлгээний ажилтай нэгдэж, холбогдох юм. 2013-2014 онуудад 1-р үе шатны урьдчилсан судалгаа хийгдсэн ба 3-р үе шатанд хийгдэх нэгтгэсэн урьдчилсан ТЭЗҮ/ТЭЗҮ боловсруулах судалгаа болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний нарийвчилсан ажлын даалгаврыг боловсруулсан. 2-р шат хараахан дуусаагүй байгаа ба 3-р шатны зөвлөхүүдийн тендер хараахан эхлээгүй байна.

55. Бүх үнэлгээний судалгааны хувьд, ТУХ болон банкны шийдвэрүүд тусгагдсан. Дэд төслүүдийг нягтлах 1-р шатны гол зорилго нь ТУХ-г дараагийн шатны судалгаа, урьдчилсан ТЭЗҮ эсвэл ТЭЗҮ боловсруулах судалгаа хийхийг үргэлжлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл өгөх явдал. Нэгэнт дэд төслүүд нягтлах үе шатыг давсан бол ТУХ нь төлөвлөсөн дэд төслүүдийн үр дүнгийн талаар дэлгэрэнгүй болон дараагийн шатны сайн судалгаа хийх нь зүйтэй ба ингэснээр Банкаас татгалзсан хариу авахгүй гэдгийг зөвлөдөг. Шүрэнгийн судалгааны хувьд, бүтэн ТЭЗҮ боловсруулах болон түүнтэй холбоотой үнэлгээ эхлүүлэхээс өмнө нэмэлтээр урьдчилсан ТЭЗҮ боловсруулах үе шатыг оруулж ирсэн. Мөн нэмэлт санаанууд ч хийгдсэн. Тиймээс Шүрэн болон Орхон говийн дэд төслүүдийн ТЭЗҮ болон байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх зөвлөмжийг ТУХ гаргаж үүнийг нь Банк урьдчилсан ТЭЗҮ боловсруулах судалгаа болон урьдчилсан судалгаа хийгдсэний дараа буюу 2014 оны 11 дүгээр сарын 20-нд баталгаажуулсан. Үүний дүнд Шүрэн болон Орхон говийн дэд төслүүдийн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын даалгавруудад Банк зөвшөөрлөө 2015 оны 2-р сарын 9-нд болон 2015 оны 2-р сарын 25-ны өдрүүдэд тус тус өгсөн. Орхон говийн дэд төслийн хувьд, хийсэн урьдчилсан судалгаан дээр үндэслээд ТУХ урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, ТЭЗҮ боловсруулах ажлыг нэгтгэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргасан.

56. ДБ-ны бодлого, журмын БОННУ (байгаль орчны үнэлгээ) боловсруулах ажлын даалгаварыг эцэслэх, байгаль орчны үнэлгээний тайлангийн төсөл гарахаас өмнө олон нийттэй зөвлөлдөх шаардлагатай. Хүсэлтэд дурдсанаар, Шүрэнгийн судалгаа болон Орхон Говийн судалгаануудын аль алиных нь ажлын даалгаврын төсөлд БОННУ боловсруулах асуудал орсон. Удирдлага өнөөдрийг болтол Шүрэн эсвэл Орхон говийн судалгааны аль алиных нь хэсэг болж ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний аль нь ч хийгдээгүй болохыг хэлж байна.

57. Хэдийгээр дэд төслүүдийн аль нь ч ТЭЗҮ болон БОННУ боловсруулах ажлаа дуусаагүй байгаа боловч дээр 20-р догол мөрд дурдсанчлан судалгаануудыг хянах, үнэлэх үе ажлууд хийгдсэн.

Бусад хувилбаруудад хангалттай дүн шинжилгээ хийгээгүй.

58. Дэд төслүүдийн боломжит хувилбаруудад хангалтгүй дүн шинжилгээ хийсэн гэсэн хүсэлт гаргагчдын гомдолтой удирдлага санал нийлэхгүй байна.

59. УУДБХОД төслөөр дамжин МУ томоохон эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн замаар явж байна гэж удирдлага цохон тэмдэглэсэн. Нэгдүгээрт, дэд төслүүдийн үнэлгээ, судалгаанд, анхны хувилбар нь үндэсний мастер төлөвлөгөө, хийгдсэн судалгаануудыг *нягтлах, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах* зэрэг үе шатуудыг нарийвчлан гаргасан. Одоо УУДБХОД төсөл нь 22-р догол мөрд дурдсан 6 дэд төслүүдийн Үнэлэх Судалгааг дэмжин ажиллаж байна. Хоёрдугаарт, Үнэлэх судалгаа нь өөрөө 6 дэд төслүүдийн боломжит хувилбаруудад дүн шинжилгээ хийнэ.

60. ***Шүрэнгийн судалгаа.*** Шүрэн дэд төслийн хувилбарын талаар ТУХ сонголт хийхдээ үндэслэсэн гол дүн шинжилгээ бол УУДБХОД төсөл эхлэхээс өмнө 2010 онд эхлүүлсэн,

2012-2013 онд явцын үр дүн, тайлангууд нь гарсан Эрчим хүчний салбарын төлөвлөгөө юм. Мөн Эрчим хүчний салбарын төлөвлөгөө нь Шүрэн дэд төслийн боломжит хувилбаруудын эх үүсвэр болж байгаа ба мөн нягтлах, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, ТЭЗҮ боловсруулах үе шатуудад байнгын харьцуулах эх үүсвэр болж байна.

61. Шүрэнгийн судалгааны (урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгаанд) хүрээнд өнөөдрийг болтол хийсэн хувилбаруудын үнэлгээнүүд нь Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөмжүүдтэй нийцэж байгаа талаар удирдлага цохон тэмдэглэсэн. Шүрэн дэд төслийн 2 гол боломжит хувилбар нь МУ дахь нүүрс шатаадаг цахилгаан станцыг хөгжүүлэх мөн ОХУ-ын усан цахилгаан станцуудаас импортлодог эрчим хүчийг нэмэгдүүлэх явдал. Эдгээр боломжит хувилбарууд нь магадгүй эдийн засаг болоод санхүүгийн хувьд хамгийн боломжтой хувилбарууд болох ба эрчим хүчийг өндөр хүчин чадлаар хүргэх Шүрэн дэд төсөлтэй ойролцоо боломжтой. Урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны нэг хэсэг болж эдгээр хувилбаруудыг Шүрэн дэд төслийн хамгийн сайн хувилбаруудтай харьцуулсан. Уг Шүрэн төслийн хамгийн сайн хувилбаруудыг Сэлэнгэ голын усан цахилгаан станцын хувилбаруудад хийсэн дүн шинжилгээгээр тодорхойлсон. Өөр өөр байршлуудын нөхцөл байдлууд (байр зүй, геологи, байгаль орчин ба нийгмийн асуудлууд)-аас болоод өөр өөр шийдэл (усан сангийн хэмжээ, далангийн өндөр гэх мэт), зардал, эрчим хүч түгээх чадваруудыг бий болгоно. Тиймээс Шүрэн төслийн тодорхой байршлын хувилбаруудыг бусад усан биш эрчим хүчний хувилбаруудтай харьцуулах нь чухал.

62. Урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны үед хийгдсэн дүн шинжилгээн дээр үндэслэсэн эдгээр хувилбаруудад хийсэн үнэлгээний үр дүн нь Шүрэн дэд төслийн хамгийн боломжит байршил нь нүүрс түлдэг цахилгаан станц эсвэл ОХУ-с импортлох эрчим хүчтэй харьцуулахад хүчтэй өрсөлдөгч байсан. Тиймээс эдгээр хувилбаруудад хийсэн үнэлгээ нь хөгжлийн төлөө Шүрэн төслийг илүүд авч үзсэн Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөмжүүдийг батлан харуулсан.

63. Шүрэн дэд төслийн хамгийн сайн байршил болоод тогтцын хувьд, урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгаа нь бага далантай, том далантай гэсэн 2 боломжит хувилбарыг тодорхойлон гаргасан. Гэхдээ Үнэлгээ хийх судалгааны урьдчилсан ТЭЗҮ боловсруулах явцад олсон мэдээллээс харахад, эдгээрийг тэргүүлэх ач холбогдолтой гэж дүгнэлт хийх боломжгүй байна. Тиймээс урьдчилсан ТЭЗҮ боловсруулах судалгааны эцсийн зөвлөмжид эдгээр 2 байршлуудын хувьд аль алинд нь нарийвчилсан хяналт шалгалт, үнэлгээ хийх асуудлыг багтаасан ТЭЗҮ боловсруулах судалгаа хийх, мөн аль байршил нь давуу талтай болохыг хэлэх хэрэгтэй гэж зөвлөсөн. ТЭЗҮ болон БОННУ боловсруулах судалгааны ажлын даалгаварт энэхүү зөвлөмжийг тусгасан ба зөвлөхүүдийг энэхүү асуултад тусгайлан анхаарал хандуулах хэрэгтэй гэж үзсэн.

64. **Орхон Говийн судалгаа.** УУДБХОД төслийн хүрээнд сонгогдон судлагдаж буй Орхон Говийн дэд төсөл нь Монголын өмнөд говийн бүс нутгийн усан хангамжийг урт хугацаанд тогтвортой хангахын зэрэгцээ усан эрчим хүч үйлдвэрлэх боломжийг санал болгож буй олон талт төсөл юм. Уг дэд төсөл нь Орхон голыг түшиглэн усан цахилгаан станц байгуулах үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлүүдийн нэг хэмээн тодорхойлсон Эрчим хүчний салбарын төлөвлөгөөтэй нийцэж байна.

65. УУДБХОД төслийг эхлүүлэхээс өмнө Говийн бүсийн усны эрэлт хэрэгцээ 2010 онд хоногт 50000 м³ байсан бол 2020 онд хоногт 350,000 м³ болж огцом өснө хэмээн урьдчилсан тооцож байсан. Гэвч тухайн үед энэ бүс нутгийн хөрсөн дорх гүний усны эх үүсвэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байлаа. ӨГДБС 2009 онд энэхүү хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан 2020 он хүртэлх эрэлтийг хангахуйц гүний усны нөөцтэй байх магадлалтай гэж дүгнэж байсан хэдий ч илүү урт хугацааны хэрэгцээг хангахад гүний усны

нөөц хүрэлцэхгүй байж болзошгүй тул гадаргын ус тухайлбал, Орхон голын усыг дамжуулан ашиглах шаардлага гарах болно.

66. Иймд тухайн бүс нутгийн гүний усны нөөцийг эрэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийх анхны боломжийг олгосноороо Орхон Говийн төслийн бэлтгэл судалгаа чухал ач холбогдолтой байлаа. Уг дүн шинжилгээний үр дүнд дараах дүгнэлтүүдийг гаргасан байна. Үүнд (1) Говийн бүсийн гүний усны дорвитойд тооцогдох ихэнх нөөц нь дарагдмал ус¹⁰ тул түвшинд нь нөлөөлөхгүйгээр хүрч ашиглах боломжгүй; (2) 2020 он гэхэд усны хэрэглээ гүний усны нөөцийн хэмжээнээс давж гарах хандлагатай; (3) гүний усны нөөцийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл, урьдчилан тооцсон эрэлт хэрэгцээг хангах бусад боломжит хувилбаруудын дүн шинжилгээ нэн шаардлагатай байна гэж дурьджээ. Эдгээр дүгнэлтүүдээс үзэхэд анх төсөөлж байсанчлан гүний усны нөөцөнд найдах бус гадаргын усны эх үүсвэрээр говийн бүсийн усны хангамжийн асуудлыг шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болоод байгаа тул Орхон Говийн төслийн үнэлгээ, судалгааг үргэлжлүүлэх нь ач холбогдолтойг харуулж байна. Говийн бүс нутгийн гүний усыг үр ашигтай аль болох тогтвортой ашиглахын ач холбогдлыг Удирдлага хүлээн зөвшөөрч байна. Иймд Төслийн (Бүрэлдэхүүн хэсэг 3) усны нөөцийн зохистой удирдлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээр Австрали улсын Засгийн газрын зүгээс ГХХЯ-аараа дамжуулан олгож буй нэмэлт төслийн санхүүжилт нэн ач холбогдолтой юм.

67. Орхон Говийн судалгаа үргэлжлэхийн хирээр уг дэд төслийг хэрэгжүүлэх боломжит хувилбаруудыг эрчим хүчний нэмэлт эх сурвалж бус усны нэмэлт эх үүсвэр гэдэг талаас нь ач холбогдол өгч үнэллээ. Цаашилбал, Орхон голын аль хэсгийг сонгох вэ, усны голдрилыг хаагуур явуулах вэ, Говийн аль хэсэгт усны хэрэгцээ хамгийн их байх вэ зэрэг олон тодорхойгүй асуудлууд байсан тул санал болгож буй Орхон Говийн дэд төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн судалгааг урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ-г хийж эхлэхээс өмнө эхлүүлсэн. Энэхүү бэлтгэл судалгааны цар хүрээ анхан шатны түвшинд хийгдэх судалгааны түвшнээс хальж хүлээлтээс давсан үр дүн өгснийг Удирдлага оновчтой алхам болсон гэж үнэлж байна.

68. Бэлтгэл судалгааны хүрээнд Говийн бүсийг усаар хангах хувилбаруудыг харьцуулан судалж, усны хэрэгцээ өндөр цэгүүд рүү Орхон голоос хоолойгоор гадаргын усыг татах болон орон нутгийн гүний усны нөөцийг ашиглах хувилбаруудыг хослуулах нь нөөцийн хэмжээ, технологийн боломж, хүрээлэн буй орчинд болон нийгэмд үзүүлэх үр нөлөө, санхүү, эдийн засгийн хувьд хамгийн боломжит шийдэл юм гэж үзжээ. Бэлтгэл судалгаа нь хэрэглээний хамгийн доод ба дээд түвшний нөхцлөөр Орхон голоос нэмэлтээр ус татах хугацаа, хэмжээг тооцох зорилго бүхий Орхон Говийн дэд төслийн урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ-ний ажын даалгавар боловсруулах үндэслэл нотолгоо бий болгож өгсөн юм. Уурхайн цаашдын хөгжил нь усны нөөцийн хэмжээ болон хугацаанаас шууд хамаарах тул хэрэгжих боломжийн судалгаа хамгийн бага болон хамгийн их хэмжээгээр нийлүүлэх нөхцлүүдийг мөн харгалзан үзнэ.

Амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл

69. Хүсэлт гаргагчдын зүгээс амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой хөндөн тавьсан асуудлууд нь Шүрэн ба Орхон Говь дэд төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанаас гарч болох үр дагавартай хамааралтай болохыг Удирдлага тэмдэглэж байна. Шүрэн ба Орхон Говь дэд төслийн байгаль орчин болон нийгмийн нөлөөллийг судлах нь Банкны санхүүжилтээр хийгдэж буй үнэлгээний судалгааны нэг хэсэг мөн.

¹⁰ Дарагдмал усны нөөц гэдэг нь маш олон жилийн өмнө бий болж хадгалагдсан битүүмжлэгдсэн усны давхрага бөгөөд нөхөн сэргээгдэхгүй.

70. **Санал болгож буй Шүрэн төслийн хувьд**, БОННУ нь АД-т заасны дагуу:

- Дэд төслийн нөлөөллийн газар зүйн цар хүрээг тодорхойлох;
- Биет, биологийн, нийгэм эдийн засгийн болон соёлын суурь нөхцөл байдлыг баримтжуулах;
- Тогтоосон суурь түвшнийг өөрчлөхүйц нөлөө бүхий төслийн гол бүтэц, бүрэлдэхүүн, бүтээн байгуулалт, хэрэгжилтийн шатны үйл ажиллагааг тодорхойлох;
- Болзошгүй үр дагаврыг тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тогтоож, дэд төслийн хувилбаруудыг хэлэлцэх нээлттэй уулзалтууд зохион байгуулах;
- Төсөл хэрэгжүүлэх байршлын хувилбаруудыг гарган, хувилбар тус бүрийн эерэг болон сөрөг үр нөлөөг тооцох;
- Байгаль орчин, эдийн засгийн хувьд хамгийн зохистой хувилбарын учруулж болох хамгийн ноцтой сөрөг үр дагаврын дүн шинжилгээ;
- Дэд төсөл хэрэгжүүлэх бүс нутагт байрлах түүх, археологийн дурсгалт газруудыг тодорхойлох;
- Дэд төсөл хэрэгжүүлэх бүс нутагт оршин суудаг нутгийн иргэдэд учирч болзошгүй үр дагаврыг тогтоох;
- Болзошгүй сөрөг үр дагавраас зайлсхийх, эрсдэлийг бууруулах, хохирлыг нөхөх болон эерэг үр нөлөөг сайжруулах үр ашигтай, өвөрмөц, хэрэгжих боломжтой тохирсон арга хэмжээг тодорхойлох;
- Байгаль орчин, нийгмийн сөрөг үр дагаврын эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээг гаргаж, удирдлага зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, аудитын механизмыг тодорхойлон, төлөвлөлтийг хийх;
- Санал болгож буй дэд төслийн байгаль орчин, нийгмийн үр нөлөөг тооцон хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар нэгдсэн зөвлөмж гаргах.

71. Хуул эрх зүй, бодлогын дүн шинжилгээ. Шүрэнгийн дэд төслийн хувьд БОННУ-ний АД-т дотоодын хууль эрх зүйн орчин, байгаль орчны олон улсын хэмжээний гэрээ хэлэлцээр, хоёр талт гэрээ хэлэлцээр болон Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлогын холбогдох шаардлагуудыг хэрэгжүүлэхээр хүлээх үүрэг хариуцлагын үнэлгээ багтсан. Түүнчлэн Банкны бодлого ба Монгол Улсын байгаль орчин, нийгмийн бодлого, хууль журмын харьцуулсан дүн шинжилгээ мөн хийгдэх болно.

72. **Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.** БОННУ-ний хүрээнд Шүрэнгийн дэд төслийн бүтээн байгуулах болон Сэлэнгэ мөрний хавьд ирээдүйд бий болох бусад дэд бүтцийн урт хугацааны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг мөн гүйцэтгэнэ. Үүнд голын голдрилыг өөрчлөхтэй холбоотой гарч болох хуримтлагдсан үр нөлөөг тооцох, Сэлэнгэ мөрөн, Байгаль нуур орчмын нийгмийн үр нөлөөний үнэлгээ бас багтаж байна. Ирэх 20 жилийн хугацаанд Сэлэнгэ мөрний бэлчир цаашилбал Байгаль нуур хүртэлх бүс нутагт бүтээн байгуулах усан болон усан цахилгаан станцын байгууламжийг энэхүү үнэлгээнд хамруулах юм. Түүнчлэн БОННУ-ний хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийн боломжит хувилбарууд (ус, нүүрс, хий болон бусад)-ын үр нөлөөг эрчим хүчний бодлогын түвшинд харьцуулан судална.

73. Шүрэнгийн дэд төслийн БОННУ-ний хүрээнд зөвлөхүүд байгаль орчин, нийгмийн болзошгүй сөрөг нөлөөнөөс сэргийлэх, үр дагаврыг бууруулах, хянах зорилгоор Байгаль орчны удирдлагын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, дэд төслийг хэрэгжүүлэх тохиолдолд гарах зардлын тооцоог хийнэ.

74. **Орхон Говийн дэд төслийн БОННУ.** Санал болгогдож буй Орхоны дэд төслийн БОННУ-ний АД-т заасны дагуу дараахь хэд хэдэн төрлийн үнэлгээг нэгдсэн зохицуулалттайгаар гүйцэтгэх юм. Үүнд: (1) Орхон-Сэлэнгийн ай савд голын гольдрил өөрчлөн, хагас хуурай өмнийн говийн бүс нутагт усны нэмэлт үүсвэр бий болгохтой холбоотой гарч болох үр дагаврыг тооцох Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ (ББОУ); (2) дэд төслийн бие даасан доорх 3 бүрэлдэхүүн хэсэгт тус бүрт хийх БОННУ

- Усны голдрилыг зохицуулах ба нөөцийн байгууламж;
- Ус дамжуулах хоолой, шахуургын станцууд;
- Усан цахилгаан станц, эрчим хүчний шугамууд.

75. Орхон Говь дэд төслийн БОННУ-ний АД-ын төсөлд дараахь даалгаврууд орсон байна:

- Орхон, Сэлэнгийн урсгалын дагуух усны чанар голдрил өөрчилсөнтэй холбоотой гарч болох өөрчлөлтүүдийн үр нөлөө, Байгаль нуурт үзүүлэх нөлөөллийг үнэлэх;

- Дэд бүтэц, төслийн байгууламжууд тухайлбал, усны нөөцийн байгууламж, ус татах бүтэц, усан цахилгаан станц, ус дамжуулах хоолой, шахуургын станцууд, зам, эрчим хүчний шугам зэргийг барих, үйл ажиллагаа явуулах үеийн байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийг үнэлэх;
- Дэд төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн газрын өнөөгийн нөхцөл, ашиглалтын төлөв байдлыг тодорхойлох;
- Төслийн байгууламж, ус дамжуулах хоолой, усны нөөц байрших газрын орчин дахь түүх археологийн дурсгалт газруудыг тогтоох;
- Газар эзэмших эрх авах хэрэгцээ, нүүлгэн шилжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодруулах;
- Дэд төсөл хэрэгжүүлэх бүс нутагт оршин суудаг нутгийн иргэдэд учирч болзошгүй үр дагаврыг тогтоох;
- Дэд төсөлд хамаарах Монгол Улсын нэгдсэн орсон байгаль орчны чиглэлээрх олон улсын хэмжээний конвенц, гэрээ хэлэлцээр, хоёр талт гэрээ, холбогдох дотоодын хууль, дүрэм, журмууд, бодлогын баримт бичгүүд, үндэсний хөтөлбөрийг шинжлэх, Дэлхийн банкны байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлого ба Монгол Улсын холбогдох хууль журмын нийцлийн харьцуулсан дүн шинжилгээ хийх.

76. Дээрх үнэлгээ, дүн шинжилгээний дүнд тулгуурлан зөвлөхүүд учирч болох сөрөг үр дагавраас сэргийлэх, үр нөлөөг бууруулах зорилго бүхий байгаль орчны удирдлагын төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, хэрэв шаардлагатай бол нутгийн иргэдийн хөгжлийн төлөвлөгөөг сонирхогч талууд, нөлөөнд өртөх боломжтой хүн амын санал, зөвлөмжийг тусган боловсруулна.

77. Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн БОННУ-ний АД-ыг нээлттэй хэлэлцүүлэх үйл явц үргэлжилсээр байгаа бөгөөд хэлэлцүүлгийн үед сонирхогч талуудаас гаргасан саналыг тусган эцэслэн боловсруулна гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

78. Эцэст нь, Банк УУДБХОД Төслийн хүрээнд санхүүжилт авсан судалгаа, үнэлгээнд хамрагдаж буй эдгээр дэд төслүүдийг санхүүжүүлэх амлалт өгөөгүй гэдгийг Удирдлага дахин тэмдэглэхийг хүсэж байна. Гэвч, Удирдлага МУЗГ-ыг санал болгож буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох, бууруулахад чиглэсэн арга хэмжээ авахад шаардлагатай судалгаа, дүгнэлтийг хийх боломж бүрдүүлэх зорилго бүхий Үнэлгээний судалгааг бүрэн гүйцэтгэх нөхцлөөр ханган, эдгээр дэд төслүүдийг дэмжин, хэрэгжүүлэх талаар нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх болно.

Хил дамнасан нөлөөлөл

79. Банкны Бодлого ОР 7.50 нь санал болгогдож буй 6 дэд төслийн 2-т нь буюу Шүрэн, Орхон Говь дэд төслүүдтэй холбоотойгоор УУДБХОД төсөлд хамаарах юм. Орхон гол Сэлэнгэ мөрөнтэй нийлэн, зүүн хойшоо чиглэн урсаж ОХУ-ын нутаг дэвсгэрт байрладаг дэлхийн хамгийн том бөгөөд гүн цэнгэг уст нуур болох Байгал нуурт цуцадаг тул дурьдсан дэд төслүүд нь хил дамнасан үр дагавар, үр нөлөөтэй байх магадлалтай гэж үзэж байна.

80. Бодлого ОР 7.50 нь (а) олон улсын усан замыг ашиглах, бохирдуулах үйл ажиллагаа бүхий ба/эсвэл (б) ийм төслийн судалгааны ажил хийхээр төлөвлөж буй төслүүдэд шууд хамаарна. Ийм төслийн хувьд тухайн гол/усны судалбарын эрэг дагуух бүх улс орнуудад мэдэгдэл хүргүүлэх ёстой. Зөвхөн ийнхүү мэдэгдэхгүй байхыг зөвтгөх нөхцлийг хангасан тохиолдолд мэдэгдэл өгөхгүй байж болно. 3 нөхцөлд мэдэгдэл хүргүүлэхгүй байж болно гэж энэхүү бодлогод заасан байдаг. Тухайн судалгаа уг Бодлогын 7 (b)-д заасны дагуу зөвхөн "төслийн хүрээнд усны эх

үүсвэрийн судалгаа хийх, олон улсын усан замд чиглэсэн эсвэл холбоотой ТЭЗҮ"-г санхүүжүүлж буй тохиолдолд мэдэгдэл хүргүүлэхгүй байх нэг үндэслэл нь юм. Энэ тохиолдолд эрэг дагуух улс орны хувьд хөндөгдөж болох асуудлуудыг үнэлгээ, судалгааны АД-т заавал багтаасан байх шаардлага тавьдаг.

81. Төслийн хүрээнд санхүүжүүлэх үйл ажиллагааны төрөл хэлбэрийг харгалзан үзээд дурьдсан Бодлогын заалтыг үндэслэн УУДБХОД төслийн хувьд эрэг дагуух бусад улс орнуудад мэдэгдэл хүргүүлэхгүй байхыг Удирдлага 2013 оны 8 сарын 23-ны өдөр зөвшөөрсөн билээ. Иймд тухайн Бодлогод заасны дагуу санал болгож буй 2 дэд төслийн БОННУ-ний АД-т эрэг дагуух улс орны асуудлыг тусгасан болно.

82. МУЗГ нь Шүрэн, Орхон Говийн дэд төслийн асуудлаар ОХУ-ын эрх бүхий байгууллагатай 2 талт хамтын ажиллагааны шугамаар холбогдсон болохыг Удирдлага онцлон тэмдэглэж байна. Нэгт, 2014 оны 6 сарын 20-ны өдөр Банкнд ирүүлсэн албан захианд МУЗГ санал болгож буй 2 төслийн талаарх мэдээллийг ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яаманд хүргүүлсэн болохыг мэдэгджээ. Хоёрт, 2014 оны 8 сарын 21-ний өдөр Монгол Улсын Эрчим хүчний яам ОХУ-ны Шинжлэх ухааны академитай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг (ХОС)-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт Сэлэнгэ мөрний ай сав дагуу усан цахилгаан станц байгуулахтай холбоотой гарч болх байгаль, ус, эрчим хүч болон нийгэм эдийн засгийн үр дагаврыг тооцож үнэлэх цогц судалгааг хамтран гүйцэтгэнэ" хэмээн заасан байна. Гуравт, 2014 оны 8 сард ОХУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газартай хийсэн 2 талт ярианы үеэр Сэлэнгэ мөрний ай савд усан цахилгаан станц байгуулах тухай асуудал хөндөгдсөн талаар олон нийтэд нээлттэй мэдээлснийг Удирдлага тэмдэглэж байна. Дөрөвт, ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яамны Дэд сайдаар ахлуулсан төлөөлөгчид Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мөн Дэд сайдаар ахлуулсан төлөөлөгчидтэй Улаанбаатар хотноо 2015 оны 3 сарын 30-31-ний өдрүүдэд уулзсан юм. Энэ уулзалтын үеэр талууд Шүрэнгийн дэд төслийн үнэлгээний чиглэлээр хамтран ажиллах протоколд гарын үсэг зурцгаажээ.

83. Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний намгархаг газар нь Дэлхийн өвийн конвенци¹¹, Рамсарын конвенци¹²-оор хамгаалагдсан байдаг. Банк эдгээр газруудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхийн сацуу олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу МУЗГ-ын хүлээсэн үүрэгтэй холбогдуулан УУДБХОД Төслийг хэрэгжүүлэх хугацааны туршид үйл ажиллагаанд нь хяналт тавьж байгаа болно. Мөн 2014 оны 6 сарын 15-25-ны өдрүүдэд Катарын Доха хотноо зохион байгуулагдсан Дэлхийн өвийн хорооны 38 дахь удаагийн чуулганд Сэлэнгийн ай савтай холбоотой МУЗГ-ын төлөвлөгөөний талаар тайлагнах ЮНЕСКО-ийн хүсэлтэд МУЗГ-ын өгсөн хариулт болон Дэлхийн өвийн хорооны 38 СОМ 7В.76 тоот шийдвэрийг Банк онцлон дурьдаж байна. Банкны хүсэлтээр МУЗГ олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2014 оны 6 сарын 20-ны өдөр Банкнд ирүүлсэн болно. Уг захианд Монгол Улс болон Дэлхийн өвийн хорооны хооронд солилцсон албан бичгүүдийн хувийг хавсаргасан байв.

84. Хүлээж авсан мэдээллийг хянаж үзээд Удирдлага УУДБХОД Төслийн хүрээнд Шүрэн, Орхон Говь дэд төслүүдтэй холбоотой мөрдөж хэрэгжүүлсэн арга хэмжээ Дэлхийн өвийн хорооны 38 СОМ 7В.76 тоот шийдвэрт заасан зөвлөмжүүд тухайлбал эдгээр дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохих ёсоор үнэлэх, үнэлгээний дүнг дэд төслүүдийг хэрэгжүүлэх эсэх талаарх шийдвэр гарахаас өмнө олон нийтэд нээлттэй мэдээлэх гэсэнтэй нийцэж байна гэж дүгнэлээ. Түүнчлэн Дэлхийн өвийн хорооноос өгсөн зөвлөмжүүд нь Дэлхийн банкны Хамгааллын бодлоготой бүрэн нийцэж байгааг Удирдлага тэмдэглэхийг хүсэж байна.

85. Сэлэнгэ голын ай сав дагуу усан цахилгаан станц байгуулахтай холбоотой үүсэж болох хуримтлагдах нөлөөний талаар Хүсэлт гаргагчдын хөндөн тавьсан асуудлыг Удирдлага мөн чухал хэмээн хүлээн зөвшөөрөхийн сацуу УУДБХОД Төсөл энэ асуудлыг Шүрэн дэд төслийн хүрээнд Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, Орхон Говь дэд төслийн хүрээнд БОННУ-ний нэг хэсэг болох

¹¹ Байгаль нуур Дэлхийн өвийн жагсаалтад 1996 онд бүртгэгдсэн.

¹² Сэлэнгэ мөрний намгархаг газар нь Рамсарын олон улсын намгархаг газрын жагсаалтад 1994 онд бүртгэгдсэн.

бүс нутгийн байгаль орчны үнэлгээг тус тус гүйцэтгэх замаар тусгаж байгааг онцлон тэмдэглэж байна.

86. Хил дамнасан нөлөөлөл болон Байгаль нуурт үзүүлэх өвөрмөц нөлөөллийг судлан үзэх шаардлагыг Шүрэн, Орхон говь дэд төслийн БОННУ-ний АД-т тодорхой тусгаж өгөх болно. Шүрэн дэд төслийн БОННУ-ний АД-т туссан тодорхой жишээг Хавсралт 1-с харна уу.

Зөвлөлдөж, мэдээллэхтэй холбоотой дутагдлууд

87. УУДБХОД Төслийн хүрээнд хийгдэж буй Үнэлгээний судалгааны бүх үе шатанд зөвлөлдөх болон мэдээллийг нээлттэй байлгах үйл явцыг хэрэгжүүлэх Банкны Хамгааллын болон Мэдээллийн хүртээмжтэй байдлын бодлогод тавьсан шаардлагатай нийцэж буй эсэхэд Банк тогтмол хяналт тавьж байна. Удирдлага УУДБХОД Төсөл нь Банкны холбогдох бодлого, журмын шаардлагыг хангаж байгаа гэдгийг батлаж байгааг илэрхийлэх хүсэлтэй байна.

88. Банк УУДБХОД Төслийн ТҮББ, БОНУХ, Хамгааллын нэгдсэн хүснэгт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (түүний хянасан хувиуд), төслийн зохион байгуулалтыг өөрчлөх, нэмэлт санхүүжилтийн төслийн баримт бичиг, Хэрэгжилтийн явцын тайлан зэрэг баримт бичгүүдийг нийтэд ил тодоор хүргээд байна. Түүнчлэн МУЗГ-ын зүгээс БОНУХ (Англи Монгол хэлээр), санал болгож буй дэд төслүүдийн АД-ын төслүүдийг (Англи Монгол хэлээр) тус тус олон нийтэд нээлттэй болгосон болно.

89. Банкны баримталдаг бодлого, процедурын дагуу хүлээн авагч нь төсөл хэрэгжүүлэх боломжийн урьдчилсан ТЭЗҮ-г нийтэд ил болгох шаардлагагүй хэдий ч Банкны зүгээс УУДБХОД Төслийн санхүүжилтээр хийгдсэн судалгааны үр дүнгээс аль болох их мэдээллийг олон нийтэд түгээж байхыг ТУБ-т зөвлөдөг.

90. Өнөөг хүртэл бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх хүсэлт тавьсан ТББ-уудын төлөөлөлтэй (түүний дотор Хүсэлт гаргагчдын нэг багтсан) хийсэн уулзалтын үр дүнд үндэслэн Банк МУЗГ-ыг Банкны бодлогод зааснаас гадуурх нэмэлт мэдээллүүдийг ил болгохыг хэд хэдэн удаа зөвлөсөн болно (тухайлбал Шүрэн дэд төслийн хэрэгжүүлэх боломжийн урьдчилсан ТЭЗҮ-ний тайлан болон бусад үйлчлүүлэгчийн эрх мэдэлд байдаг бусад мэдээллүүд). Түүнчлэн ТУБ, Эрчим хүчний яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай Хүсэлт гаргагчдын нэг болон бусад сонирхогч талууд нүүр тулан уулзах уулзалтуудыг зохион байгуулахад Банк санаачлага гарган дэмжлэг үзүүлсэн билээ.

91. ТУБ нь мэдээллийг нээлттэй солилцох боломж бүрдүүлэх үүднээс УУДБХОД Төслийн веб хуудсыг (Монгол, Англи хэл дээр) ажиллуулж байна. Гэвч уг веб хуудсын байнгын үйл ажиллагааг илүү сайжруулах боломжтой гэж Удирдлага үзэж байна. Банкны зүгээс ТУБ-т олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулах, төслийн веб хуудсыг илүү хүчирхэг мэдээллийн солилцооны хэрэгсэл болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн ажилтан ажилуулахыг зөвлөмж болгосон болно.

92. Банк ТУБ-ийн үйл ажиллагаанд тогтмол дэмжлэг үзүүлж, чадавхийг нь бэхжүүлэхэд анхаарч ирсэн болохоо Удирдлага батлан илэрхийлж байна. Санал болгож буй Шүрэн (2015 оны 1 сарын 16), Орхон Говь (2015 оны 1 сарын 29) дэд төслүүдийн БОННУ-ний АД-ын хэлэлцүүлгийг Улаанбаатар хотноо тус тус зохион байгууллаа. Мөн сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр сургалтыг 2015 оны 1 сарын 13-нд Улаанбаатар хотод хийсэн болно.

93. Дээрх арга хэмжээг жишигт нийцүүлэн зохион байгуулсан бөгөөд ТББ-ын төлөөллүүд, байгаль орчин, нийгмийн хөдөлгөөний идэвхтнүүд, өвөрмөц сонирхлын бүлгүүд, орон нутгийн Удирдлагын төлөөллүүд тухайлбал, холбогдох 4 сумын засаг дарга болон төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон. Дараагийн хэлэлцүүлгийн чанарыг сайжруулах үүднээс ТУБ хэлэлцүүлгийн үйл явцад оролцогчдын зүгээс өгөх үнэлгээг авсан болно.

94. Хэлэлцүүлэх уулзалтыг зөвхөн Улаанбаатар хотод зохион байгуулах нь эхний алхам болохыг хүлээн зөвшөөрч, БОННУ-г дэд төсөл бүрт зохион байгуулах, сонирхогч талуудын дэлгэрэнгүй судалгаа хийж, мэргэжлийн судалгааны чиглэлийг тогтоох, бэлтгэл шатны хэлэлцүүлэгт сонирхогч талуудыг оролцуулж, цаашид зохион байгуулагдах хэлэлцүүлгүүдийн төлөвлөгөө, оролцогч талуудын талаар санал авах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөхүүдийг хөлслөн авч ажиллуулах болно

95. Энэ чиглэлээр Банк ТУБ-т Шүрэн дэд төслийн БОННУ-ний АД-ын төслийн нэг хэсэгт болгон хэлэлцүүлгийн замын зураглалын загвар боловсруулахад дэмжлэг үзүүлээд байна. Энэхүү замын зураглалыг 2015 оны 1 сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан оролцогч талуудын оролцоог хангах сургалтын үеэр танилцуулж, хэлэлцүүлгийн үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарласан. Замын зураглалд БОННУ-ний бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулах хэлэлцүүлгүүдийн хуваарь, Шинжээчдийн хороотой сонирхогч талууд харилцах боломжуудыг тусгасан болно. Уг хуваарийг УУДБХОД Төслийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх бусад БОННУ-ний загвар болгон ашиглахаар төлөвлөсөн ба бусад дэд төслүүдийн БОННУ-гүйцэтгэхээр сонгогдсон зөвлөхүүд уг загварыг тухайн дэд төслийн онцлогч нийцүүлэн өөрчлөх боломжтой юм. БОННУ-ний ажлын даалгавар, аргачлал эцэслэн боловсрогдсоны дараа үндсэн сонирхогч талуудтай хамтран хийх хэлэлцүүлгийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулах болно.

96. Банк цаашид мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах чухал асуудлын хэрэгжилтийг улам сайжруулах, дутагдалтай талуудыг арилгах чиглэлээр ТУБ-тай нягт хамтран ажиллах болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад Хүсэлт гаргагчид болон бусад талуудын ирүүлсэн албан бичиг

97. Ирүүлсэн хүсэлтийн Хавсралт 3-т жагсаасан албан бичгийг хүлээн авсныг Удирдлагууд үүгээр мэдэгдэж байна. Эдгээр албан бичгүүдэд Банкныг Шүрэнгийн дэд төслийн ТЭЗҮ-д дэмжлэг үзүүлэхээ зогсоохыг хүссэн хүсэлт нийтлэг туссан байсан юм. Түүний зэрэгцээ (1) Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн байгаль орчин нийгмийн нөлөөллийн цар хүрээ; (2) УУДБХОД Төслийн хүрээнд Үнэлгээний судалгааг гүйцэтгэх нь зохистой эсэх; (3) Үнэлгээний судалгааны хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны талаарх хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, мэдээлэл ил тод бус байна гэсэн асуудлуудыг хөндөн тавьсан байсан.

98. Хөндлөнгийн талуудаас ирүүлсэн зарим бичигт Банк Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийг санхүүжүүлэх мэдэгдэл хийсэн мэтээр бичсэн нь ташаа бөгөөд санал болгож буй дэд төслүүдийн өнөөгийн бодит явц болон УУДБХОД Төсөл дэх Банкны оролцооны талаар зөрүүтэй ойлголтогтой байгааг илэрхийлж буйг тэмдэглэх нь зүйтэй.

99. Банкны зүгээс ирүүлсэн бичиг бүрийг хүлээн авмагц шуурхай хариу өгч байсан бөгөөд санал болгож буй дэд төслүүдийн Үнэлгээний судалгааны явцыг тодорхой тайлбарлаж байсан болно. Түүнчлэн УУДБХОД төслийн хүрээнд хийгдэж буй Үнэлгээний судалгааны дүн ямар гарахаас үл хамааран Банк эдгээр дэд төслүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөөгүй болохоо тодорхой хариулж байсан. Мөн дээрх хариу албан бичгүүдэд санал болгож буй дэд төслүүдийг урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ, БОННУ-г Дэлхийн Банкны бодлого, процедурын хүрээнд гүйцэтгэх тул нэхэмжлэл гаргагчдын хөндөн тавьсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийг УУДБХОД төслийн хүрээнд дэлгэрэнгүй судлах болно гэдгийг батлан илэрхийлж ирсэн.

100. Ирүүлсэн хүсэлт бүрт бичгээр шуурхай хариу өгөхийн зэрэгцээ Банкны төлөөллүүд, УУДБХОД төслийн ажлын хэсгийн гишүүд Хүсэлт гаргагчдын нэг төлөөлөл болсон Хил хязгааргүй гол мөрөн (Монгол) ТББ-ын төлөөлөгчидтэй 2014 оны 7 сарын 10-ны өдөр Вашингтон хотноо, 2014 оны 9 сард Улаанбаатар хотноо тус тус уулзаж байсан. Эдгээр уулзалтуудын үеэр Банкны төлөөлөл олон нийт болон ТББ-уудын оролцооны чухлыг онцлон тэмдэглэж БОННУ-ний бэлтгэл ажлын хүрээнд хэлэлцүүлгүүдийг Дэлхийн Банкны шаардлагад нийцүүлэн зохион байгуулах

болно гэдгийг тодорхой илэрхийлж байсан юм. Мөн УУДБХОД төсөл санал болгож буй дэд төслүүдийн алийг нь ч санхүүжүүлэхгүй гэдгийг Банкны төлөөлөл батлахын зэрэгцээ Дэлхийн Банк цаашид ч эдгээр төслүүдийг Монгол улсад санхүүжүүлэх бодолгүй байгаагаа мэдэгдсэн.

101. Эцэст нь, Хүсэлт гаргагчидтай бичгээр болон нүүр тулан харилцаж байсан дээр дурьдсан тохиолдлуудаас гадна ТББ-ыг засгийн газрын холбогдох байгууллагуудтай холбох ажлыг Банкны зүгээс зохион байгуулсан болохыг Удирдлага мэдэгдэж байна. Монголын Хил хязгааргүй гол мөрөн ТББ-ын Эрчим хүчний яам, УУДБХОД төслийн ТУБ-тай хийсэн анхны нүүр тулсан уулзалтыг Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх баг Улаанбаатар хотод ажиллаж байх үедээ 2014 оны 9 сард зохион байгуулсан юм. Уг уулзалт үр дүнтэй болж, ТУБ, Эрчим хүчний яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, ТББ, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан хэвлэл мэдээлэлтэй харилцах, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах талаар сургалт зохион байгуулахаар харилцан зөвшилцсөн билээ. Уг сургалтыг 2015 оны 1 сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан болно.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

102. Үнэлгээний судалгаанаас зохистой үр дүн гарах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс бүх сонирхогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах нь чухал хэмээн Удирдлага үзэж байна. ОР4.01 болон Дэлхийн Банкны бусад холбогдох Хамгааллын бодлого нь оролцоог хангах, мэдээллийн ил тод байдлыг хангах, нээлттэй хэлэлцүүлэх хийх үйл явцыг чиглүүлэх болно.

103. Санал болгож буй дэд төслүүдтэй холбоотой сонирхогч талуудын зүгээс дэвшүүлсэн асуудлууд, асуултуудыг Үнэлгээний цогц судалгааг бүрэн гүйцэтгэхэд Хүлээн авагчид дэмжлэг үзүүлэх замаар шийдвэрлэхээ Удирдлага мэдэгдэж байна.

104. Үнэлгээний судалгааны талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, судалгааг чанартай гүйцэтгэх бүхий л үйл явцыг Банкны бодлого, журамд нийцүүлэн хэрэгжүүлэхийн төлөө анхаарах болно гэдгээ Удирдлага илэрхийлж байна. Банкны бодлогод заасны дагуу БОННУ-ний аргачлал, удирдамжийг хэлэлцүүлж, эцэслэх эхний хэлэлцүүлгүүд удахгүй зохион байгуулагдах бөгөөд дараа дараагийн шатанд төслийн нөлөөнд өртөх хүн амын бүлэг, олон улсын сонирхогч талуудын хэлэлцүүлгээр үргэлжлэх болно. МУЗГ үндсэн сонирхогч талуудын оролцоог өргөн хүрээтэй хангах эрмэлзэлтэй байгаагаа харуулсан бөгөөд цаашид ил тод байдал, оролцоог хангахыг Удирдлагын зүгээс хөхүүлэн дэмжих болно.

105. Усан эрчим хүч, далангийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэшсэн олон улсын туршлага бүхий Шинжээчдийн хороо сонгон томилох үйл явц үргэлжилж байна. Шинжээчдийн хороо нь 2 дэд төслийн БОННУ-ний чанарын баталгаажилтыг хангах, хэрэгжилтийг хянах замаар үнэлгээний үйл явцад оролцох болно.

106. Үнэлгээний судалгаанаас санал болгож буй дэд төсөл хэрэгжих боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд Удирдлагын зүгээс МУЗГ-т УУДБХОД төслийн хүрээнд үнэлгээ нь хийгдэж буй эдгээр дэд төслүүдийг боловсруулах үйл ажиллагааг зогсоох зөвлөмжийг өгөх болно.

Дүгнэлт

107. *Хүсэлт гаргагчид нь УУДБХОД төслийн хүрээнд Банкаас санхүүжүүлж буй Үнэлгээний судалгаанууд бус, харин санал болгож буй дэд төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаа мөн/эсвэл бүтэлгүйтлээс үүдэх болзошгүй хор хөнөөлд чиглэгдсэн асуудлууд дэвшүүлсэн тул Удирдлагын зүгээс хяналт шалгалт хийх хүсэлт нь шалгалт явуулах шаардлага хангаагүй гэж үзэж буй байна.* Удирдлага санал болгож буй дэд төслүүдийн бүтээн байгуулалтын санхүүжилтийн асуудалд Банк оролцоогүй болохыг мэдэгдэхийн сацуу цаашид санхүүжүүлэх шийдвэр гаргаж эсвэл амлалт өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

108. *Хүсэлт гаргагчид нь санал болгосон Шүрэн болон Орхон Говийн дэд төслүүдийн талаар үндэслэлтэй асуултууд агуулсан асуудлууд дэвшүүлсэнд Удирдлага талархаж байна.* Удирдлага нь эдгээр асуудлуудыг зөвхөн цогц, системтэй байгаль орчин, нийгмийн үнэлгээ ОР 4.01-д заасны дагуу хийн авч үзэж, хариуг олох боломжтой гэх байр суурьтай хэвээр байна. Банкны зүгээс Шүрэн, Орхон говь дэд төслийн Үнэлгээний судалгааг гүйцэтгэх замаар баталгаатай, объектив мэдлэг, мэдээллийг бий болгоход МУЗГ-т дэмжлэг үзүүлж байна. Хүсэлт гаргагчдын үндэслэлтэй асуудлуудыг эдгээр Үнэлгээний судалгаанд оруулж, хянан үзэх юм.

109. *МУЗГ-аас санал болгосон төслүүдийг урагшлуулах эсэх талаарх шийдвэрийг эдгээр судалгаанууд нь урьдчилан тогтоохгүй мөн/эсвэл албадахгүй тул Хүсэлт гаргагчдын дурьдсан хор хөнөөл нь Үнэлгээний судалгаануудаас үүдэх боломжгүй гэж Удирдлага үзэж байна.* Мэдээлэл, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад шаардлагатай объектив суурь мэдээллээр хангах зорилготой хараат бус зөвлөхийн хийсэн Үнэлгээний судалгаанууд болон эдгээр Үнэлгээний судалгаануудын зөвлөмжийг хүлээн авах эсвэл хэрэгжүүлэх талаар МУЗГ-ын гаргах шийдвэр хоёрын хоорондох логик ялгаатай цаашид ч хэвээр харах шаардлагатай юм. Эдгээр Үнэлгээний судалгаануудыг санхүүжүүлэх нь Хяналт шалгалтын тогтоолд шаардсанчлан бодитой болон болзошгүй хор хөнөөлд хүргэж, Банкны бодлого, журмыг хэрхэн зөрчсөн болохыг Удирдлага олж харахгүй байна.

110. *Нэг оролцогч бүлгийн илэрхийлсэн хязгаарлагдмал зовиол, асуудлуудад төвлөрч, хяналт шалгалт энэ үе шатанд явуулах нь Хүлээн авагчийн хараат бус, цогц байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг ОР4.01-т заасанчлан хийж, эцэслэх чадварыг дордуулна гэж Удирдлага итгэж байна.*

111. *Банкны зүгээс Төслийн үйл ажиллагааг өөрийн Бодлого, журамд нийцүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч байгаа гэдэгт Удирдлага илтгэлтэй байна. Хүсэлтэд дэвшүүлсэн асуудлуудын чиглэлээр Банк өөрийн Бодлого, журмыг мөрдөж ажилласан гэж Удирдлага үзэж буй. Иймд Банк өөрийн Бодлого, поцедурыг мөрдөөгүйгээс болж хүсэлт гаргагчдын эрх буюу ашиг сонирхол шууд болон дам хэлбэрээр зөрчигдөөгүй, цаашид зөрчигдөхгүй гэдэгт Удирдлага итгэлтэй байна.*

ХАВСРАЛТ 1
НЭХЭМЖЛЭЛ БОЛОН ХАРИУЛТ

№	Нэхэмжлэл	ҮАБ/ББ ¹³	Тайлбар
	Эрчим хүчний салбарын хөгжил		
1.	<p>Эрчим хүчний салбарын үр ашиггүй хөгжлийг дэмжиж байна.</p> <p><i>Монгол Улс нь улирлаас хэт хамааралтай урсгал нь өөрчлөгддөг гол мөрөн багатай. Нар, салхи, нүүрс зэрэг арвин их эх үүсвэртэй харьцуулахад гол мөрний эрчим хүчний боломж ихээхэн бага юм. УУДБХОД төслийн хүрээнд усан цахилгаан станцын хоёр даланг барих ажлыг дэмжлэг үзүүлснээр Монгол Улсын ирээдүй нь ихээхэн эргэлзээтэй, хамгийн өндөр боломжит эрсдэл бүхий салбарын хөгжлийг дэмжиж байгаа юм.</i></p> <p>2012 онд Хил хязгааргүй гол мөрөн байгууллагаас ДБ-ны Ажлын хэсгийн ахлагчид зөвлөхдөө ... хувилбаруудын дүн шинжилгээ, эрчим хүчний хөгжлийн стратеги үнэлгээг авч үзэхгүйгээр УУДБХОДТ үүнийг хийж чадахгүй хэмээн тухайн үед хэлж байв.</p>	ҮАБ 4.01	<p>Хэдийгээр ОР4.01-ийн дагуу ДБ-наас дэмжлэг үзүүлж буй төсөл бүрт салбарын стратеги шаарддаггүй боловч, УУДБХОД Төслийн хувьд Хүлээн авагчийг төлөвлөн буй дэд төслүүдийн Үнэлгээний судалгааны сонголт, бэлтгэл ажлыг гүйцэтгэхдээ олон улсын шилдэг практик ашиглахад бэлэн байгаа өмнө нь Дэлхийн Банкнаас зөвлөх үйлчилгээ үзүүлсэн “Өмнийн говийн дэд бүтцийн судалгаа” (ӨГДБС), түүнчлэн 2009 онд гүйцэтгэж 2010 оноос АХБ туслан 2014 онд хэрэгжсэн Эрчим хүчний салбарын төлөвлөгөө (Эрчим хүчний салбарын төлөвлөгөө) зэрэг салбарын хөгжлийн түвшний шинжилгээ, төлөвлөгөө зэрэг баримт бичгийг дагаж мөрдөхийг Банкнаас дэмжсэн.</p> <p>Удирдлага Эрчим хүчний салбарын төлөвлөгөө боловсруулах үйл явцын талаар иж бүрэн, нарийвчилсан мэдээлэл авах боломжтой тул давхардлаас сэргийлэх үүднээс нэг салбарын өөр судалгаа шаардлагагүй гэж үзэн УУДБХОД төслийн хүрээнд бүрэлдэхүүн болгон оруулаагүй байна.</p> <p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд ирээдүйд Монгол орны цахилгаан эрчим хүчний хэрэгцээний талаарх иж бүрэн зураглалыг багтаасан бөгөөд цахилгааны хэрэгцээ 2030 онд 4,372 MW хүрнэ хэмээн тооцоолсон байна. Түүнчлэн томоохон хоёр уурхай болох Оюу толгой, Таван толгой төслийн үйл ажиллагааны хэрэгцээнд нийт суурилуулсан хүчин чадлын 55 хувь буюу 2,821 MW цахилгаан эрчим хүч шаардлагатай гэсэн тооцоо гарчээ.</p> <p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд мөн Монгол орны түгээх системийн насжилтын талаарх дүн шинжилгээг авч үзсэн бөгөөд улс орны эрчим хүчний тогтвортой, аюулгүй байдлыг хангахад багагүй хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай талаар дурьдсан байна.</p> <p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд саяхны өмнөд болон төвийн сүлжээг холбосноор Улаанбаатар хот болон Өмнөд говийн бүсийг хамарсан нэгдсэн сүлжээ (Төвийн эрчим хүчний систем) байгуулах талаар тэмдэглэжээ. Сүлжээний энэхүү нэгдмэл байдал нь уул уурхай, Монгол орны хүн амын аль алины эрчим хүчний хангамжийг илүү уян хатан байдлаар удирдах боломж олгох юм.</p> <p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөө Төвийн эрчим хүчний системээс Оюу толгой, Таван толгойн уурхай бүхий Өмнөд говийн бүсийн ихээхэн хэмжээний цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангахад шаардагдах өндөр ач холбогдолтой хөрөнгө оруулалтын талаар санал дэвшүүлсэн. Тиймээс Төвийн эрчим хүчний системийн томоохон нийлүүлэгч болох төлөвлөн буй Шүрэнгийн УЦС-ын дэд төсөл нь Өмнөд говийн бүс дэх уул уурхайн салбарт шууд үр ашиг үзүүлэх юм.</p>

¹³ ҮАБ- Үйл ажиллагааны бодлого ББ- Банкны Бодлого

			<p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөө Монгол орны цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн олон төрлийн эх үүсвэр болон улс орны хэмжээний цахилгаан эрчим хүч түгээх олон сүлжээний талаар өргөн хүрээнд авч үзжээ. Үүнд чулуун нүүрс болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн (усан, нарны гэрэл, салхи) аль алиныг авч үзсэн байна. Шинжилгээний үр дүнгш цахилгаан эрчим хүчний хэрэгцээ, зардал багатай шийдэл, эрчим хүчний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны бодлого, багцын олон янз байдал болон санхүүжилт зэрэг эрчим хүчний бодлогын үндсэн дээр эрэмбэлэн гаргажээ.</p> <p>Судалгааны дүнд Монгол орны эрчим хүчний бүтцэд усан цахилгаан станцаас гаргаж авах эрчим хүч нь найдвартай, зардал багатай бөгөөд эрчим хүчний хангамжийн тэнцвэрийг хадгалахад туслан, оргил ачааллын үеийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангахад шаардлагатай уян хатан чанарыг бий болгох талаар дурьджээ. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд (Б хэсэг – Ү боть: Технологи): <i>“Зардлын харьцуулалтад томоохон усан цахилгаан станцууд сайн үзүүлэлт үзүүлдэг бөгөөд Орхон, Эг, Шүрэнгийн УЦС-ийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд нэг бүрчлэн авч үзэх”</i> хэрэгтэй талаар дурьдсан байна.</p> <p>Эрчим хүчний салбарын судалгаанд мөн Монгол Улс Төвийн эрчим хүчний системд цахилгаан нийлүүлэх Шүрэн голын усан цахилгаан станц барих талаар тодорхой зөвлөмж багтсан байна. Усан цахилгаан станц нь Монгол орны цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн зонхилох хэлбэр болох нүүрс хэрэглэдэг ердийн цахилгаан станцуудтай харьцуулахад олон чухал давуу талтай юм.</p> <p>Эрчим хүчний салбарын төлөвлөгөө цэвэр эрчим хүч хувилбаруудыг бүрэн дэмжиж байгаа боловч, нар салхины эрчим хүчний аль нь ч тасалданги, тогтмол бус шинж чанарынхаа улмаас хурдацтай өсөн нэмэгдэж буй Монгол орны хэрэгцээг хангаж чадахгүй гэж дүгнэжээ. Эрчим хүчний салбарын төлөвлөгөөний Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн технологийн тойм хэсэгт (Б хэсэг – Ү боть: Технологи) <i>“Ачааллын хүчин зүйл нь хязгаарлагдмал учраас нар болон салхины эрчим хүч нь Монгол орны хямд үнэтэй нүүрстэй өрсөлдөх боломжгүй юм.”</i> хэмээн дурьджээ.</p> <p>Дээрх зөвлөмжүүдийг үл харгалзан, аливаа боломжит усан цахилгаан станцын нөхцөлийн техник, эдийн засгийн үндэслэлийг байгаль орчин, нийгмийн нөлөөлөл болон, эдийн засаг, техникийн өрсөлдөх чадварыг сайтар судлах шаардлагатай юм.</p> <p>Удирдлага Үнэлгээний судалгааг иж бүрнээр хийж гүйцэтгэх хүртэл төлөвлөж буй дэд төслүүдийн боломжит эрсдэл, нөлөөллийн талаар мэдэх боломжгүй гэдийг тэмдэглэж байна. Төлөвлөж буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн эдгээр асуудлуудын талаар системтэй, иж бүрнээр үнэлгээ өгөн, судалгаа хийх нь УУДБХОД төслийн хийхээр зорьж буй зүйл билээ.</p>
	Усны салбарын хөгжил		
2.	Монгол орны усан хангамжийн голлох хэсгийг голын хөндийн гүний эх	ҮАБ 4.07	Удирдлагын зүгээс энэхүү асуудал нь Дэлхийн Банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөж буй Үнэлгээний судалгаанаас биш харин санал болгож буй Шүрэн, Орхон Говь дэд

	<p>үүсвэрээс гаргаж авдаг байна. Гэвч, Монголын улс төрчид гүний уснаас гадаргын ус ашиглахад шилжих ёстой гэж үзэж байна. Усны үнэ нь усны далан барих үйл ажиллагааг дэмжих бодогыг гажуудуулж байна.</p> <p>Олон нийтийг усаар хангахад аюул учирч байна. Шүрэнгийн УЦС-ын төслийн бүх гидрологи, эдийн засгийн тооцооноос харахад Эрдэнэт хотын усны хэрэглээнд ихээхэн аюул заналхийлж байгаа нь илэрхий байна. Шүрэн төслийн ажилтнууд энэ талаар мэдэж байсан боловч 2014 оны зун хүртэл төслийн дизайнд тулгуурласан хамгийн анхан шатны ТЭЗҮ-ний судалгааны тооцооны баримтыг олон нийтэд нээлттэй болгоогүй нь энэ зөрчилдөөнийг шийдвэрлэх боломж олгоогүй.</p>		<p>төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаанаас үүдэн гарах магадлалтай гэж үзэж байна. Төлөвлөж буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн боломжит нөлөөллийг тодруулах нь Үнэлгээний судалгааны гол зорилго юм.</p> <p>Уламжлал ёсоор Монгол орон ихэнхдээ ундны усны хязгаарлагдмал хэрэгцээгээ хангахад голын хөндий дэх хөрсний ойролцоох гүний усны хэрэглээнд найддаг юм. Улаанбаатар хотын суурин хүн амын өсөлт, уул уурхайн салбарын хурдацтай хөгжил, холбогдох эдийн засгийн үйл ажиллагааны улмаас усны хэрэглээ эрчимтэй өсч байгаа бөгөөд ирэх жилүүдэд үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нь зарим нэгэн бүс нутаг ялангуяа говийн бүс дэх гүний усны чухал эх үүсвэрүүд оршдог Өмнөговь аймгийн гүний ус чулуужсан¹⁴ байдлаар байдаг нь орон нутгийн хэмжээнд ашигладаг усны нөөцөд дарамт болж байгаа бөгөөд, гүний усны түвшинд нөлөөлөхгүйгээр ашиглах боломжгүй байдаг. Эдгээр бүс нутагт, өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангахын тулд бусад боломжит нөхцөлүүдийн хамт гадаргын ус ашиглах асуудлыг авч үзэх шаардлагатай.</p> <p><i>Усны үнийн гажуудлын таамаглал</i></p> <p>Үйлдвэрлэлийн зориулалттай усны үнийн өсөлт нь гажуудал биш бөгөөд харин нөгөө талаасаа уул уурхайн үйлдвэрлэлийн усны нөөцийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих арга хэрэгсэл бөгөөд ингэснээрээ нэмэлт усны эх үүсвэр шаардах явдлыг бууруулах болно.</p> <p><i>Эрдэнэт хотын усан хангамжид учруулах аюулын талаарх таамаглал</i></p> <p>Төлөвлөж буй Шүрэн дэд төслөөс Эрдэнэт хотод учруулах нөлөөллийн талаарх асуудал 2015 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Шүрэн БОННУ-ний Ажлын зааврыг хэлэлцэх олон нийтийн зөвлөгөөний үеэр хөндөгдсөн бөгөөд энэхүү дэд төслийн Техник эдийн засгийн үндэслэл болон, БОННУ-ний судалгааны хүрээнд авч үзэх болно.</p> <p>Санал болгож буй Шүрэн дэд төслийн ТЭЗҮ-ний Ажлын удирдамжид “Шүрэнгийн УЦС-ын барилга, хэрэгжилттэй холбогдох бүх зардал нь гүйцэтгэлийн дизайн болон хэрэгжилтийн төлөвлөгөөнд үндэслэн шинэчлэгдэнэ. БОМТ, НШУАТ болон боломжит ашиг хувиарлах хөтөлбөрийн хэрэгжилтийн зардал нь БОННБУ-ний зардлаас гарах бөгөөд нийт хөрөнгө оруулалтын зардалд багтсан болно.” заасан байна. (Б13,1 – Хөрөнгө, хөрөнгө оруулалтын зардал)</p>
	<p>Байгалийн амьдрах орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл</p>		
<p>3.</p>	<p><i>Дэлхий дахинд чухал ач холбогдолтой байгалийн амьдрах орчин – Байгаль нуур, Сэлэнгэ мөрний ай савд заналхийлж байна</i> Байгаль нуур, Сэлэнгэ мөрний ай сав газрын эко систем нь</p>	<p>ҮАБ 4.01</p>	<p>Удирдлага Хүсэлт гаргагчаас урсгалын дээд, доод хэсгийн амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийн талаар гаргасан асуудал нь Дэлхийн Банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөж буй Үнэлгээний судалгаанаас биш харин санал болгож буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн барилгын ажил, үйл ажиллагаанаас үүдэн гарах магадлалтай гэж үзэж байна. Төлөвлөж буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлыг</p>

¹⁴ Дарагдмал гүний ус нь удаан хугацаанд үүсэн бий болдог. Энэхүү нөөц нь эргэн нөхөгддөггүй учраас гүний ус нь нөхөн сэргээгддэггүй эх сурвалж юм.

	<p>дэлхийн байгаль хамгааллын томоохон төв хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн. Томоохон хэмжээний усны далангууд нь ихэнхдээ урсгалын доод хэсгийн эко системд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг нь мэдээж. (энэ талаар ДБ-ны тусгайлсан бий). Тиймээс УУДБХОД Төсөл нь Сэлэнгэ мөрний сав газар дахь далангуудыг тодорхойлох судалгааны боломж гэж үзэх ёсгүй.</p> <p><i>Сэлэнгэ мөрөн, Орхон голын орчмын амьдрах орчинд заналхийлж байна. Сэлэнгэ мөрөн, Орхон гол нь Монгол орны ховордсон болон нэн ховордсон амьтдын жагсаалтад орсон “хилэм загас”-ны амьдран буй Монгол орон дахь хамгийн сүүлчийн орчин юм. Хилэм болон бусад загаснууд Байгаль нуурт ирэн очин нүүдэллэн шилждэг. Жишээлбэл, Сэлэнгэ мөрөн, Орхон гол нь “тул” зэрэг БХОУХ-ны жагсаалтад орсон төрөл зүйлийн чухал амьдрах орчин юм. Хатуу ширүүн өвлийн улиралд томоохон голын сувгууд нь голын загасны хувьд цорын ганц хоргодох газар болдог бөгөөд ингэснээрээ цэнгэг усны нийт амьтны аймгийн чухал амьдрах орчин болдог байна. Сэлэнгэ мөрөн нь Монгол орны хамгийн том гол бөгөөд тиймээс өвөрмөц, орлуулж болшгүй амьдрах орчин юм. Үүнийг бусад жижиг голуудтай харьцуулахад хамгийн том цэнгэг устай амьдрах орчин, олон тооны усны амьтны төрөл зүйлтэй юм.</i></p>	<p>тодруулах нь Үнэлгээний судалгааны гол зорилго юм.</p> <p>Байгаль нуур орчмын чухал байгалийн амьдрах орчин, Монгол хилэм загас зэрэг ховордсон төрөл зүйлд заналхийлэх, хэрэв Үнэлгээний судалгаагаар төлөвлөж буй дэд төслүүдийг хэрэгжүүлэх нь байгаль хамгааллын үр дүн, чухал байгалийн амьдрах орчны доройтолд хүргэх нь тодорхойлогдвол Банкны зүгээс Монгол Улсын Засгийн газрыг Дэлхийн Банкны ОР 4,04-ийн шаардлагын дагуу цаашид үргэлжлүүлэхгүй байхыг зөвлөх болно.</p> <p>УУДБХОД Төсөл нь төлөвлөж буй Шүрэнгийн дэд төсөлтэй холбогдох шийдвэр гаргахад нь Монгол Улсын Засгийн газарт туслах иж бүрэн, системтэй БОННБҮ-г бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. Үнэлгээний судалгаа нь УУДБХОД төслийн хүрээнд хийгдэх учраас төлөвлөж буй Шүрэнгийн дэд төслийг Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний ай савын эко системд үзүүлж болзошгүй нөлөөлөл зэргийг багтаасан, байгаль орчин, нийгэмд учруулах нөлөөллийг бууруулах зохих үнэлгээгүйгээр боловсруулах эрсдэлийг бууруулах юм.</p> <p>Нарийвчилсан, системтэй Үнэлгээний судалгаа гарах хүртэл төлөвлөж буй Шүрэн, Орхон Говь дэд төслүүдийн үйл ажиллагааны улмаас аюулд өртсөн ховордсон төрөл зүйл болон амьдрах орчны цар хүрээг тодорхойлж чадахгүй байх буюу байгалийн амьдрах орчинд хүндээр нөлөөлөх, тэдгээр төрөл зүйл болон тэдний эко системд дэд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй аливаа нөлөөллийг бууруулах арга замыг тодорхойлох боломжгүй тохиолдолд дэд төслийг үргэлжлүүлэхгүй байхыг зөвлөж болно.</p> <p>Төлөвлөж буй Шүрэнгийн дэд төслийн БОННБҮ-ний Ажлын даалгаврын төсөлд Сэлэнгэ мөрөн, түүний сав газар (дээд урсгал, доод урсгал, Рамсар суурин бэлчир, Байгаль нуур Дэлхийн өв суурин)-ыг мэдрэмтгий байдалтай гэдгийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Төлөвлөж буй Шүрэнгийн дэд төслийн доод хашицын урсацын байгаль орчны нөлөөлөл” хэмээх В.4.3 хэсэгт “Шүрэнгийн УЦС-ын нөлөөллийг үнэлэхдээ ЮНЕСКО-гийн дэлхийн өвийн бүртгэлтэй "Байгаль нуур" болон РАМСАР сайтын "Сэлэнгэ дельта" 2RU018 гэсэн үнэлгээнүүдийг харгалзан үзэж голын урсацын байгалийн урсгал болон хагшаасны шилжилт зэрэг боомтын хөндлөнгийн нөлөөллүүдийг тооцоолно” гэж төслийн зөвлөхөд шууд зааж өгсөн. - Мөн В.2, В.4, В.4.1, В.4.3 хэсгүүдэд Зөвлөх нь төлөвлөж буй Шүрэн дэд төслийн үйл ажиллагаанаас байгалийн амьдрах орчин, чухал газруудад (ургамал, амьтны төрөл зүйлийн олонх нь амьдарч буй хуурай газар, усан орчин) үзүүлж болзошгүй нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, Сэлэнгэ мөрөн дээр хаалт бий болгосноос үүдэн байгалийн амьдрах орчны хэсэгчлэн хуваагдал, зэрлэг амьтдын нүүдлийн зам (загас өнгөрүүлэх байгууламж), газрын хөрсөн дээрх ургамалд нөлөөлөх хохирол, газрын доройтлын хэмжээ зэргийг үнэлэх, - F.1.1 хэсэгт Зөвлөх багийн бүрэлдэхүүнд багтах Байгалийн нөөцийн менежментийн мэргэжилтэн нь энэхүү эмзэг бүс нутагт хамаарах байгалийн амьдрах орчин судлал, ургамал амьтны аймгийн судалгаа болон байгаль орчны менежмент боловсруулах,
--	--	--

			<p>стратегийн хяналт шинжилгээ хийх чиглэлээр доод тал нь 10 жил ажилласан мэргэжлийн туршлагатай байх,</p> <p>Шивэр хилэм зэрэг биологийн төрөл зүйлд үзүүлж болох болзошгүй нөлөөллийн тодорхойлолт, үнэлгээ хийх талаар төлөвлөж буй Шүрэнгийн дэд төслийн БОННБУ-ний ажлын даалгаварт дараах байдлаар тусгасан байна, тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - В.4.3 хэсэгт Шүрэнгийн дэд төслийн доод хашицын Байгаль орчны нөлөөллийг хийхдээ Зөвлөх нь “Далан барих болон голын байгалийн урсацыг өөрчилснөөс зэрлэг ан амьтдын амьдрах орчин, нүүдлийн зам хаагдах эсэх (загас дамжин өнгөрөх хэсэг), хөрсний доройтол зэрэг болзошгүй нөлөөллийг тодорхойлон үнэлнэ” гэсэн байна. <p>Төлөвлөж буй Шүрэнгийн дэд төслийн БОННБУ-ний ажлын даалгаварт Шивэр хилэм загасыг онцлон түүний амьдрах орчин үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээ, түүнээс зайлсхийх арга замыг тодорхойлох, нөлөөллийг бууруулах арга замыг эрэлхийлэх талаар тусгасан, тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Баримт бичгийн В.4.3-д заахдаа Зөвлөх нь “Тул, шивэр хилэм зэрэг загасны хувьд буюу усны бусад олон янз байдал амьтдын хувьд давшгүй саад (далан) болох тул Сэлэнгэ голын дээд, доод хашицын урсцын дагуух загасны нүүдлийн замд учрах аливаа саад тотгорыг тодорхойлон үнэлнэ. Загас өнгөрүүлэх байгууламж, үржүүлэх цөөрөм, эсвэл усан санд загас үржүүлэх аж ахуй эрхлэх зэргээр мэдэгдэж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээг судална” гэсэн байна. - Мөн F.1.1 хэсэгт Зөвлөх багт ажиллах Загас судлаач нь мэргэжлээрээ доод тал нь 10 жил ажилласан туршлагатай, практик асуудлыг шийдвэрлэх ур чадвартай байх талаар тусгасан байна.
	УУДБХОД төслийн хамрах хүрээ		
4	<p>УУДБХОД төсөл нь хамрах хүрээгээ зөрчиж байна. Дэлхийн Банк 2009 онд Өмнийн говийн эрчим хүчний эх үүсвэрийн хөгжлийн талаарх судалгаа хийлгэсэн бөгөөд энэхүү судалгаа нь уул уурхайн үйлдвэрлэлд шууд холбоотой усан цахилгаан станцын талаар авч үзээгүй. УУДБХОД төслийн зарим нэг дэд төслүүд тухайлбал Багануурын уурхайн өргөтгөлийн төслүүд үндсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байна.</p> <p>Шүрэнгийн УЦС нь уул уурхайн салбарт шууд хамааралгүй юм. Энэ нь анхнаасаа оргил ачааллыг даван туулах, Төвийн эрчим</p>	ОР4.01	<p>УУУДБХОДТ-ийн Төслийн баримт бичигт дурьдсан төслийн хамрах хүрээг уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих бэлтгэл үйл ажиллагаатай холбогдох судалгааг санхүүжүүлэх талаар тусгахдаа: “Эрчим хүч, тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, усан хангамж, орон сууц, нийгмийн салбарын болон ложистик, хилийн боомтын барилга байгууламжид холбогдох төслүүд сонгогдох боломжтой. Түүнчлэн боловсруулах болон (хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт) зэс хайлуулах болон төмөр үрэл үйлдвэрлэл зэрэг нэмүү өртөг бий болгох үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой” (ТББ, 89-р) Эдгээр тэргүүлэх зорилтыг 2009 оны ЖДҮС-ийн судалгааны баримт бичгийн зөвлөмжид тулгуурлан гаргасан бөгөөд Эрчим хүчний салбарын төлөвлөгөөний зөвлөмжтэй нийцэж байгаа болно.</p> <p>УУДБХОДТ-ын хүрээнд үнэлгээ хийгдэн, судалгаа хийсэн санал болгож буй зургаан дэд төсөл нь ТУХ-оор тодруулсан бөгөөд УУДБХОДТ-ийн бүтцийн өөрчлөлт, нэмэлт санхүүжилтийн гэрээ 2014 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Удирдах хороогоор батлагдсан.</p> <p>Хүлээн авагчийн хүсэлтийн дагуу 2009 оны ЖДҮС-д дурьдагдсан Багануурын уурхайг түшиглэн Нүүрснээс шингэж түлш гарган авах үйлдвэр байгуулах (51-р тал) талаар судалгаа хийгдсэн боловч өндөр эрсдэлийн улмаас</p>

	хүчний системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх зорилготой байсан. УУДБХОДТ нь уул уурхайн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх үндсэн үүрэгтэй учраас Шүрэнгийн УЦС-д шууд холбогдолгүй юм.		хойшлогдсон талаар тэмдэглэсэн байна. Эрчим хүчний хангамжийн нөхцлүүдийн энэхүү үнэлгээнд “ялгаатай нөхцөлүүдийн холбогдох эдийн засаг, санхүүгийн сонирхол татсан саналыг үнэлээгүй. Үүний оронд төслийн арилжааны бэлтгэл байдлаас илүүтэйгээр тэдний 2012-2013 оны богино хугацаанд нийлүүлэх бэлэн байдалд нь илүү анхаарал хандуулсан юм” (52-р тал) гэсэн байна. Санал болгож буй Багануурын нүүрсний уурхайн дэд төслийн үнэлгээний судалгаа нь Монгол орны ногоон эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэхэд түлхэц болох нүүрснээс байгалийн хий гарган авах боломжийн талаарх ТЭЗҮ болон байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөлөлд үнэлгээ хийнэ. Хуучин мэдээллийн сан байгаа боловч цаашид баталгаажуулах шаардлагатай юм. Үүнээс гадна, энэ нь Монгол орны олборлох аж үйлдвэрийн удирдах чадавхийг бий болгоход туслах бөгөөд, хуримтлагдсан нөлөөлөл болон хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд чиглэгдсэн байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд илүү анхаарал хандуулах болно.
	УУДБХОДТ-ийн хэрэгжилт		
5.	УУДБХОД төслийн судалгааны дэс дараалал. Энэ ажил Дэлхийн Банкны зохих байгаль орчны үнэлгээний журмын дагуу хийгдээгүй. Орхон Говь ус зөөвөрлөх системийн үйл ажиллагааг УУДБХОД төсөл 2012 оны зунаас ихээхэн дэмжиж байна. Гэвч, говийн гүний усны нөөцийг үнэлэх “Гүний ус бүрэлдэхүүн хэсэг” иж бүрэн судалгаа хийгдэж байгаа учраас ус зөөвөрлөх системтэй холбогдох төслийн үйл ажиллагаа 2-3 жил завсарласны дараагаар 2014 оноос эхлэх шаардлагатай эсэхийг тодруулах. “1.1.7.b Уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд чиглэгдсэн Өмнийн говийн хөгжил – гидрогеологийн хайгуул судалгаа” 2014 оны хоёрдугаар хагаст эхэлсэн. Энгийн логик дараалал эсрэгээрээ байж болох юм. Энэхүү ажлын дараалал нь боломжит гүний усны судалгааг эхний ээлжинд хийж, түүний дараагаар ус зөөвөрлөх шаардлагатай	ОР4.01	Удирдлага бэлтгэл судалгааны зөвлөмж болон УУДБХОД Төслийн үйл ажиллагааны бодит дэс дараалал хооронд ямар нэгэн зөрөө байхгүй гэдгийг нотолж байна. 1) “Өмнийн говийн бүс нутгийн байгаль орчны үнэлгээ” (Дэлхийн Банк, 2010 оны 1-р сар) судалгаанд Өмнийн говийн бүс нутгийн хөгжилд тулгарч буй бэрхшээлүүдийн дундаас нэн тэргүүнд авч үзэх асуудал нь усны олдоцын асуудал юм гэж дүгнэсэн байна. Уг тайланд дарагдмал гүний усны ихээхэн хэмжээний нөөц байгаа боловч түүний нөхөн сэргээгдэх хурд маш удаан (жилд 1 мм), эдгээр нь нөхөн сэргээгддэг эх үүсвэр биш учраас болгоомжтой хэрэглэх ёстой талаар анхааруулжээ. 2) “Өмнийн говийн бүс нутгийн гүний усны үнэлгээ” (2010 оны 4-р сар) судалгаа нь Өмнийн говийн бүс нутаг дахь усны хэрэгцээ болон гүний усны боломжит эх үүсвэрийн талаарх анхны үнэлгээ болсон юм. Энэхүү тайланд дүгнэхдээ: i. Өмнийн говийн бүс нутгийн гүний усны бүх эх үүсвэр нь чулуужсан байдалтай тул хөрсний усны түвшинд нөлөөлөхгүйгээр ашиглах боломжгүй ii. Хөрсний ус 25-40 жилийн хугацаанд 50-100 метрээр доошлохыг хүлээн зөвшөөрдөг ч 2020 он гэхэд усны хэрэгцээ боломжит хөрсний усны эх үүсвэрээс давах юм. iii. Гүний ус болон ус зөөвөрлөх Орхон говь төслийн аль алиных нь талаарх судалгаа хийж, яаралтай мэдээлэл цуглуулах шаардлагатай байна.

	<p>эсэхийг тодорхойлох Дэлхийн Банкны 2008-2010 онд хийсэн анхны судалгаатай зөрчилдөж байна. Хэдийгээр гүний усны үнэлгээний ажил дөнгөж эхэлж байгаа боловч УУДБХОДТ-ийн захирал нь хурал уулзалтууд, хэвлэлд өгсөн ярилцлагадаа гүний усны хангамжийг гадаргын усыг холын зайн тээвэрлэх шаардлагатай талаар ярьж байна.</p>		<p>3) УУДБХОД төслийн Гүний усны менежментийн бүрдэл хэсгийг санхүүжүүлж байгаа Австралийн DFAT-ын Төслийн дизайны баримт бичигт (2012 оны 2-р сар) гурван аймагт усны сав газрын захиргаа байгуулах, Гүний усны менежмент, мэдээллийн төв байгуулах замаар Усны хэрэг эрхлэх газрын чадавхийг бэхжүүлэх, говийн бүс нутаг дахь гүний усны талаарх хяналтын үйл ажиллагаа болон мэдлэгийг бий болгох судалгаа хийх, Аймгийн гүний усны менежментийн төлөвлөгөө боловсруулах зэрэг үйл ажиллагаа 2016 оны 9-р сард хэрэгжиж дуусна.</p> <p>4) 2012 оны 6-р сарын сонгуулийн дараагаар Усны хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааг шинээр байгуулагдсан Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ) хариуцах болсон. 2012 оны 9-р сард, Дэлхийн Банкнаас УУДБХОД төслийн Гүний усны менежментийн бүрдэл хэсгийн бүтэц зохион байгуулалтын талаар БОНХЯ-ны шинээр томилогдсон ажилтантай уулзалт зохион байгуулсан бөгөөд уулзалтын явцад шинээр тодорхойлсон гурван голын сав газруудад Голын сав газрын захиргаа байгуулахыг дэмжсэн юм. УУДБХОД төслийн зүгээс Австралийн DFAT байгууллагад хандан УУДБХОДТ-ийн Гүний усны менежментийн бүрдэл хэсгийн цаашдын үйл ажиллагааг дэмжих Нэмэлт санхүүжилтийн талаар ярилцаж байна.</p> <p>5) 2014 оны 3-р сард Улаанбаатар хот дахь БОНХЯ-ны Гүний усны менежмент, мэдээллийн төвийн дэмжлэгтэйгээр Өмнийн говийн бүс нутаг дахь гурван ГСГЗахиргаа орон нутаг дахь үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм. Удирдлага төслийн хэрэгжилт, хяналтын үйл ажиллагаа, судалгаа, 2016 оны 9-р сард бэлэн болох Гүний усны менежментийн төлөвлөгөө бэлтгэх зэрэг үйл ажиллагаанууд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сааталгүй үргэлжилж байгаа болохыг нотолж байна.</p> <p>6) Санал болгож буй Орхон говь дэд төслийн анхан шатны тайланд (2014 оны 5-р сар) Өмнийн говийн бүс нутаг дахь гүний усны нөөцийн ашиглалт хоногт 144.000 м³ байгаа нь 2020 оноос өмнө усны хэрэгцээ боломжит нөөцөөс давах болно гэж дүгнэжээ.</p> <p>Санал болгож буй Орхон говь (Орхон говь судалгаа) дэд төслийн үнэлгээ, судалгааны байдлыг аваад үзвэл төлөвлөж буй дэд төслийн нарийн төвөгтэй байдал, боломжит гүний усны үнэлгээний дутагдалтай тал зэргийн улмаас бэлтгэл судалгааг багтаасан илрүүлэх явц зэргийг гүнзгийрүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна. Санал болгож буй Орхон говь дэд төслийн үнэлгээ нь Австрали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн дэмжлэгтэй хэрэгжсэн Төслийн 3 дахь</p>
--	---	--	---

			<p>бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Өмнийн говийн бүс нутаг дахь гүний усны нарийн нягт хийсэн мониторинг, үнэлгээгээр сайжирсан байна. Эдгээр гүний усны үнэлгээний судалгааны ажил 2014 онд эхэлсэн бөгөөд Орхон говь ТЭЗҮ болон БОННБҮ-ний ажлын хамт үргэлжлэх юм. Энэхүү ажлын зорилго нь гүний усны үнэлгээний судалгааны үр дүнг ТЭЗҮ болон БОННБҮ-нээс гадна Өмнийн говийн бүс нутаг дахь усны хэрэгцээг хэрхэн хангах талаар МУЗГ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино. Хэдийгээр гүний усны үнэлгээний үр дүн одоогоор тодорхой болоогүй боловч, одоогоор гүйцэтгээд байгаа санал болгож буй Орхон говь дэд төслийн бэлтгэл судалгааны үр дүнгээс үзвэл, ирээдүйд Орхон говиос Өмнийн говийн бүс нутаг руу ус зөөвөрлөх шаардлагатай бөгөөд уул уурхайн хөгжлийн ирээдүй нь боломжит усны цаг хугацаа, цар хэмжээнээс шалтгаалах болохг нь харагдаж байна. Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаанд усан хангамжийн дээд болон доод хэмжээний хувилбарыг авч үзэх болно.</p>
6.	<p>Шударга байдал, “төслийн үнэлгээ”-ний чанар алдагдсан. Хил хязгааргүй гол мөрөн, Грийнпис байгууллагаас ДБ-ны Ажлын хэсгийн багийн ахлагчтай жил гаруй хугацаанд хийсэн яриа хэлэлцээ нь дараагийн урьдчилсан ТЭЗҮ ба ТЭЗҮ-ийн үе шатны үнэлгээ/сонголтын үйл явцыг тодорхой болгох асуудал байв. 2012 оноос хойш ДБ байнга сануулж байсан боловч “Төслийн өрсөлдөх чадварын үнэлгээ” болон төслийн анхны санааны явцын баримтжуулсан хэрэглээг танилцуулаагүй бөгөөд УУДБХОДТ-ийн хүрээнд дуусгавар болсон. Бодит байдал дээр УУДБХОДТ-ийн хүрээний төсөл сонгох, дэвшүүлэх үйл ажиллагаан нь 4-5 оролцогч яамны өөрчлөгддөг сонирхолд үйлчилдэг ихээхэн улс төрийн үйл явц болсон. Анхан шатны тодорхойлолт болон дараагийн үе шатны хараат бус үнэлгээний сайн механизм байхгүй байна.</p>	<p>ҮАБ 4.01</p>	<p>Удирдлага нь УУДБХОД төсөл нь томоохон хэмжээний дэд бүтцийн төслийг боловсруулах үе шат бүхий судалгаанууд, төлөвлөлтийн түвшнээс эхлэн боломжит хувилбаруудын талаарх гүнзгий дүн шинжилгээ рүү дэвшүүлэн (ямар нэгэн төслийн хувилбаргүй нөхцөл байдлыг ч оролцуулан), болзошгүй нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ зэрэг Дэлхийн Банкны бодлого, дүрэм журам түүнчлэн олон улсын шилдэг туршлагыг мөрдөн ажиллаж байгаа болохыг тэмдэглэж байна. Сангийн сайдаар ахлуулсан олон тооны яамдын оролцоотой ТУХ нь төслийн үйл ажиллагааны ерөнхий удирдлагаар хангаж байгаа болно. Төслийн удирдах хорооноос санал болгож буй зургаан дэд төсөл бүрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны олон талт хэрэгжилтийн журмыг баталсан.</p> <p>Санал болгож буй зургаан дэд төслийн ихэнхийг нь хоёр шатны үйл явцаас бүрдсэн, Нэгдүгээр үе шат – Үнэлэх, Хоёрдугаар үе шат – ТЭЗҮ болон БОННБҮ юм. Эхний үе шатны хүрээнд, санал болгож буй төсөл нэг бүрийн техник, санхүү, байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, санал болгож буй дэд төслүүдийн хувилбаруудад дүн шинжилгээ хийх зэрэг үнэлгээний ажлууд хийж гүйцэтгэсэн. Энэ үе шатанд боломжит мэдээллийг цуглуулах, үнэлгээний тайлангаа гаргах зэрэг үйл ажиллагаанууд багтана. Дараагийн үе шатны Ажлын даалгавар боловсруулахад байгаа мэдээлэл нь хангалтгүй байгаа тохиолдолд энэ үе шатанд сонгосон техникийн судалгааны гүйцэтгэлийг багтаасан байна.</p> <p>Үнэлгээний тайланд нэгдүгээр үе шатны үр дүн болгон хоёрдугаар үе шатны хүрээнд хийгдэх ТЭЗҮ болон холбогдох БОННБҮ-ний Ажлын даалгаварыг оруулна. Нэгдүгээр үе шатанд үнэлгээний үйл явцын эхний үе шатанд дэд төслүүдийн холбогдолтой судалгаа, мэдээлэл цуглуулах, байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн талаарх анхан шатны мэдээлэл, ТЭЗҮ болон БОННБҮ-ний Ажлын даалгаврын бэлтгэлийн үеийн системтэй зөвлөгөө зэргийн талаар ТУН-ээс зохион байгуулсан хагас өдрийн хэлэлцүүлэг зэргийг багтаасан оролцогч талуудын зөвлөгөө багтаж байна. Хоёрдугаар үе шат нь доор нарийвчлан тайлбарласан БОННБҮ-ний бэлтгэл ажлын үед</p>

	<p>Төслийн үнэлгээний баримт бичгийн хавсралтад анхлан багтсан бүх 6 төсөл нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийн улмаас буурсан. Үүнийг Шүрэнгийн УЦС-ын төслийн байдлаас илэрхий юм, бидэнд ДБ-ны бүх түвшний албан тушаалтнуудаас ирүүлсэн “өрсөлдөх чадварын үнэлгээ” хийхийг амалсан 3-5 захиа байгаа бөгөөд, урьдчилсан ТЭЗҮ-г өмнө нь ДБ-наас тодорхой болсон Ажлын даалгаврыг бүдүүлгээр зөрчиж байгааг одоо бид мэдсэн. ХХГМ байгууллагаас ДБ болон УУДБХОДТ-д хандан дараах үнэлгээний үйл явцын нотолгоо гаргаж өгөхийг хүссэн, үүнд: 1) төслийн өрсөлдөх чадварыг тодорхойлоход ашигласан шалгуур үзүүлэлт, 2) оновчгүй төслийг цуцлах дүрэм, 3) ДБ-ны ажлын хэсгийн ашигласан төслийн үнэлгээний үйл явц, 4) төслийн үнэлгээний менежер, оролцогч талуудын оролцоо, 5) үнэлгээний үр дүнг баримтжуулсан арга зүй зэрэг болно. Бид одоогийн Ажлын хэсгийн ахлагч буюу Энхбаатараас ямар нэгэн хариу аваагүй болно.</p>	<p>хийсэн нэмэлт зөвлөгөө багтана. Шүрэнгийн судалгаа нь урьдчилсан ТЭЗҮ судалгааны үе шатыг багтаасан. Нэгдүгээр үе шатны үр дүнд өрсөлдөх чадвар болон санхүүгийн үнэлгээний судалгаа, Хоёрдугаар үе шатны хүрээнд хийгдэх Ажлын даалгавар орсон. Урьдчилсан ТЭЗҮ-г 2014 онд хийсэн бөгөөд ТЭЗҮ болон БОННБҮ-ний нарийвчилсан Ажлын удирдамжийг Гуравдугаар үе шатны хүрээнд боловсруулна. Орхон говь төслийн судалгаа нь гурван үе шатнаас бүрдэнэ. Хэдийгээр санал болгож буй Орхон говь дэд төслийн нөхцөл байдал нарийн төвөгтэй, говийн бүсийн гүний усны эх үүсвэрийн талаарх боломжит мэдээлэл хангалтгүй байгаа боловч, Үнэлгээ хийх нэгдүгээр үе шатанд урьдчилсан ТЭЗҮ боловсруулах үеийн энгийн байдлаар шинжилгээ хийсэн олон тооны нөхцөл байдлыг тодруулахад чиглэсэн бэлтгэл судалгааг сайжруулсан байна. Боломжит газар нутгуудын шинжилгээг багтаасан урьдчилсан ТЭЗҮ-ний зарим нэгэн чухал асуудлыг илүү олон мэдээлэл цуглуулж болох үед ТЭЗҮ-ийн нэг хэсэг болгон гүйцэтгэж болно. Санал болгож буй Орхон говь дэд төслийн хүрээнд ийм арга хэмжээ авах үндэслэл нь найдвартай үр дүн авчрах хангалттай мэдээлийн үндсэн дээр хийж болох дүн шинжилгээ бөгөөд энэхүү дүн шинжилгээ нь УУДБХОД төслийн Гурав дахь бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд гүйцэтгэж байгаа гүний усны үнэлгээний ажилтай бүрэн дүүрэн уялдаж, нэгдэх болно. Нэгдүгээр үе шатны бэлтгэл судалгаа 2013-2014 онд хийгдсэн бөгөөд гуравдугаар үе шатанд хийгдэх урьдчилсан/жинхэнэ ТЭЗҮ болон БОННБҮ-ний нарийвчилсан ажлын даалгавар боловсруулсан. Хоёрдугаар үе шат хараахан дуусаагүй бөгөөд Гуравдугаар үе шатны зөвлөхүүд сонгон шалгаруулах худалдан авах үйл ажиллагаа эхэлсэн. Бүх Үнэлгээ судалгааны хувьд ТУХ болон ДБ-ны шийдвэр журманд тусгагдсан. Нэгдүгээр үе шатны гол зорилго нь – санал болгож буй бүх төслүүд урьдчилсан ТЭЗҮ болон ТЭЗҮ-ний дараагийн шатны судалгааны үе шатыг үргэлжлүүлэх эсэх талаарх шийдвэр гаргахад ТУХ-г шаардлагатай мэдээллээр хангах явдал юм. Санал болгож буй дэд төслүүд Үнэлгээний үе шатыг даван туулсаны дараагаар ТУХ-ноос санал болгож буй дэд төслүүдийг цаашид үргэлжлүүлэх зөвлөмж гаргахдаа ДБ-ны зүгээс ямар нэгэн эсэргүүцэл байгаа эсэхийг нягтлах шаардлагатай юм. Санал болгож буй Шүрэнгийн төслийн судалгааны ажлын хувьд, үндсэн ТЭЗҮ, холбогдох үнэлгээ эхлэх хүртэл урьдчилсан ТЭЗҮ боловсруулах нэмэлт үе шат болон нэмэлт шийдвэр гаргах үе шат нэмэгдэж орсон байна. Түүнчлэн урьдчилсан ТЭЗҮ болон бэлтгэл судалгааны гүйцэтгэлийг бүрэн дүүрэн хэрэгжсэний дараа санал болгож буй Шүрэн, Орхон говь дэд төслүүдийн ТЭЗҮ, БОННБҮ хийх зөвлөмжийг ТУХ-ноос дангаараа гарган 2014 оны 11-р сарын 20-ны өдөр ДБ-д мэдэгдсэн. Иймээс санал болгож буй Шүрэн, Орхон говь дэд төслүүдийн ТЭЗҮ-ийн судалгааны Ажлын удирдамжид ДБ-ны зүгээс ямар нэгэн хориг тавилгүй, 2015 оны 2-р сарын 9, 2015 оны 2-р сарын 25-ны өдөр тус бүрт нь зөвшөөрөл олгосон юм. Орхон говь дэд төслийн судалгааны ажлын хувьд, бэлтгэл судалгааны ажлын гүйцэтгэл дээр нь үндэслэн, ТУХ-ноос урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ боловсруулах үе шатыг</p>
--	---	---

			<p>нэгтгэх зөвлөмж өгсөн байна.</p> <p>Дэлхийн Банкны бодлогын баримт бичигт нийлүүлэх үүднээс санал болгож буй дэд төслүүдийн БОННБҮ-ний ажлын даалгаврыг эцэслэхээс өмнө болон БОННБҮ-ний тайлангийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай юм. Хүсэлтэд дурьдсан Шүрэн болон Орхон говь дэд төслийн судалгааны ажлын БОННБҮ-ний Ажлын даалгаврын төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг одоо явагдаж байна. Улирдлагын зүгээс өнөөдрийг хүртэл Шүрэн болон Орхон говь дэд төслийн алиных нь ч ТЭЗҮ болон БОННБҮ-ний ажил эхлээгүй болохыг нотлон тэмдэглэж байна.</p> <p>Үнэлгээний судалгаанд эрсдэл, болзошгүй БОНН-ийн талаар цаашид судлах шаардлагатайг тодорхойлсон байна. Үнэлгээний судалгааны Ажлын даалгаврын төслийг Дэлхийн Банкны бодлогын баримт бичиг, дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг Банкны аюулгүй байдлын ажилтнууд нягталж, зөвлөгөө өгөн, янзалсан байна. Урьдчилсан ТЭЗҮ болон бэлтгэл судалгаанд оролцсон Зөвлөхүүдийг Дэлхийн Банкны худалдан авах үйл ажиллагааны зааврын дагуу сонгон шалгаруулсан бөгөөд Банкны зүгээс урьдчилан хянасан юм. Банкны санхүүжилтээр ажиллаж буй аливаа зөвлөх нь Хүлээн авагчийг БОННБҮ-г хийхэд дэмжлэг үзүүлэхүйц бие даасан, мэргэшсэн, туршлагатай мэргэжлийн хүн байхыг шаарддаг.</p> <p>Холбогдох яамдууд судалгааны бэлтгэлд хяналт тавихаар байгуулсан ажлын хэсгүүдийн судалгааны бэлтгэл явцад бүрэн оролцож, Ажлын даалгавартай нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.</p> <p>Дээрх хоёр дэд төслийн Үнэлгээний судалгааны бэлтгэл ажил эрт үедээ байгаа тул олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагагүй байв. Хэдий тийм боловч Дэлхийн Банкны зүгээс ТУН-д холбогдор оролцогч талуудтай хамтран ажиллахыг удаа дараа дэмжиж байв. Дэлхийн Банк зарим нэг ТББ-ууд ТЭЗҮ нь аль хэдийн бэлэн болсон хэмээх бодит байдалтай нийцэхгүй мэдээлэлтэй байгааг анзаарсан бөгөөд, Банкнаас ТББ-д хандан энэхүү ойлголтыг өөрчлөхийг эрмэлзэж байгаа болно.</p>
	<i>Байгаль орчны үнэлгээний үйл явц</i>		
7	<p>Усны далангуудын Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийгдэж эхлээгүй.</p> <p>Хэдийгээр ХХГМ байгууллагын шахалтаар Сэлэнгэ мөрний сав газарт ХНҮ-г нэн тэргүүнд хийхээр заасан боловч, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах шатанд эхэлсэн шинж тэмдэг харагдахгүй байна. Үүний зэрэгцээ, усан далангийн 4 төсөл, олон тооны уул уурхайн үйл ажиллагаа Сэлэнгэ мөрний сав газарт идэвхтэй явагдаж байна.</p>	ОР4.01	<p>Удирдлага Дэлхийн Банкны бодлогын баримт бичиг хуримтлалын нөлөөллийг БОННҮ-ний нэг хэсэг болгон хийхийг шаарддаг болохыг тэмдэглэж байна. Тиймээс бэлтгэл буюу урьдчилсан ТЭЗҮ судалгааны ажлын хүрээнд хуримтлагдсан нөлөөллийн шинжилгээ хийгдээгүй боловч БОННБҮ-ний нэг хэсэг болгон гүйцэтгэх болно.</p> <p>Урьдчилсан ТЭЗҮ бэлтгэсэн зөвлөхөд БОННБҮ-ний ажлын даалгавар бэлтгэхийг хүссэн. Энэхүү ажлын даалгавар нь БОННБҮ-д Сэлэнгэ мөрний сав газрын бүх нөлөөллийн бүс багтана гэж заасан байна (дээд, доод урсац, сав газар, Байгаль нуур).</p> <p>Санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн БОННБҮ-ний Ажлын даалгаврын Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хэсгийн В.9 хэсэгт: “Зөвлөх нь нөлөөллийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Сэлэнгэ мөрний дагуух дэд бүтцийг хөгжүүлэх болон Шүрэнгийн УЦС-ын хуримтлагдсан нөлөөллийг авч үзэх хэрэгтэй. Үүнд Сэлэнгэ мөрөн болон Байгаль нуурын бүс нутаг дахь байгаль орчин, нийгмийн</p>

			<p>нөлөөллийн улмаас голын усны урсац, горимд орж болзошгүй хуримтлагдсан нөлөөллийг авч үзнэ. Түүнчлэн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээнд Шүрэнгийн УЦС-ын төслийн хэрэгжилтийн улмаас нийгэм эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдсэнээс үүсэх нөлөөллийг харгалзан үзнэ. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь ирэх 20 жилд Сэлэнгэ мөрний дагуу барихаар төлөвлөсөн бүх ус болон усан цахилгаан станцтай холбоотой дэд бүтцийг хамарсан байх хэрэгтэйгээс гадна бүс нутгийн хувьд наад зах нь Сэлэнгэ мөрний ай саваас доош Байгаль нуур хүртлэх нутгийг хамарсан байна. Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурын ач холбогдолыг авч үзэн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийхдээ RAMSAR, НҮБ-ыг БШУСБ-ын Дэлхийн өвийн төвийн олон улсын конвенцын зарчмыг баримтална.” хэмээн зааж оруулжээ.</p> <p>Орхон говь дэд төслийн БОННБУ-ний Ажлын даалгаврын 4.1 хэсэгт заахдаа: “Санал болгож буй төслийн Орхон гол, Сэлэнгэ Гол болон Байгаль нууранд үзүүлэх нөлөөлөл ба боомт, усанд автагдах газар болон ус дамжуулах шугам хоолойн трассын дагуу үзүүлэх нөлөөлөлийг тодорхойлж тоон байдлаар илэрхийлнэ. Зөвлөх нь төслийн газар нутаг, усанд автагдах газар, Орхон, Сэлэнгэ голын дээд, доод хэсэг, дамжуулах шугам хоолойн дагууд үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлж нөлөөллийг бууруулж эрсдэлээс хамгаалах аргуудыг ДБ-ны Аюулгүйн ажиллагааны бодлого, Монгол улсын хууль дүрэм, олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу тодорхойлно.” гэжээ.</p> <p>Мөн уг баримт бичгийн 4.1.6 заахдаа: “Далангаас доош Орхон гол, Сэлэнгэ мөрний усны чанар, горимийн өөрчлөлтийн нөлөөлөл, сав газарт, Байгаль нуурт нөлөөлөх аливаа нөлөөллийг үнэлсэн байна.” гэсэн байна.</p>
8	<p>Хувилбаруудын талаарх эрдэм шинжилгээний үндэслэлтэй үнэлгээ байхгүй.</p> <p>Урьдчилсан ТЭЗҮ боловсруулах үе шатанд Төвийн эрчим хүчний системд (Шүрэнгийн төслийн хувилбар) нийлүүлэх цахилгаан эрчим хүчний талаарх хувилбаруудын утга учиртай, хараат бус үнэлгээ хийгдээгүй.</p> <p>Ажлын даалгаварт үнэлгээ хийгдэх хувилбаруудын тоог зориудаар хязгаарлаж, хамгийн өрсөлдөх чадвартай хувилбаруудыг хассан.</p> <p>Орхон говь дэд төслийн Ажлын даалгаварт мөн ижил өөрчлөлт оруулж, ус хангамжийн талаар оруулсан зарим нэгэн нөхцөлийг үнэлгээнээс хассан.</p>	<p>ҮАБ4.0 1 ба БЖ4.01 ,</p> <p>Хавсралт А: Усны далан, нөөцлүүрийн төслийн н</p> <p>Үнэлгээний аппликэйшн</p>	<p>Удирдлага Хүсэлт гаргагчийн УУДБХОД төслийн хүрээнд санал болгож буй дэд төслүүдийн үнэлэх, судалгаа хийх хувилбаруудад хийсэн шинжилгээ хангалтгүй байна гэсэн нэхэмжлэлтэй санал нийлэхгүй байна.</p> <p>Удирдлага УУДБХОД төсөл нь томоохон хэмжээний эрчим хүчний дэд бүтцийг барьж байгуулахтай холбогдсон Банкны бодлогын баримт бичиг, дүрэм журам, болон олон улсын шилдэг туршлагыг мөрдөн ажиллаж байгаа болохыг мэдэгдэж байна. Нэгдүгээрт, санал болгож буй дэд төслүүдийн боломжийг үнэлгээ, судалгаа хийсэн, анхны нөхцөлийг цаашид нарийвчлан судлахдаа холбогдох үндэсний хэмжээний мастер төлөвлөгөө, үнэлгээний шинжилгээ, урьдчилсан ТЭЗҮ судалгаа зэрэгтэй уялдуулан харьцуулсан. УУДБХОД Төсөл одоогоор санал болгож буй зургаан дэд төслүүдийн Үнэлгээний судалгаанд дэмжлэг үзүүлж байна.</p> <p>Хоёрдугаарт, Үнэлгээний судалгаа нь санал болгож буй дэд төсөл нэг бүрийн хувилбарын нөхцлүүдийн шинжилгээг цаашид хийж гүйцэтгэнэ. Үнэлгээний үйл явц цааш үргэлжлэхдээ үе шат тус бүрийн хамгийн боломжит нөхцөлийг цааш хөгжүүлэн, илүү нарийн мэдээллийг олж цуглуулан, бусад боломжит хувилбаруудтай харьцуулах болно.</p> <p>УУДБХОД төсөл хэрэгжиж эхлэх үед эрчим хүчний салбарын цөөн тооны судалгаа төлөвлөлтийн шатандаа байсан. Энэ шалтгааны улмаас, УУДБХОД төслийн хүрээнд санал болгож буй дэд төслүүдийг үнэлэх, урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ боловсруулах түвшинд</p>

		<p>судалгаа хийх шаардлагатай болсон юм.</p> <p>Санал болгож буй Шүрэнгийн дэд төсөл. Санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн ТУХ-ны сонголтод үндэслэсэн гол дүн шинжилгээ нь 2010 онд УУДБХОД төслийг эхлэхээс өмнө Эрчим хүчний салбарын төлөвлөгөөнд тулгуурласан бөгөөд завсрын үр дүн, тайлангуудаа 2012-2013 онд гаргажээ. Эрчим хүчний салбарын төлөвлөгөө нь санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн хувилбар нөхцөлүүдийн эх үндэс болсон бөгөөд үнэлгээ, урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ судалгааны үе шатны үеийн харьцуулалт хийхэд цаашид үргэлжлэн ашиглагдах юм.</p> <p>Удирдлага хувилбаруудын үнэлгээ нь Шүрэнгийн судалгааны нэг хэсэг (урьдчилсан ТЭЗҮ судалгааны үед) нэгэн адил хийгдэж байгаа бөгөөд Эрчим хүчний салбарын төлөвлөгөөний зөвлөмжтэй нийцэж байгаа болохыг тэмдэглэж байна. Санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн хоёр үндсэн хувилбар нь Монголд нүүрсээр галладаг цахилгаан станц байгуулах, ОХУ-ын усан цахилгаан станцаас импортлох цахилгаан эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх юм. Энэхүү хоёр хувилбар нь эдийн засгийн үр өгөөж, санхүүгийн өрсөлдөх нөхцөлийн хувьд хамгийн боломжтой хувилбарууд бөгөөд цахилгааны өндөр ачааллыг даван туулахад үзүүлэх нөлөөний хувьд санал болгож буй Шүрэнгийн дэд төсөлтэй ижил хэмжээний чадавхитай төсөл юм.</p> <p>Урьдчилсан ТЭЗҮ судалгаанд эдгээр нөхцөлүүд нь санал болгож буй Шүрэнгийн дэд төсөлтэй харьцуулахад боломжит нөхцөлтэй бөгөөд Сэлэнгэ мөрний сав газарт усан цахилгаан станц байгуулах боломжит байрлалуудыг тодруулсан тусдаа дүн шинжилгээг багтаасан байна. Өөр хоорондоо ялгаатай нөхцөл байдлын (байр зүй, геологи, байгаль орчин болон нийгмийн хүчин зүйлс) улмаас байршил нэг бүрийн шийдлийн үр дүн (усан сангийн хэмжээ, далангийн өндөр гэх мэт), зардал, эрчим хүч үйлдвэрлэх чадамж зэрэг нь өөр өөр байна. Тиймээс эдгээр байрлалуудын нөхцөл, тэр дундаа усан цахилгаан эрчим хүчний хувилбаруудын хамтаар санал болгож буй Шүрэнгийн дэд төсөлтэй харьцуулах нь чухал юм.</p> <p>Эдгээр нөхцөлүүдийн үнэлгээний үр дүнд, урьдчилсан ТЭЗҮ судалгааны явцад хийсэн шинжилгээнд үндэслэн, санал болгож буй Шүрэнгийн дэд төсөл нь Монголд нүүрсээр галладаг цахилгаан станц байгуулах, болон Оросоос эрчим хүч импортлох хувилбаруудтай харьцуулахад өрсөлдөх чадвар өндөртэй харагдаж байна. Эдгээр нөхцлийн үнэлгээ нь санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн цаашдын үнэлгээ, судалгаа хийх явдлыг нэн тэргүүнд авч үзэх Эрчим хүчний салбарын төлөвлөгөөний зөвлөмжийг баталгаажуулж байна.</p> <p>Санал болгож буй Шүрэнгийн дэд төсөл хамгийн боломжит шилдэг байршил, нөхцөлтэй боловч урьдчилсан ТЭЗҮ судалгаагаар тодорхойлсон нь далангийн хэмжээ нь жижиг эсвэл том байх гэсэн хоёр боломжит нөхцөлийг авч үзсэн бөгөөд, гэвч энэхүү шийдлийг Үнэлгээний судалгааны урьдчилсан ТЭЗҮ судалгааны түвшинд цуглуулсан мэдээллийн хүрээнд эцсийн байдлаар ач холбогдлоор нь тодорхойлох боломжгүй байна. Тиймээс, урьдчилсан ТЭЗҮ судалгааны эцсийн зөвлөмж нь дээрх хоёр нөхцөлийн талаарх нарийвчилсан шинжилгээ,</p>
--	--	---

		<p>үнэлгээг багтаасан цаашид үргэлжлүүлэн хийж, аль хувилбар нь илүү байх талаарх мэдээлэл бүхий зөвлөмж гаргах юм. ТЭЗҮ судалгаа болон БОННБҮ-ний Ажлын удирдамжид уг зөвлөмжийг тусган, зөвлөхүүдэд энэхүү асуудалд нухацтай хандахыг шаардах юм.</p> <p>Удирдлага цаашид мэдээллүүд боломжтой болж ТЭЗҮ судалгаа, БОННБҮ-г бүрэн гүйцэт хийгдсэний дараагаар Монгол Улсын Засгийн газар санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн талаарх шийдвэр гаргах болно гэж үзэж байна. Удирдлага санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн хөрөнгө оруулалтын талаар Дэлхийн Банкнаас Монгол Улсад ямар нэгэн амлалт өгөөгүй болохоо дахин онцлон тэмдэглэж байна.</p> <p>Санал болгож буй Орхон говь дэд төсөл. УУДБХОД төслийн хүрээнд судалгаа хийхээр сонгогдсон санал болгож буй Орхон говь дэд төсөл нь Монгол орны Өмнийн говийн бүс нутаг дахь усан хангамжийг урт хугацаанд хангах бололцоо олгох, усан цахилгаан станцын хавсарга үйлдвэрлэл явуулах боломж олгох зэрэг олон төрлийн зорилготой төсөл юм. Энэ нь Орхон голын усны эрчим хүчийг ашиглах боломжтой гэдгийг тодорхойлсон Эрчим хүчний салбарын төлөвлөгөөтэй уялдаж байгаа тэргүүлэх ач холбогдолтой төсөл болно.</p> <p>Говийн бүс нутаг дахь 2010 онд хоногт 50,000 м³ байсан усны хэрэгцээ 2020 онд 350,000 м³ болон эрс нэмэгдэх болно гэсэн тооцоог УУДБХОД төсөл эхлэхээс өмнө хийж байжээ. Гэвч энэ үед энэ бүс нутгийн газрын доорх усны боломжит нөөцийн хэмжээ тодорхой бус байлаа. Зарим нэгэн тоон мэдээлэл сөхвөл, 2009 оны ЖДҮС-д газрын доорх усны нөөц 2020 он хүртэлх хэрэгцээг хангахад хүрэлцээтэй боловч, урт хугацааны хэрэгцээг дан гүний усаар хангах боломжгүй учраас ирэдүйд Орхон гол зэрэг эх үүсвэрээс гадаргын усыг татаж шилжүүлэх шаардлагатай болно.</p> <p>Энэхүү учир шалтгааны улмаас санал болгож буй Орхон говь дэд төслийн бэлтгэл судалгаа хийхээр шийдсэн нь чухал байсан бөгөөд бүс нутаг дахь боломжит гүний усны эх үүсвэр, усны хэрэгцээнд анхаарлаа хандуулах анхны боломж олгосон юм. Шинжилгээнд дурьдахдаа: 1) Говийн бүс нутаг дахь гүний усны чухал эх үүсвэрүүд нь дарагдмал ¹⁵ учраас хөрсний усны түвшинд нөлөөлөхгүйгээр ашиглах боломжгүй, 2) 2020 он гэхэд усны хэрэгцээ боломжит гүний усны нөөцөөс давна, 3) Гүний усны талаарх судалгаа хийж, яаралтай мэдээлэл цуглуулах шаардлагатай байна.</p> <p>Энэхүү дүн шинжилгээ нь санал болгож буй Орхон говь дэд төслийн цаашдын шинжилгээг хийхийн чухал байдлыг ойлгуулахад дэмжлэг үзүүлэн, говийн бүсийн усны хэрэглээг гадаргын усны эх үүсвэрээр хангах (гүний усны эх үүсвэрт найдахаас илүүгээр) анх төсөөлж байснаас илүү яаралтай чухал болохыг харуулж байна. Говийн бүсийн хөрсний усны эх үүсвэрийн үр ашигтай, тогтвортой менежмент чухал хэрэгцээтэй байгаа учраас Австралийн Засгийн газрын DFAT байгууллагын санхүүжилтээр төслийн усны нөөцийн менежментийн бүрдэл хэсэг (3-р</p>
--	--	--

¹⁵ Дарагдмал усны нөөц гэдэг нь маш олон жилийн өмнө бий болж хадгалагдсан битүүмжлэгдсэн усны давхрага бөгөөд нөхөн сэргээгдэхгүй.

			<p>бүрдэл хэсэг)-ийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн нь амжилттай хэрэгжиж байна.</p> <p>Орхон говь дэд төслийн судалгааны ажил хийгдэхийн зэрэгцээ, санал болгож буй дэд төслийн усан хангамжийн өөр эх үүсвэрийн хувилбаруудад үнэлгээ хийж, Монгол орны эрчим хүчний эх үүсвэрийн хувилбар гэдэг талаас нь харж байна. Түүнчлэн, Орхон гол хаана оршдог, аль маршрутаар ус зөөвөрлөх, усны хэрэгцээ говийн аль хэсэгт нэн тэргүүнд шаардлагатай байгаа зэрэг энэхүү дэд төсөлд холбогдох нарийн төвөгтэй байдлыг тодруулах шаардлагатай учраас урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ судалгааны ажлын үе шатнаас өмнө санал болгож буй Орхон говь дэд төслийн бэлтгэл судалгааны ажил хийгдсэн байна. Бэлтгэл судалгааг үнэлгээний үе шатны зэрэгцээ явуулсан Удирдлага оновчтой арга болсон гэж үзэж байна.</p> <p>Бэлтгэл судалгаа нь Говийн бүс нутаг дахь өөр хоорондоо ялгаатай ирээдүйн усны хангамжийн хувилбаруудыг харьцуулан үзсэн бөгөөд Орхон голоос гадаргын усыг хоолойгоор үндсэн хэрэгцээт газар хүргэх болон говийн өөрийн хөрсний усны эх үүсвэрийн ашиглалтыг хослуулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд хамгийн боломжит хувилбаруудын усны нөөц, технологийн боломж, анхан шатны санхүү эдийн засгийн шинжилгээ, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн асуудлуудыг авч үзсэн байна.</p> <p>Энэхүү бэлтгэл судалгааг санал болгож буй Орхон говь дэд төслийн урьдчилсан болон жинхэнэ ТЭЗҮ судалгааны ажлын даалгавар боловсруулахад ашиглан, бага болон өндөр хэрэгцээт гэсэн хувилбарууд Орхон голын нэмэлт усаар хангах тоо хэмжээ, цаг хугацааг тодорхойлоход тусалсан байна. Ирээдүйн уул уурхайн хөгжил нь боломжит усны нөөцтэй болох цаг хугацаа, тоо хэмжээний асуудлаас шалтгаалах учраас ТЭЗҮ-ийн судалгаа нь бага болон их усан хангамжтай байх гэсэн нөхцөл байдлаар мөн авч үзэх хэрэгтэй.</p> <p>Удирдлага санал болгож буй Орхон говь дэд төслийн хөрөнгө оруулалтын талаар Дэлхийн Банкнаас Монгол Улсад ямар нэгэн амлалт өгөөгүй болохоо дахин онцлон тэмдэглэж байна.</p>
	<i>Дэлхийн өв ба Ус намгархаг газрын жагсаалт</i>		
9	<p><i>Дэлхийн өвийн хүсэлтэд зүй бус хандаж байна</i></p> <p>Дэлхийн өвийн хороо Монгол Улсын Засгийн газарт 2013, 2014 онд хоёр удаа хандсан. Монгол Улс хариу өгөхдөө хугацаа алдаж, 2013 онд ДӨХ-ны шаардлагад нийцээгүй байна.</p> <p>Одоогоор Монгол Улсын Засгийн газар орос зөвлөх авч ажиллуулахаар оролдож байгаа нь оросын талын орон нийтийн оролцооны нэг хэлбэр гэж бусдад</p>	ОР 7.50 Олон улсын усан замын төсөл	<p>Удирдлага УУДБХОД төсөл Хүлээн авагч талын байгаль орчны холбогдолтой олон улсын гэрэ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг БОННБУ-д тодорхой авч үзнэ гэдгийг онцлон заахыг хүсч байна. Дэлхийн Банк нь БОННБУ-ээр тодорхойлсон Хүлээн авагчийн хүлээн эрх үүргийг зөрчсөн аливаа санал болгож буй төсөл, зөвлөмжийг санхүүжүүлдэггүй юм. Рамсар сайт (Сэлэнгэ мөрний бэлчир), Дэлхийн өвийн сайт (Байгаль нуур) зэрэг нь БОННБУ-ний Ажлын зааварт тусгайлан орсон байна. УУДБХОД төсөл санал болгож буй зургаан төслөөс Шүрэн, Орхон говь дэд төслүүд нь Дэлхийн Банкны Үйл ажиллагааны бодлогын баримт бичгийн 7.50 заалтад хамаарна. Санал болгож буй энэхүү хоёр төсөл нь ОХУ-ын нутаг дэвсгэрт орших дэлхийн хамгийн том, гүн цэнгэг уст Байгаль нуурт цутгадаг Сэлэнгэ мөрний цутгал учраас хил дамнасан нөлөөлөл үзүүлэх боломжтой юм.</p> <p>Үйл ажиллагааны бодлогын баримт бичгийн 7.50 нь дараах төслүүдэд хамаарна, үүнд: а) олон улсын усан замын</p>

	<p>итгүүлэхийг хичээж байна.</p> <p>Одоогийн байдлаар Орос улсад ямар нэгэн нээлттэй зөвлөлгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулагдахаар төлөвлөгдөөгүй байна.</p> <p>Шүрэн болон Орхон говь дэд төслийн БОННБҮ-ний ажлын даалгавар боловсруулах ажлыг ДӨХ-ны ажлын хэсэг Монгол орон ирж ажиллан, зөвлөмж боловсруулахаас өмнө хийсэн.</p>		<p>хэрэглэх буюу бохирдуулж болзошгүй, б) энэ төрлийн төслүүдийн нарийвчилсан дизайн, инженерийн судалгаа. Эдгээр төслүүдийн хувьд, тухайлан шаардлага тавьсанаас бусад тохиолдолд голын эрэг дээрх бүх талуудад мэдэгдэл хүргүүлэх ёстой. Банкны бодлогын баримт бичигт гурван тохиолдлыг дурьдсан байдаг нь хэрэв төсөл нь зөвхөн усны эх үүвэрийн судалгаа, ТЭЗҮ судалгааг санхүүжүүлж байгаа тохиолдолд төслийг санхүүжүүлнэ хэмээн Бодлогын бичгийн 7 (b)-д заасан байна. Энэ тохиолдолд Ажлын даалгаварт аль нэгэн болзошгүй талын асуудлыг хянах шаардлага тавигдана.</p> <p>Төслөөс санхүүжүүлэхээр зорьсон үйл ажиллагаанд оролцуулан, Удирдлага ҮАБ 7.50-д заасан УУДБХОД төслийн мэдэгдлийн шаардлагыг 2013 оны 8-р сарын 28-нд баталсан. Бодлогын баримт бичигт заасанчлан дээрх хоёр дэд төслийн БОННБҮ-ний Ажлын даалгаварт аливаа болзошгүй сав газрын асуудлыг оруулсан байна.</p> <p>Удирдлага МУЗГ-аас санал болгосон Шүрэн, Орхон говь дэд төслүүдийн талаар хоёр талын харилцааны шугамаар Оросын эрх баригчидтай харилцаж байгааг тэмдэглэж байна. Нэгдүгээрт 2014 оны 6-р сарын 20-ны өдөр Дэлхийн Банкнд ирүүлсэн албан бичигт дурьдсанаар Монгол Улсын Засгийн газраас санал болгож буй төслүүдийн талаарх мэдээллийг ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яаманд хүргүүлсэн байна. Хоёрдугаарт, 2014 оны 8-р сарын 21-ний өдөр Монгол Улсын Эрчим хүчний яам Оросын шинжлэх ухааны академитай “байгаль орчин, ус, эрчим хүчний үнэлгээ судалгаа, Монгол орны Сэлэнгэ мөрний сав газарт байгуулах усан цахилгаан станц барихтай холбогдсон нийгэм эдийн засгийн үр дагаврыг судлах талаар хамтран ажиллах тухай” хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна. Гуравдугаарт, Удирдлага Сэлэнгэ мөрний сав газарт усан цахилгаан станц байгуулах асуудлын талаар 2014 оны 8-р сард ОХУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр тал ярилцсан талаар олон нийтэд мэдээлснийг тэмдэглэж байна. Дөрөвдүгээрт, 2015 оны 3-р сарын 30-31-ний өдрүүдэд ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн дэд сайдаар ахлуулсан төлөөлөгчид Улаанбаатар хотноо ажиллаж Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгтэй уулзаж ярилцсан байна. Уулзалтын үеэр Шүрэнгийн үнэлгээний судалгааны талаар хоёр яам хамтран ажиллах тухай протоколд гарын үсэг зурсан байна.</p> <p>Байгаль нуур, Сэлэнгэ мөрний намгархаг газар нутаг нь Дэлхийн өвийн конвенц¹⁶ болон Ramsar конвенцоор¹⁷ тус тус хамгаалагдсан. Дэлхийн Банк эдгээр газруудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд УУДБХОД төслийн хэрэгжилтийн явцад МУЗГ-ын олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн үйл ажиллагаанд мониторинг хийж байна. Дэлхийн Банк ЮНЕСКО-гоос тавьсан хүсэлтийн дагуу Сэлэнгэ мөрний сав газрын талаар баримталж байгаа төлөвлөгөөнийхөө талаар тайланг Катар улсын Доха хотноо 2014 оны 6-р сарын 15-25-ны хооронд зохион байгуулагдсан Дэлхийн өвийн хорооны 38 дахь</p>
--	--	--	--

¹⁶ Байгаль нуур нь Дэлхийн өйд 1996 онд бүртгэгдсэн.

¹⁷ Сэлэнгийн адгийн намгархаг газар Ramsar-ын олон улсын намгархаг газрын бүртгэлд 1994 онд бүртгэгдсэн

		<p>удаагийн хуралд танилцуулан үүний дагуу Дэлхийн өвийн хорооны 38 СОМ 7В.76 тоот шийдвэр гарсныг тэмдэглэж байна. Банкнаас тавьсан хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн Газар 2014 оны 6-р сарын 20-ны өдөр Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүрэгтэй холбогдох үйл ажиллагааны тайланг бичгээр ирүүлсэн. Энэхүү албан бичигт Монгол Улс, Дэлхий өвийн хороо хооронд харилцсан албан бичгүүдийн хуулбарыг хавсаргасан байна.</p> <p>Эдгээр мэдээллийг тоймлон үзээд, Удирдлага УУДБХОД төслийн хүрээнд санал болгож буй Шүрэн, Орхон говь дэд төслүүд нь байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийг зохих ёсоор үнэлгээ хийн, эдгээр үнэлгээний үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж, дэд төслүүдийг цаашид үргэлжлүүлэх шийдвэр гаргаж байх тухай Дэлхийн өвийн сангийн 38 СОМ 7В.76 дугаар шийдвэртэй нийцэж байна хэмээн дүгнэж байна. Удирдлага Дэлхийн өвийн хорооны зөвлөмж нь Дэлхийн Банкны Аюулгүй ажиллагааны бодлоготой нийцэж байгааг тэмдэглэж байна.</p> <p>Удирдлага Хүсэлт гаргагчаас Сэлэнгэ мөрний сав газарт усан цахилгаан станц байгуулагдахтай холбогдон гарах боломжит хуримтлагдах нөлөөллийн талаарх саналыг хуваалцаж байгаа бөгөөд, УУДБХОД төсөл нь хуримтлагдах нөлөөллийн үнэлээг санал болгож буй Шүрэн, Орхон говь дэд төслүүдийн БОННБҮ-ний нэг хэсэг болгон гүйцэтгэх болохыг онцолж байна.</p> <p>Удирдлага хил дамнасан байдлаас үүсэх асуудлын талаарх шаардлага, Байгальд нуурт үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар Шүрэн, Орхон говь дэд төслийн БОННБҮ-ний Ажлын даалгаврын төсөлд тодорхой оруулсан болохыг тэмдэглэж байна.</p> <p>Шүрэнгийн УЦС-ын БОННБҮ-ний ажлын даалгаварт орсон зарим нэг жишээг дурьдвал:</p> <p>В.2, В4, В4.1, В4.3 хэсэгт Зөвлөх нь санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн хүрээнд Сэлэнгэ мөрөн дээр хаалт бий болгосноос үүдэн байгалийн амьдрах орчны хэсэгчлэн хуваагдал, зэрлэг амьтдын нүүдлийн зам (загас өнгөрүүлэх байгууламж), газрын хөрс дээрх ургамалд нөлөөлөх хохирол болон газрын доройтлын хэмжээ зэрэг сөрөг нөлөөллийг тодорхойлох.</p> <p>Түүнчлэн В.9 хэсэгт: “Зөвлөх нь нөлөөллийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Сэлэнгэ мөрөний дагуух дэд бүтцийг хөгжүүлэх болон Шүрэнгийн УЦС-ын хуримтлагдсан нөлөөллийг авч үзэх хэрэгтэй. Үүнд Сэлэнгэ мөрөн болон Байгаль нуурын бүс нутаг дахь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн улмаас голын усны урсац, горимд орж болзошгүй хуримтлагдсан нөлөөллийг авч үзнэ. Түүнчлэн хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээнд Шүрэнгийн УЦС-ын төслийн хэрэгжилтийн улмаас нийгэм эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдсэнээс үүсэх нөлөөллийг харгалзан үзнэ. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь ирэх 20 жилд Сэлэнгэ мөрний дагуу барихаар төлөвлөсөн бүх ус болон усан цахилгаан станцтай холбоотой дэд бүтцийг хамарсан байх хэрэгтэйгээс гадна бүс нутгийн хувьд наад зах нь Сэлэнгэ мөрний ай саваас доош Байгаль нуур хүртлэх нутгийг хамарна хэмээн зааж оруулжээ. Төгсгөлд нь Ажлын даалгаварт хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг хийхдээ RAMSAR, НҮБ-ын БШУСБ Дэлхийн өвийн</p>
--	--	--

			<p>төвийн олон улсын конвенцын зарчимыг баримтлах талаар тусгажээ.</p> <p><i>Орос дахь зөвлөлдөх уулзалт</i></p> <p>Удирдлага Хүсэлт гаргагчаас Орос дахь төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг хамруулсан зөвлөлдөх уулзалт хийж байгаагүй гэсэн нотолгоо гаргасныг хүлээн зөвшөөрөхгүй байна. БОННБУ-ний Ажлын даалгаврын төсөлд Зөвлөхүүд нь санал болгож буй төслүүдийн хамрах бүс нутгийн оролцогчдын газар зүйн байрлалын зураглалыг үйлдэн, өртөж болзошгүй иргэдтэй уулзах ярилцлагын төлөвлөгөө гаргах талаар заасан. Энэхүү төлөвлөгөөний нэг хэсэг нь доод урсацын дагуу суух төсөлд өртөх улсын хилийн цаана амьдрах иргэдтэй хийх уулзалт байхыг шаардсан байна.</p> <p>Мөн Оросын Шинжлэх ухааны академийн төлөөлөл оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтад оролцсоныг тэмдэглэх нь чухал бөгөөд, санал болгож буй Шүрэнгийн дэд төслийн доод урсацын хэсэгт үзүүлэх болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг 2015 оны 1-р сарын 16-ны өдөр Улаанбаатар хотноо болсон Шүрэнгийн талаарх олон нийтийн мэдээллийн уулзалтаар танилцуулсан байна. Түүнчлэн, санал болгож буй Шүрэн, Орхон говь дэ төслүүдийн БОННБУ-ний Ажлын даалгаврын засвар оруулсан төслийг орос хэлнээ хөрвүүлсэн бөгөөд Оросын Байгалийн баялаг, байгаль орчны яаманд санал авахаар хүргүүлсэн байна.</p>
	Зөвлөлдөх уулзалт ба тодруулга		
10	<p>2014 оны 11-р сарын 21-ний өдөр Багануур болон Таван толгойн уурхайн Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний Ажлын даалгаврын талаарх хэлэлцүүлэг зохион байгуулсан боловч, зохион байгуулалт муутай (оролцогчдод өмнөх өдөр нь мэдэгдсэн) үйл ажиллагаа нь тодорхой бус байсан. Оролцогчдын гаргасан саналыг эдгээр Ажлын даалгаврыг цаашид боловсруулахдаа хэрхэн тусгах нь бүрхэг болсон.</p>	<p>Мэдээллийн бодлогын хэрэглээ ба аюулгүй бодлого</p> <p>ОР4.01, ОР4.04, ОР4.11, ОР4.10, ОР4.12.</p>	<p>Удирдлага Багануур, Таван толгойн уурхайн БОННБУ-тэй холбогдуулан Улаанбаатар хотноо зохион байгуулсан ТУН-ийн менежментийн асуудлыг хөндөж байгааг тэмдэглэж байна. Энэхүү зөвлөлдөх уулзалт нь ТУН-ийн хувьд олон нийтийн уулзалт зохион байгуулах анхны туршлага болсон. Хил хязгааргүй гол мөрөн байгууллагаас 2014 оны 11-р сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан зөвлөлдөх уулзалтын үеэр ТУН-ээс уулзалтын үеэр саналаа хэлэх хангалттай цаг гаргаж өгөөгүй гэдгийг Банкны ажлын хэсэгт анхааруулсан. Банкны ажлын хэсгээс энэ байдлаа нэн даруй засахыг ТУН-д мэдэгдсэн. ТУН энэ асуудлыг хариуцлагатайгаар хүлээн авч санал хүлээн авах эцсийн хугацааг 2014 оны 11-р сарын 28 байсныг 12-р сарын 5 болгон сунгасан байна.</p> <p>Удирдлага БОННБУ-ний Ажлын даалгаврыг эргэн нягталж, олон нийтэд түгээн ашиглаж болохоор болсныг тэмдэглэж байна. Мөн Банкны зүгээс ТУН-ийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах гүйцэтгэлийн чанар анхны олон нийтийн уулзалтаас хойш сайжирч байгааг анзаарсан болно. ТУН-ээс санал хүлээн авахад хангалттай хугацаа олгон (тухайн арга хэмжээнээс нэг сарын өмнө мэдээллийг олон нийтэд хүргэн, жишээ нь Шүрэнгийн БОННБУ-ний Ажлын даалгаврыг танилцуулснаас хойш хоёр долоо хоногийн турш саналыг бичгээр хүлээн авсан гэх мэт) ирүүлсэн саналуудыг хэрхэн тусгаснаа “хариу матрикс” зарчмаар Засвар хийсэн Ажлын удирдамжийн хамтаар түгээж байна. Санал болгож буй Шүрэн, Орхон говь дэд төслүүдийн аль алины хариу матриц одоогоор ТУН-д төслийг нь боловсруулж байна. Өмнөх 9-р зүйлд</p>

			<p>өгүүлсэнчлэн, Ажлын даалгаврыг орос хэлэнд хөрвүүлэн Оросын холбогдох албаны саналыг Ажлын даалгаврын эцсийн хувилбарт тусгахаар болсон байна.</p> <p>Банкны зүгээс ТУН-д олон нийтийн уулзалтанд бэлтгэх, зохион байгуулахад туслах харилцаа холбооны асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулан, Төслийн цахим хуудсыг сайжруулан илүү их мэдээлэл хуваалцах хэрэгсэл болгох зөвлөмж өгсөн.</p> <p>Мөн Банкны зүгээс ТУН, ТУХ-г усан цахилгаан станц, байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр туршлагатай хүмүүсээс бүрдсэн Шинжээчийн баг бүрдүүлэхийг зөвлөсөн болно. Бүх мэргэжилтнүүдийн Ажлын даалгавар эцэслэн батлагдаад сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа явагдаж байна.</p>
11	Сүүлийн 2 жил хагасын хугацаанд Монгол, Орост зохистой мэдээлэл түгээх, зөвлөлдөх уулзалт зохион байгуулаагүй	Мэдээллийн бодлогын хэрэглээ ба аюулгүй бодлого ОР4.01, ОР4.04, ОР4.11, ОР4.10, ОР4.12.	<p>Удирдлага ТУН-ийг нээлттэй болгох, баримт бичигт зохистой зөвлөгөө өгөх Хүсэлт гаргагчийн сонирхлыг хуваалцаж байна. УУДБХОД төслийн нэг үр дүн нь оролцогч талуудыг татан оролцуулж МУЗГ-ын чадавхийг бий болгох явдал тул энэ нь олон нийтийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулан, холбогдох баримт бичгийн талаар өргөн цар хүрээтэй санал шүүмжлэл авдаг болсны үр дүн бий болно.</p> <p>Банкны зүгээс нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд, орон нутгийн ТББ-д чиглэсэн ач холбогдолтой, цагаа олсон уулзалт хийх иж бүрэн зөвлөлдөх уулзалтын төлөвлөгөө (хавсралт 3-д байгаа Олон нийтийн хэлэлцүүлэг хэсгийг үзнэ үү) боловсруулахад ТУН-ийг дэмжиж байна.</p> <p>2014 оны 11-р сараас хойш, гурван томоохон олон нийтийн хэлэлцүүлэг (2014 оны 11-р сарын 21-ний өдөр Багануур дэд төсөл, 2015 оны 1-р сарын 16-ны өдөр Шүрэнгийн дэд төсөл, 2015 оны 1-р сарын 29-нд Орхон говь дэд төсөл), оролцогч талуудад зориулсан нэг сургалт семинар (2015 оны 1-р сарын 13) Улаанбаатар хотод зохион байгуулав. Эдгээр үйл ажиллагаа нь Дэлхийн Банкны бодлогын баримт бичгийн хүрээнд сайн практик болсон бөгөөд ТББ, байгаль орчин болон нийгмийн салбарын өмгөөлөгчид, тусгай сонирхлын бүлгүүд, нөлөөлөлд өртөж болзошгүй дөрвөн сумын Засаг дарга нар орон нутгийн захиргааны ажилтнууд болон хувийн хэвшлийн төлөөлөл идэвхтэй хамрагдсан байна. Үйл ажиллагааны өмнө болон дараа нь баримт бичигт холбогдох санал, хүсэлт хүлээн хугацааг хангалттай оруулж өгсөн. ТУН-ээс цаашдын хэлэлцүүлгийн үйл ажиллагаагаа сайжруулах үүднээс оролцогчдын саналыг хүлээн авах болсон.</p> <p>Банкны бодлогод энэ төрлийн анхан шатны зөвлөлдөх уулзалт нь “санал болгож буй төслийн зорилт, тодорхойлолт, болзошгүй нөлөөл” зэргийг багтаасан (ОР4.01, 16-р зүйл) хураангуй тараахыг шаарддаг боловч, ТУН-ийн хувьд үүнээс илүүгээр БОННБҮ-ний Ажлын даалгаварт дэлгэрэнгүй санал өөрсдөө санаачлан авдаг болсныг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр саналыг нэгтгэн хариу матриц болгодог байна. (дээрх 10-р зүйлээс үзнэ үү) Зөвлөлдөх ярилцлагын үеэр санал хүлээн авахад анхаарлаа хандуулж, ТУН-ээс цаашдын үйл ажиллагаа сайжруулахад ашигладаг байна.</p> <p>ТУН мөн Үнэлгээ судалгаа хийх эхний үе шатанд зөвлөлдөх, түгээх үйл ажиллагаагаа сайжруулан нотолгоо үзүүлэв. Банк цаашид Үнэлгээ судалгааны үйл ажиллагаар</p>

			дамжуулан аливаа нэгэн алдаа дутагдлаа засч залруулж байгаа эсэх талаар ТУН-тэй ойр нягт хамтран ажиллагаагаа үргэлжлүүлэх болно.
